

Лиахоно



**Иохан бол төлөөлөгч,
илчлэгч, гэрч, 18-р хуудас**

Шавь байх талаарх Мариагийн түүх,
12-р хуудас

Оролдож үзэх итгэл ба үйлдэх итгэл,
24-р хуудас

Иосеф Смит бол Бурханы болон хүмүүний
хуулийн суралцагч, 28-р хуудас

ЭНЭ САРД ШИНЭЭР

**ХҮҮХДҮҮДЭД
ЗОРИУЛСАН ХЭСГИЙН
НАЙЗ ХЭМЭЭХ ШИНЭ
СЭТГҮҮЛИЙГ
ХҮҮХДҮҮДТЭЙ
ХУВААЛЦ.**

СҮМ ЭНД
БАЙГУУЛАГДЛАА

Япон

Токио





Японы Токио дахь Янака оршуулгын газарт хожмын үеийн гэгээнтэн Сайтосын гэр бүлийнхэн гэр бүлийнхээ дурсгалын хөшөөг эргэж ирдэг. Тэдний хувьд энэ нь санан дурсах газар бөгөөд гэр бүл мөнхөд хамт байж болно гэсэн сайн мэдээний мэдлэг үүнийг улам бүр ариун нандин болгосон юм.

Гэр бүл, өвөг дээдсээ эрхэмлэн дээдлэх нь япончуудын соёл уламжлалд гүн гүнзгий шингэсэн байдаг ба ард түмэн нь одоо Токио (1980 онд онцгойлон адислагдсан, одоогоор засварт орсон Азийн анхны ариун сүм), Фукуока (2000 онд онцгойлон адислагдсан), Саппоро (2016 онд онцгойлон адислагдсан) гээд гурван ариун сүмээр адислагдсанд Японы хожмын үеийн гэгээнтнүүд баяртай байна. Мөн Японд 64 ХҮГ гэр бүлийн түүхийн төв байдаг.

Тухайн үед Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн байсан бөгөөд сүүлд Сүмийн долоо дахь ерөнхийлөгч болсон ахлагч Хибэр Ж.Грантаар (1856–1945) удирдуулсан номлогчид 1901 онд анх Японд иржээ. Өнөөдөр Японд бараг 261 цуглаанд цуглардаг 130 мянга шахам гишүүн бий.

- Мормоны Номыг анх япон хэл дээр орчуулахад 5 жилийг зарцуулж, 1909 онд дуусгажээ. Орчуулгыг дахин хянаж, 1957 онд хэвлэн гаргасан.
- Азийн анхны цуглааны байрыг 1964 онд Японд онцгойлон адисалсан.
- Япон гаралтай ерөнхий эрх мэдэлтнүүдэд Хавайд төрсөн Адний Я.Камацү (1923–2011), Хавайд төрсөн Сэм К.Шимабукуро (1925–2015); чөлөөнд гарсан Ёшихико Кикүчи; чөлөөнд гарсан Койчи Аяожи болон Такаши Уада; Казүхико Ямашита нар орно.



Шавь байх

Бидний амьдардаг дэлхий бидний хэр үнэнч шавь бэ гэдгийг сориход зориулагдсан мэт. Энэ жил биднийг Шинэ Гэрээг судалж байхад Есүс Христийн болон Эзэнээсээ суралцаж, Түүнтэй адилхан болохыг хичээдэг байсан шавь нарынх нь сургаал, үлгэр жишээ сүнсээр өдөөх болно.

Бригам Янгийн Их сургуулийн Шинэ Гэрээний багш нар болох миний анд Гай Стратам бид хоёр Их Эзэний эх Мариа (12-р хуудас), хайрт Иохан хоёроос (18-р хуудас) олж харсан шавь байх загварын талаарх зарим бодол дээр санаа нийлдэг. Энэ хоёр хүн Есүс Христийн хамгийн агуу гэрчүүдийн дунд байсан. Бурхан Эцэгээс гадна Есүс бол үнэхээр Бурханы Хүү гэдгийг Түүний эхээс өөр хэн ч илүү сайн мэдэхгүй байсан бөгөөд Иохан бол анхны Арван хоёрын дунд байсан төдийгүй Их Эзэний ойр дотно найзуудын нэг байсан бололтой.

Энэ хоёрын болон бусад шавийнх нь үнэнч байдал бидэнд хэрхэн өөрсдөө Есүс Христийн хайртай шавь нар болж, дэлхийн саад бэрхшээлийг үл харгалзан шавь хэвээр байж болохыг заадаг.


Бид Шинэ Гэрээг залбирч судалснаар Есүсийн талаар илүү ихийг суралцахын зэрэгцээ Түүнийг илүү сайн мэддэг болдог (Иохан 17:3-ыг үзнэ үү).

Хүндэтгэсэн,
Эрик Д.Хантсман



Бошиглогч
Иосеф Смитийн
гайхамшигт зорилго
Ерөнхийлөгч
Даллин Х.Өүкс


28



Есүсийн хайртай
шавь Иохан

Эрик Д.Хантсман



18



Есүсийн
эх Мариа

Гай Стратэм

12



Тохинууллын
зарчмууд:
Тохинууллыг
өөрчлөх бидний
зорилго

8

- 5 **Шинэ Гэрээн дэх бэлгэдлүүд** ☪
Бид Шинэ Гэрээн дэх эд зүйлс, соёл, түүх, газар зэргээс утга санааг олж болно.
- 6 **Итгэлийн хөрөг: ☪**
Фан Фон—Камбож, Пномпень
Гал гарсны дараа бид өвдөг сөгдөн залбирч, арга замыг заан, шинэ гэр орон олоход туслан адислахыг Их Эзэнээс хүссэн юм.
- 8 **Тохинууллын зарчмууд:**
Тохинууллыг өөрчлөх бидний зорилго
Бид тохинуулахдаа хүмүүсийг Христэд авчрахын тулд олон зүйлийг хийх боломжтой.
- 12 **Есүсийн эх Мариа**
Гай Стратэм
Мариагийн итгэл, үнэнч байдлаас сурах зүйл бидэнд их бий.
- 18 **Есүсийн хайртай шавь Иохан**
Эрик Д.Хантсман
Төлөөлөгч Иоханы адил бид Есүс Христийн хайртай шавь болж болно.
- 24 **Итгэлийн хоёр түвшин**
Ахлагч Вилфорд В.Андэрсэн
Итгэл гэдэг нь үйлдэхээс гадна Бурханы хүсэлтэй өөрсдийн хүслийг нийцүүлэхийг хэлнэ.
- 28 **Бошиглогч Иосеф Смитийн гайхамшигт зорилго**
Ерөнхийлөгч Даллин Х.Өүкс
Харсан гэрчүүд болон хуулийн баримт бичгүүд бидэнд Иосефын зан чанарыг мөн түүний амьдралынхаа туршид хийж гүйцэтгэж чадсан зүйлсийг ойлгоход тусалдаг.
- 38 **Хожмын үеийн гэгээнтнүүдийн дуу хоолой** ☪
Сониrhoгчид модноос бууж ирнэ; Бурханы үгэн дээр найрлах; мөнгө олох; итгэлээр халдаг зуух.

☪ Богино өгүүллүүд



Хавтсан дээр
Карл Хэйнрих Блок,
Сүүлчийн зоог

Хэсгүүд

Залуучуудад зориулав

42

Сэтгэцийн болон сэтгэл санааныхаа эрүүл мэндэд анхаарлаа хандуулах нь **тэнцвэртэй, баяр баясгалантай амьдрахад** амин чухал. Сэтгэл санааны хувьд бие даах тухай өгүүлсэн энэ сарын нийтлэлтэй танилцана уу.



Өсвөр үеийнхэнд зориулав

50

Өөрийнхөө үнэ цэнийг ойлгож, **Дөрвөн чухал талаараа Аврагчтай адил болж өсөн хөгж. 2019 оны Мючелийн сэдвийг судалж байхдаа** Тэнгэрлэг Эцэгт хайраа үзүүлэх нь хэрхэн таныг аз жаргалтай болгохыг олж мэд.



Хүүхдүүдэд зориулав

Хүүхдүүдэд зориулсан хэсэг бие даасан Найз нэртэй сэтгүүлтэй боллоо!

Энэ нь хүүхдүүдэд зөвхөн тэдэнд зориулсан итгэлийг хөгжүүлэх түүхүүдийг өгнө гэж найдаж байна. Хэрэв танай гэрт хүүхэд байхгүй бол тойрог, салбар, хөршийнхөө хүүхдэд шинэ *Найз* сэтгүүлийг авч өгнө үү.



ИЛҮҮ ИХИЙГ ОЛЖ МЭД

Та Gospel Library аппликэйшн болон comefollowme.lds.org вэбсайт дээр дараах зүйлсийг хийж болно.

- Сэтгүүлийн энэ дугаарыг ол.
- Зөвхөн цахим хувилбарыг ол.
- Өмнөх дугааруудыг хай.
- Өөрийн түүх, санал зөвлөмжийг илгээ.
- Сэтгүүл захиал эсвэл бусдад захиалж өгч, бэлэглэ.
- Цахим хэрэгслийн тусламжтайгаар илүү сайн суралц.
- Таалагдсан нийтлэл, видео бичлэгээ хуваалц.
- Дуртай нийтлэлүүдээ татаж аван, сонс мөн хэвлэж ав.

БИДЭНТЭЙ ХОЛБОО БАРИХ

Асуулт, санал зөвлөмжөө liahona@ldschurch.org хаяг руу э-мэйлээр илгээнэ үү.

Итгэлийг тань хүчирхэгжүүлсэн түүхийг liahona.lds.org вэбсайт руу илгээ эсвэл доорх хаягаар шуудангаар ирүүлнэ үү:

Liahona, floor 23

50 E. North Temple Street

Salt Lake City, UT, 84150-0023, USA


ЗӨВХӨН ЦАХИМ ХУВИЛБАРААР ГАРАХ НИЙТЛЭЛҮҮД



Сэтгэцийн хувьд дахин эрүүл болох 14 арга зам

Хийдэр Ж.Жонсон

Эдгээр санаа өөрийгөө дахин олж авахад тань тусална.



Өөрт тохирсон сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг эмчийг олох нь *Кэвин Тэриот*

Хэрэв та сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг эмчтэй уулзах талаар бодож байвал энэ нь танд хаанаас эхлэхийг зааж тусална.

НЭГДҮГЭЭР 2019 ОНЫ 1-Р CAP, 20, №1 ЛИАХОНА 18601 363

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн олон улсын сэтгүүл

Тэргүүн Зөвлөл: Рассэлл М.Нэлсон, Даллин Х.Өүкс, Хэнри Б.Айринг

Арван хоёр Төлөөлөгчийн Чуулга:

М.Рассэлл Баллард, Жэффри Р.Холланд, Дийтр Ф.Угдорф, Дэвид А.Баднар, Квинтин Л.Кук, Д.Тодд Кристоферсон, Нийл Л.Андэрсэн, Роналд А.Расбанд, Гари И.Стивэнсон, Дэйл Г.Рэнланд, Гэррит В.Гонг, Улиссэс Соарэс

Эрхлэгч: Хюго И.Мартинэз
Зөвлөхүүд: Бриан К.Эштон, Рэндэлл К.Бэннэтт, Бэжи Крайвэн, Шэрон Юбанк, Кристина Б.Франко, Доналд Л.Холлстром, Эрих В.Копишк, Линн Г.Роббинс

Гүйцэтгэх захирал: Ричард И.Хийтон

Сүмийн сэтгүүлийн захирал:

Аллан Р.Лойборг

Бизнесийн менежер: Гарфф Каннон

Гүйцэтгэх редактор: Адам С.Олсон
Гүйцэтгэх захирлын туслах: Рэан Карр
Хэвлэлийн туслах: Франсиска Олсон

Редакцийн баг: Марисса Дэннис, Дэвид Диксон, Дэвид А.Эдвардс, Маттью Д.Филитон, Лори Фүллэр, Гаррэтт Х.Гарфф, Ларин Портэр Гаунт, Жон Райн Жэнсэн, Шарлотт Ларкэбэл, Майкл Р.Моррис, Эрик Б.Мердок, Салли Жонсон Одэжөрк, Жошуа Ж.Пэркий, Жан Пинбороу, Ричард М.Ромни, Минди Сэлу, Чакэлл Вардлэй, Марисса Виддисон

Зураглал чимэглэлийн удирдагч

менежер: Ж.Скотт Кнүдсэн

Зургийн дарга: Тадд Р.Пэтэрсон

Уран бүтээлийн ажилтнууд: Жинэтт Эндрьюс, Фэй П.Андрус, Мэндий Бэнгли, С.Кимбалл Ботт, Томас Чайлд, Жошуа Дэннис, Дэвид Грийн, Коллийн Хинкли, Эрик П.Жонсэн, Сюзан Лофгрэн, Скотт М.Моой, Эмили Чиэко Рэммингтон, Марк В.Робисон, Брэд Тизри, К.Никол Вокэнорт

Оюуны өмчийн зохицуулагч:

Коллэтт Нэбжэр Аун

Хэвлэлийн менежер: Жэйн Анн Пэтэрсон

Хэвлэл баг: Ира Глэн Адэйр, Жоли Бөрдэтт, Томас Ж.Кронин, Брайн В.Гайги, Жинни Ж.Нилсон, Дэрж Ричардсон, Маррисса М.Смит

Хэвлэлийн эх бэлтгэгч: Жошуа Дэннис, Аммон Харрис

Хэвлэлийн захирал: Стивэн Т.Льюис

Хуваарилалт хариуцсан захирал:

Трой Р.Бархэр

Нэгдсэн Улс, Канадаас бусад орон дахь захиалга болон үнийн талаар орон нутгийн сүмийн хангамжийн төв болон тойрог, салбарынхаа удирдагчтай холбоо барина уу.

Гар бичмэл болон асуултаа

интернэт вэбсайт liahona.lds.org руу;

шуудангаар Liahona, Rm. 2420, 50 E.

North Temple St., Salt Lake City, UT

84150-0024, USA хаягаар; эсвэл э-мэйлийн:

liahona@ldschurch.org хаягаар ирүүлнэ үү.

Лиaхона (Мормоны Номон дахь уугаара бол "луужин" буюу "залагч") нь албани, англи, армен, бислам, болгар, вьетнам, гайти, герман, грек, дани, индонез, ирланд, испани, итали, камбож, кирибати, латви, литов, малагаш, маршалл, монгол, нидерланд, норвеги, орос, польш, португал, румын, свахили, самоа, себу, словени, солонгос, сингал,

тагалог, тай, тами, тахити, телуг, тонга, украин, унгар, урду, финжи, фин, франц, хинди, хорват, хятад, хятад (хялбаршуулсан), чех, швед, эстони, япон хэлээр нийтлэгддэг. (Жилд нийтлэгдэх дугаарын тоо бүрд өөр байна.)

© 2019 by Intellectual Reserve, Inc. Бүх эрх хамгаалагдсан. Америкийн Нэгдсэн Улсад хэвлэв.

Зохиогчийн эрхийн талаарх

мэдээлэл: Өөрөөр заагаагүй бол

хувь хүмүүс арилжааны бус зорилгоор

(Сүмийн дуудлага зэрэг) хувийн

хэрэгцээндээ *Лиaхона* гаас материал

хувиран авч, ашиглаж болно. Энэ

эрх ямар ч үед өөрчлөгдөхгүй. Хэрэв

зураг чимэглэлийн тухайд ямар нэг

хязгаарлалт тогтоосон бол үзүүлэнгийн

материалыг хуулбарлаж болохгүй.

Зохиогчийн эрхийн талаар асуух зүйл

байвал дараах хаягаар хандана уу.

Intellectual Property Office, 50 E. North

Temple St., FL 13, Salt Lake City, UT 84150,

USA хаягаар; эсвэл электрон шуудангийн

cor-intellectualproperty@ldschurch.org хаягаар ирүүлнэ үү.

For Readers in the United States

and Canada: January 2019 Vol.20, No. 1.

LIAHONA (USPS 311-480) Mongolian (ISSN

1525-7584) is published six times a year

(January, April, June, July, October, and

December) by The Church of Jesus Christ

of Latter-day Saints, 50 E. North Temple St.,

Salt Lake City, UT 84150. USA subscription

price is \$5.00 per year; Canada, \$6.00 plus

applicable taxes. Periodicals Postage Paid

at Salt Lake City, Utah. Sixty days' notice

required for change of address. Include

address label from a recent issue; old and

new address must be included. Send USA

and Canadian subscriptions to Salt Lake

Distribution Center at address below.

Subscription help line: 1-800-537-5971. Credit

card orders (American Express, Discover,

MasterCard, Visa) may be taken by phone or

at store.lds.org. (Canada Post information:

Publication Agreement #40017431)

POSTMASTER: Send all UAA to CFS (see

DMM 507.1.5.2). NONPOSTAL AND

MILITARY FACILITIES: Send address

changes to Distribution Services, Church

Magazines, P.O. Box 26368, Salt Lake City,

UT 84126-0368, USA.



ШИНЭ ГЭРЭЭН ДЭХ БЭЛГЭДЛҮҮД



БИД СУРГААЛААС ГАДНА
ШИНЭ ГЭРЭЭН ДЭХ ЗҮЙЛС,
СОЁЛ, ТҮҮХ БОЛОН
ГАЗРУУДААС УТГА САНААГ
ОЛЖ БОЛНО.

Уулс: “Ууланд мацах нь амар хялбар зүйл биш. Хүч чармайлт гаргах, дуулгавартай байхын үр дүнг онцлохын тулд Их Эзэн өмнөхтэй адил өнөө үед ч гэсэн Өөрийн шавь нарыг уул өөд мацахад дууддаг. Тэрээр бас танаас ийнхүү үйлдэхийг шууд бус болон шууд утгаар хүсэх болно.

Чидун жимс: “Есүс Чидуны уулын хойморт Цагаатгалын анхны бүрэлдэхүүн хэсгийг гүйцэлдүүлэхээр ирсэн. Үүнийг Тэр Гетсеманийн цэцэрлэгт хийсэн юм. *Гетсемани* гэдэг үг нь *гат* буюу ‘дарах, шэмэн буюу ‘тос,’ ялангуяа чидун жимсний тосыг илэрхийлэхэд ашиглагддаг хоёр еврей үгээс гаралтай.

Чидун жимсийг асар хүнд чулуун дугуйгаар дээрээс нь дарж, тосыг шахаж гарган авдаг. Түүний адил Гетсеманийн цэцэрлэгт Есүс дэлхийн



нүглийн жинд шууд утгаараа дарагдсан юм. Түүний цус буюу амьдралынх нь “тос” хөлс адил нүх сүв бүрээс нь асар ихээр дусалсан билээ. (Лук 22:44; С ба Г 19:18-ыг үзнэ үү.)”



Ус: “Иордан гол бол Есүсийн ‘зөвт байдлыг гүйцэлдүүлэх[ийн тулд]’ Иоханы Өөрийн баптисмыг хүртэхээр сонгосон газар юм [Матай 3:15]. Энэхүү ариун нандин ёслолыг цэвэр усны түвшин нь дэлхийн хамгийн нам доор хэсэгт оршдог газарт хийсэн нь ач холбогдолтой юу? Нас нөгчсөн эгэл даруу нөхцөл байдлаа мөн амь орж боссон явдлаа бэлгэдэн харуулах үүнээс илүү тохиромжтой сонгох газар Түүнд байсан гэж үү?”

Гавал: “Цовдлолт нь Голгота (еврей хэлээр) эсвэл Калвари (латин хэлээр) буюу ‘гавал’ гэсэн утгатай нэр бүхий толгод дээр болсон. Гавал нь үхлийн бэлгэдэл юм. Ийм л газар цагаатгагч золиослол хийгдсэн. Загалмай дээр дэлхийн Аврагч хамгийн чухал ач холбогдолтой зүйлийг буюу үхлийг дийлэх хүчийг авсан ба уг хүч нь бодит болохыг бэлгэдэхээр Их Эзэн үхлээс босож өргөгдсөн юм.



Russell M. Nelson, “In This Holy Land,” Tambuli, Feb. 1991, 13, 17, 18-аас эхи татав.



GETTY IMAGES-ИЙН ЗУРАГ

Фан Фон

Камбож, Пномпень



Фаны гэр шатахад тэр гурван ач зээгээ л аварч чадсан юм. Бусад бүх зүйл нь шатаж, үнс нурам болсон байв. Фан түймэр тавьсан хөршидөө уурлаж байв. Түүний уур гэр бүлийнхэнд нь төдийгүй хөршүүдэд нь тархахад Фан уучлах хэрэгтэй гэдгээ мэдлээ.

ГЭРЭЛ ЗУРАГЧИН ЛЭСЛИЙ НИЛССОН

Хөрш маань надтай адилхан ядуу хүн байсныг би мэдсэн. Тэр түймэр тавихыг хүсээгүй байлаа. Хэрэв түүнийг хариуцлагад татах юм бол тэр асуудалд орж, харин би үзэн ядсан хэвээр үлдэх байв. Тэгэхэд Их Эзэний хөршөө хайрла гэсэн үг санаанд орж ирсэн юм. Түүнийг уучлах хэрэгтэй гэсэн мэдрэмж надад төрсөн бөгөөд уучлахаар шийдэх үед амар амгалан мэдрэгдсэн.

Хөрш маань өөрийг нь уучилсанд надад баярлаж байлаа. Манай гэр бүл үүнд нь бүр ч их баярлаж байв. Үүнийг харсан би ч гэсэн баяртай байлаа.

Гишүүд болон хөршүүд маань гэр бүлд маань чадахаараа тусалсан юм. Би маш их будаа авсан тул үүнийгээ бусадтай хуваалцав. Тэд надаас хүнд нөхцөлд байж яагаад хүмүүст өгч байгаа юм бэ гэж асууж байлаа. Би бусдад үйлчилснээр Их Эзэнд үйлчилдэг гэж тэдэнд хариулж байв. Тэрээр миний амьдралд олон гайхамшигийг өгсөн учраас би ч гэсэн Түүнд өгөхийг хүсдэг. Бид түймэрт шатсан байшингаасаа хамаагүй сайхан байшинтай болсон.

ИЛҮҮ ИХИЙГ ОЛЖ МЭД

Ахлагч Ларри Ж.Еко Хоок уучлах нь хэрхэн танд урагшилж, амар амгаланг амьдралдаа авчрахад тусалдаг талаар заав. Тэрхүү захиасыг ids.org/go/1196-аас уншина уу.

Итгэлийн өөр хөргийг ids.org/go/18 вэбсайтаас үзнэ үү.





Тохинууллын зарчмууд

ТОХИНУУЛЛЫГ ӨӨРЧЛӨХ БИДНИЙ ЗОРИЛГО

Хэдийгээр олон янзын зорилгоор тохинуулдаг ч бидний хүчин чармайлт хувь хүний хувьд илүү гүн гүнзгий хөрвөгдөж, Аврагчтай илүү адилхан болоход бусдад туслах хүсэлд хөтлөгдсөн байх ёстой.

Бусдыг Аврагчийн адил хайрлах үед бид тэдэнд Түүнтэй адил туслахыг хүсдэг. Сайн Хоньчны хувьд Тэрээр утга учир бүхий тохинууллын хамгийн агуу үлгэр жишээ юм. Түүний загварын дагуу тохинуулахдаа Түүний хайрлах, өргөн дэмжих, үйлчлэх, адислах гэсэн хүчин чармайлт түр зуурын хэрэгцээ шаардлагыг нь хангах төдий байгаагүй гэдгийг санах нь чухал. Тэрээр өдөр тутмын хэрэгцээ шаардлагыг нь мөн тухайн үед туулж буй зовлон бэрхшээлийг нь ойлгож, тэднийг өрөвддөг байсан нь тодорхой. Тиймээс тэр эдгээж, хооллон ундалж, уучлан өршөөж, зааж сургадаг байсан. Гэвч Тэрээр өнөөдрийнх нь цангааг тайлахаас илүү ихийг хийхийг хүссэн (Иохан 4:13–14-ийг үзнэ үү). Тэрээр эргэн тойрныхоо хүмүүсийг Өөрийг нь дагаж (Лук 18:22; Иохан 21:22-ыг үзнэ үү), таньж мэдэн (Иохан 10:14; Сургаал ба Гэрээ 132:22–24-ийг үзнэ үү) мөн бурханлаг (Матай 5:48-ыг үзнэ үү) чадавхдаа хүрээсэй хэмээн хүсдэг. Өнөөдөр ч гэсэн Тэрээр ийнхүү хүсдэг (Сургаал ба Гэрээ 67:13-ыг үзнэ үү).

Бусдыг олон арга замаар адислан тусалж болох ч бусдад тохинуулахын эцсийн зорилго тэдэнд Аврагчийг таньж мэдэн, Түүнтэй адил болоход нь туслах явдал юм бол бид бүгд Аврагчийг мэддэгийн хувьд хөршдөө Их Эзэнийг таньж мэдэхийг заах хэрэггүй болох цаг ирэх хүртэл ажилласаар байх болно (Иеремиа 31:34-ийг үзнэ үү).





Аврагч түр зуурын эрэлт хэрэгцээнээс илүү зүйлст анхаардаг

- Хэдэн хүн асар их хүчин чармайлт гарган, найзаа саа өвчнөөс нь эдгээхээр Есүсийн өмнө авчрав. Эцэст нь Аврагч тэр эрийг эдгээсэн ч түүний нүглийг уучлахыг илүүд үзсэн (Лук 5:18–26-г үзнэ үү).
- Хүмүүс завхайрч байгаад баригдсан эмэгтэйг Аврагч дээр авчрахад Тэрээр түүнийг буруутгахын оронд амийг нь аварсан. Гэвч Тэрээр түүнийг сүнслэг байдлынх нь хувьд аврахыг хүсэн, “Яв. Үүнээс хойш дахин нүгэл бүү үйлд” (Иохан 8:2–11-ийг үзнэ үү) хэмээн хэлжээ.
- Мариа, Марта хоёр найз Лазараа ирж эдгээгээч хэмээн хүсэн, Есүс рүү хэл хүргүүлэв. Есүс тоолж баршгүй олон удаа бусдыг эдгээж байсан ч Лазарыг нас барсны дараа хүрэлцэн иржээ. Гэрийнхэн нь юу хүсэж байсныг Есүс мэдэж байсан ч Лазарыг амилуулснаар бурханлаг байдлын талаарх тэдний гэрчлэлийг хүчирхэгжүүлсэн юм (Иохан 11:21–27-г үзнэ үү).

Та эдгээр дээр өөр ямар ямар жишээ нэмж хэлж болох вэ?



Бид юу хийж чадах вэ?

Хэрэв бидний зорилго бусдад Аврагчтай илүү адил болоход нь туслах юм бол энэ нь тохинуулдаг арга замыг маань өөрчлөх болно. Энэхүү ойлголт бидний тохинуулах хүчин чармайлтыг дараах байдлаар удирдан залж болно. Тухайлбал:

1-р санаа: Үйлчлэлийг Аврагчтай холбо

Сайныг үйлдэхийн тулд гаргах бидний бүх хүчин чармайлт үнэ цэнтэй ч бид үйлчлэлээ Аврагчтай холбосноор үүнийгээ илүү сайжруулах боломж бололцоог хайж болно. Жишээлбэл, хэрэв таны тохинуулдаг гэр бүлийнхэн өвдсөн бол хоол унд авчрах нь тус болж болох ч Аврагчийн тэднийг гэх хайрын талаар гэрчлэх нь хайрын тань энгийн илэрхийллийг өсгөн нэмэгдүүлнэ. Хашаа цэвэрлэж тусалбал баярлах ч санваарын адислал өгөхийг санал болгох нь үүнийг илүү утга агуулгатай болгох боломжтой.

Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Нийл Л.Андэрсэн: “Сайхан сэтгэлтэй хүн хэн нэгэнд дугуйгаа янзлахад нь тусалж, сэтгэлээр унасан хүнтэй өдрийн хоол хамт идэж эсвэл инээмсэглэн, “Сайн уу?” гэж мэндчилснээр тухайн өдөр сэтгэлийг нь сэргээж болно.

Хамгийн эхний тушаалыг дагагч өөрийн эрхгүй үйлчлэлийн эдгээр чухал үйлдлийг нэмж хийдэг болно”¹ гэж заасан.

“Тохинууллын зарчмууд” сэдэвтэй нийтлэлүүд нь бидэнд айлчлан очихдоо хуваалцахад биш, харин нэг нэгнээ хэрхэн халамжилж сурахад туслах зорилготой. Үйлчилж байгаа хүмүүсээ таньж мэдэх үед тэдэнд халамж энэрлээс гадна ямар захиа хэрэгтэй байгааг Ариун Сүнс бидэнд шивнэн хэлэх болно.

2-р санаа: Гэрээний зам дээр анхаарлаа төвлөрүүл

Ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсон Сүмийн ерөнхийлөгчийнхөө хувьд гишүүдэд хандан, хамгийн анх удаа уг хэлэхдээ: “Гэрээний зам дээрээ үлд. Гэрээ байгуулж, уг гэрээгээ сахих нь хүртэх боломжтой сүнслэг адислал, давуу эрхийн үүд хаалгыг нээх болно”² хэмээн хэлсэн.

Хожмын үеийн гэгээнтнүүдийн хувьд бид баптисм хүртэн, гишүүнээр батлуулж, Ариун Сүнсний бэлэг хүлээн авдаг. Зохистой эрэгтэйчүүд санваар хүлээн авдаг. Бид хишиг хүртэн, гэр бүлээрээ мөнхөд лацдан холбогдохоор ариун сүмд очдог. Эдгээр авралын ёслолыг үйлдэж, холбогдох гэрээнүүдийг байгуулах нь бидэнд Түүнтэй адил болж мөн Түүнтэй хамт амьдрахад амин чухал юм.

Бид бусдад гэрээгээ сахиж, ирээдүйд гэрээ байгуулахад нь туслахдаа уг зам дээр үлдэхэд нь туслах чухал үүргийг гүйцэтгэж болно.³ Та өөрийн үйлчилдэг хувь хүн, гэр бүлүүдэд тэдэнд хэрэгтэй дараах ёслолоо хүлээн авахад нь хэрхэн тусалж чадах вэ? Энэ нь нэгэн эцэгт охиндоо баптисм хүртээхэд нь туслах дараагийн үүргийг гэрээнийх нь адислалуудыг тайлбарлах эсвэл ариун ёслолоос хүртэж байхдаа илүү утга учиртай байдлаар гэрээгээ шинэчлэх арга замуудыг хуваалцах зэргээр гүйцэтгэж болно.



3-р санаа: Урьж, урамшуулан дэмж

Тохиромжтой үед анхаарал халамж тавьдаг хүмүүстээ хөрвөлтийнх нь тухай мөн Христтэй илүү адилхан болохын тулд гаргаж буй хүчин чармайлтынх нь талаар зөвлөлд. Тэднээс олж хардаг мөн хүндэтгэн авч үздэг хүчтэй талуудынх нь талаар хэл. Тэднийг юун дээрээ ажиллах шаардлагатай гэж бодож байгааг нь олж мэдэн, хэрхэн тэдэнд тусалж болохоо ярилц. (Тохинуулж буй хүмүүстэйгээ зөвлөлдөх талаар илүү дэлгэрэнгүй мэдээллийг "Тэдний хэрэгцээ шаардлагын талаар зөвлөлд," *Лиахона*, 2018 оны 9-р сар, х. 1-3-аас авна уу.)

Тэднийг Аврагчийг даган, Түүнд бурханлаг чадавхдаа хүрэхэд нь туслах боломж олгоход урихаасаа бүү эмээ. Энэхүү урилгыг өгөхийн зэрэгцээ тэдэнд итгэж байгаагаа төдийгүй Христэд итгэдгээ илэрхийлэх нь амьдралыг өөрчлөх хүчтэй.





1. Хуваалц. Саад бэрхшээл тулгарсан ч сайн мэдээний зарчмуудын дагуу амьдарснаар Аврагчтай илүү ойртохыг хичээх үед Тэрээр хэрхэн танд тусалж байсан талаар үнэн сэтгэлээсээ, зоригтой хуваалц.

2. Адислалуудыг амла. Хүмүүст өөрчлөгдөхгүй байснаас өөрчлөгдөх нь хэрхэн тустай болохыг олж харахад туслах шалтгаан хэрэгтэй. Үйлдлийг дагалдан ирэх адислалуудыг тайлбарлах нь хүчтэй сэдлийг төрүүлж болно (Сургаал ба Гэрээ 130:20–21-ийг үзнэ үү).

Христэд өсөж хөгжихөд нь бусдад тусалж болох зургаан арга зам.

Дараах санаанууд бусдад амьдралаа сайжруулан, гэрээний зам дээр өсөж хөгжихөд нь тусалж дэмжихэд зориулагдсан. (Илүү их санаа авахыг хүсвэл, "Миний сайн мэдээг номло," 11-р бүлгийг үзнэ үү.)

3. Урь. Сайн мэдээний зарчмын дагуу амьдрах нь энэ нь үнэн гэсэн гэрчлэлийг авчирдаг (Иохан 7:17-г үзнэ үү) бөгөөд илүү гүн гүнзгий хөрвөгдөхөд хүргэдэг.⁴ Бараг бүх харилцаа холбоонд өсөж хөгжихөд нь туслах ямар нэгэн зүйл хийх урилгыг оруулж болно.

4. Хамтдаа төлөвлө. Өөрчлөгдөх амлалтаа амжилттай биелүүлэхэд тэдэнд юу тохиолдож болох вэ? Чи яаж тусалж чадах вэ? Үүнд цаг хугацаа хэрэгтэй юү?

5. Дэмжлэг туслалцаа. Тус болно гэвэл, тухайн хүнд санаа өгч, амжилтад хүрэхэд нь туслан дэмжих хүмүүсийн сүлжээг үүсгэ. Бид бүхэнд хөгжөөн дэмжигч хэрэгтэй.

6. Эргэж шалга. Өсөлт хөгжлийг нь хуваалц, Төлөвлөгөөн дээрээ анхаарч, шаардлагатай бол нарийвчлан тайлбарла. Тэвчээртэй, тууштай, урам зоригтой бай. Өөрчлөгдөхөд цаг хугацаа хэрэгтэй.

Үйлдэхэд урь

Тохинуулахдаа гаргаж буй их бага хүчин чармайлтынхаа аль алиных нь талаар бодож үзнэ үү. Энэ нь бусдын хөрвөлтийг гүнзгийрүүлж, Аврагчтай илүү адил болоход нь туслах болно.

Туршлагаа хуваалцана уу

Та бусдад эсвэл бусад хүн танд тохинуулж байсан туршлагаасаа бидэнд илгээнэ үү. Та liahona.lds.org вэбсайт руу ороод, "Submit an Article or Feedback" дээр дарна уу. ■

ЭШЛЭЛҮҮД

1. Neil L. Andersen, "A Holier Approach to Ministering" (Brigham Young University devotional, Apr. 10, 2018), 3, speeches.byu.edu.
2. Рассэлл М. Нэлсон, "Биднийг хамтдаа урагшлахад," *Лиакхона*, 2018 оны 4-р сар, 7.
3. Хэнри Б.Айринг "Гэрээн дэх охид," *Ensign*, May 2014, 125–28 эсвэл *2014 оны 4-р сарын Ерөнхий чуулган*, 13–16-г үзнэ үү.
4. David A. Bednar, "Converted unto the Lord", *Liahona*, Nov. 2012, 106–109-ийг үзнэ үү.



Есүсийн эх Мариа

Мариагийн түүх шавь байхын үнэ цэн,
адислалуудын мөнхийн сануулга болдог юм.

Бригам Янгийн Их Сургуулийн эртний судрын дэд профессор

Гэй Стратерн

Есүсийн эх Мариа сударт дурдагдсан хэдхэн эмэгтэйн нэг бөгөөд амьдрал, тохинууллынх нь талаар төрөхөөс нь олон зуун жилийн өмнөөс бошигдосон байдаг цорын ганц хүн юм (1 Нифай 11:15, 18; Мозая 3:8; Алма 7:10-ыг үзнэ үү).¹ Шинэ Гэрээний Матай, Марк, Лук болон Иоханыг бичигчид зохих ёсоор Аврагч дээр анхаарлаа төвлөрүүлсэн тул Мариагийн амьдрал, тохинууллын талаар зөвхөн зэрвэс дурдсан байдаг. Гэвч эхэн үеийн Христийн сүмийнхэн Эцэгийн төлөвлөгөөнд Мариагийн гүйцэтгэдэг чухал үүргийг сануулахын тулд түүнд *theotokos* буюу “Бурханыг тээгч биеийг төрүүлэгч буюу Бурханы эх”² гэсэн цолыг мөн өгсөн.

Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Брүс Р.Макконки (1915–1985) “Их Эзэний бусад эмэгтэйчүүдээс илүү их адисалсан тэр эмэгтэйг бид хэт их магтана гэж байж болох уу? Ганцхан Христ мөн ганцхан Мариа байсан. Тэдний аль аль нь [мөнх бус оршихуйн өмнөх амьдралд] сүрлэг сайхан, агуу нэгэн байсан ба өөр өөрсдийн тохинуулалд урьдчилан томилогдсон байв. Эцэг Өөртэйгөө адил эрэгтэйн сүнснийг Аврагчаар сонгосны адил Хүүгийнхээ эхээр хамгийн агуу эмэгтэйн сүнснийг сонгосон гэж бид бодохоос өөр аргагүй. Бид Мариаг . . . зохих ёсоор хүндлэн дээдлэх ёстой”³ гэж хэлсэн.

Мариагийн тухай өгүүлсэн Лукийн түүх (Лук 1:26–56-г үзнэ үү) энэ гайхалтай эмэгтэйг зохих ёсоор үнэлэх үүд

хаалгыг бидэнд нээж өгдөг. Габриел, Елизабет хоёртой харьцсан байдлаас нь бид Бурханаас хүлээн авсан өвөрмөц дуудлагаа мэдэж, ойлгохыг хичээж буй залуухан эмэгтэйг харж болно. Уг дуудлагын цар хүрээ залуухан нэгэнд хүнд санагдсан нь лавтай ч тэр өөрийн хүслийг Эцэгийн хүсэлтэй нэгтгэсэн юм. Бурхан Өөрийн хүүхэд нэг бүрийг мэддэг бөгөөд хаант улсыг нь барьж байгуулахад тулах энгийн эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг гайхалтай арга замаар оролцуулахаар дууддаг гэдгийг түүний түүх бидэнд сануулдаг. Тэр Есүсийн анхны шавь болсон бөгөөд иймээс тэр Түүнийг дагахыг сонгодог бүх хүний дагавал зохих загвар юм.

Назар: Мариагийн гэр

Харамсалтай нь Шинэ Гэрээн дээр Мариагийн эцэг эхийн тухай болон түүний хэрхэн төрсөн талаар мөн Назар дахь амьдралынх нь талаар ямар ч мэдээлэл байдаггүй. Лук Назарыг *polis*, орчуулбал хот, хотхон гэж дүрсэлсэн ч энэ нь ач холбогдол бүхий газар биш байсан бололтой. Шинэ Гэрээний хүрээнээс гадна авч үзэх юм бол Назар хот МЭ хоёр дахь зууны төгсгөл хүртэл ямар ч бичвэрт дурдагдаагүй юм.

Назар нь Иерусалимаас 65 бээрт (105 км) байрлах үржил шимтэй Жэзрил хөндий рүү харсан Галилын доод хэсэг дэх толгодод байрладаг байсныг бид мэднэ. 1-р зууны Назар нь хот, хотхон гэхээс илүү ойролцоогоор 400–500 хүнтэй тосгон байсныг археологчид олж тогтоосон.⁴ Хэдхэн хүнийг

эс тооцвол, Галилын ихэнх оршин суугч зөвхөн гэр бүлээ тэжээж, татвараа төлөхийн тулд мал маллаж, загас барьж, газар тариалангийн ажилд хөлсөөр ажилладаг байжээ. Тосгон хамгаалалтгүй байсан бөгөөд гудамж нь дардан замтай, том барилга байгууламжтай бас барилга нь гангиг, шигтгэмэл болон ханын зурагтай, гэр орондоо импортын бараа бүтээгдэхүүн хэрэглэдэг байсан гэсэн ямар ч нотлох баримт байдаггүй.⁵ Ухаж гаргасан 1-р зууны хоёр байшин нь энгийн, нэг давхар, хоёр өрөө, сүрлэн дээвэр, жижигхэн хашаатай байсан байна.⁶ Оршуулгын зан үйл мөн шохойн чулуун савны үлдэгдлүүд оршин суугчид нь харийнхан бус еврейчүүд байсныг нотолдог.

Эдгээр нээлтийн алиныг нь ч Мариа болон түүний гэр бүлийнхэнтэй холбож чадахгүй ч Назар дахь түүний амьдрал ямархуу байсан тухай буюу тэр ариун сүм, язгууртан прист, эд баялаг бүхий шашны төв Иерусалимаас хол, алслагдсан тосгоны ядуу охин байсан талаар таамаглах боломж олгодог юм. Залуухан охин байхдаа тэр ээжтэйгээ болон тосгоныхоо бусад эмэгтэйтэй хамт даавуу нэхэх, хоол хийх, түлээ түүх, гэрийнхээ усны сав эсвэл тосгоныхоо худагас ус зөөх, талбайд ажиллах гээд гэр бүлийнхэндээ амин зуулгаа залгуулахад нь өдөр бүр тусалдаг байсан байх.

Мариагийн дуудлага

Лук дээрх Мариагийн түүх өмнө нь ариун сүм дээр Захарид үзэгдсэн тэнгэр элч Габриелийн үзэгдсэнээр эхэлдэг (Лук 1:11, 19, 26-г үзнэ үү). Габриелийг үзэгдэх үед Мариа Иосефтой гэрлэхээр сүй тавьсан залуухан охин байв (Лук 1:27-г үзнэ үү). Тухайн үед Мариа хэдэн настай байсныг бид мэдэхгүй ч эрт дээр үед гэрлэлтийн гэрээг өсвөр наснаас өмнө хийж болдог байсан. Габриел үзэгдэж, Мариа “ивээгдэгч” болж, “Эзэн [түүнтэй] хамт” байж мөн “эмэгтэйчүүдийн дунд адислагдсан” нь байсан бөгөөд Иосеф Смитийн Орчуулгын Лук 1:28-д өгүүлснээр “сонгогдсон” нэгэн байсан (мөн Алма 7:10-ыг үзнэ үү) хэмээн хэлсэн нь Мариад янз бүрийн бодол, бүр айдсыг төрүүлсэн нь лавтай. Тухайн цаг мөчид түүнд ямар бодол төрж байсныг бид зөвхөн төсөөлж болох ч “Яагаад Бурхан намайг бусад ‘эмэгтэйчүүдийн дунд адислагдсан’ нэгэн гэж үзсэн юм бол?,” “Яагаад би ‘Бурханы өмнө ивээгдсэн’ болох мөн энэ нь юу гэсэн утгатай юм бол?,” “Яагаад Бурхан Габриелийг Назарын эсвэл Иерусалимын өөр

залуу эмэгтэй рүү биш, над руу илгээсэн юм бол?” гэсэн асуултууд түүнд төрж байсан болов уу. Тийм ээ, тэр Давидын угсааных байсан ч (Лук 1:32; Ром 1:3-ыг үзнэ үү), энэ нь Ромын боолчлол доор тийм ч чухал байсангүй. Эцсийн эцэст Мариа жижигхэн тосгоны, ядуу гэр бүлээс гаралтай ердийн нэгэн залуухан эмэгтэй байв. Натанаел хожим нь “Назараас ямар нэгэн сайн юм гарч чадна гэж үү?” (Иохан 1:46) хэмээн асуужээ.

Габриел Мариагийн оюун ухаан, зүрх сэтгэлийг дүүргэсэн байж болох ямар ч асуултад нь хариулаагүй юм. Харин оронд нь тэр түүнд хүүхэд, зүгээр ч биш нэгэн хүүхдийг тээнэ гэдгийг мөн түүний хүүхдийг “Хамгийн Дээдийн Хүү” хэмээн дуудах ба “өвөг Давидынх нь хаан ширээг өгөх болно” гэдгийг хэлсэн (Лук 1:32–33-ыг үзнэ үү). Өөрөөр хэлбэл, хүү нь Бурханы Хүү, амлагдсан Мессиа байх болно гэдгийг Габриел Мариад хэлсэн байв. Мариа ийн хэлэхээс нь өмнө эргэлзэж, айж байсан бол үүний дараа түүнд ямар байсныг бид зөвхөн төсөөлж л болно.

Мариагийн түүхийн энэ хэсэг шавь байх талаар ямар зарчим зааж байгааг бодож үзэцгээе. Мариад зориулсан Бурханы төлөвлөгөөг тэр өөрөө хүсээгүй! Захари, Елизабет хоёр хүүхэдтэй болгож өгөх гайхамшгийг хүсэн залбирсан болохоор Габриел түүнд үзэгдсэн ч, тэр Мариад өөр нөхцөл байдалд, хүсэлтийнх нь хариуг өгөхөөр биш, харин түүнд зориулсан Бурханы хүслийг мэдэгдэхээр ирсэн. Гэрлэх гэж байсан Мариа ирээдүйд хүүхэдтэй болно хэмээн бодож байсан байх. Хэдийгээр 1-р зууны үеэр иудейчүүд Мессиаг ирэхийг хүсэн хүлээж байсан ч Назарын ядуу гаралтай залуухан Мариа өөрийгөө Мессиагийн эх болно гэж бодож байсан болов уу? Үгүй л болов уу. Учир нь шавь байх дуудлага ирэх нь биднээс хувийн амьдралын төлөвлөгөөгөө өөрчлөхийг шаарддаг.

Лук өөрийн тэмдэглэлд эхлээд Габриелд, дараа нь Елизабетын тунхаглал дээр анхаарлаа төвлөрүүлсэн байдаг. Гэхдээ энд бас Мариа өөрийн бодол, мэдрэмжийг илэрхийлсэн гурван тохиолдлыг бичсэн байна.

Сүнслэгээр өдөөгдсөн асуулт

Эхнийх нь “Би онгон атал энэ нь яаж бүтэх билээ?” хэмээн Габриелд тавьсан асуулт юм (Лук 1:34). Нөхцөл байдлыг авч үзэх юм бол түүнд ийнхүү асуух шалтгаан байсан. Энэ нь Захаригийн “Би үүнийг хэрхэн мэдэх билээ? [Елизабет хүү төрүүлнэ гэдгийг]” гэсэн асуултыг



Тэнгэр элч Габриел Мариад үзэгдэн, “бусад эмэгтэйчүүдийн дунд адислагдана” мөн Бурханы Хүүг тээнэ гэсэн гайхамшигт захиасыг өгсөн.

уншигчдад сануулдаг (18-р шүлэг). Харин Захаригийн асуулт өөрийнх нь Бурханд хандан өргөсөн залбирлынх нь хариулт болж ирсэн Габриелийн хариултад эргэлзэж байгааг нь илэрхийлж байхад Мариа Бурханы өөрт нь хэлсэн зүйлийг тодотгон лавлаж байсан юм. Бурханы урилга шавь нарыг шаардлагаа дээшлүүлж, тав тухтай байдлаасаа гарахыг шаардах үед асуух зүйл гарч ирэх нь гарцаагүй бөгөөд сүнслэгээр өдөөгдсөн асуултууд ичлэлт рүү хөтөлдөг.

Мариагийн асуултад өгсөн Габриелийн хариултыг гурван хэсэгт хувааж болно. Тухайлбал:

1. Нэгд, тэр Мариад “Ариун Сүнс чам дээр ир[нэ]” гэж хэлсэн. Ариун Сүнс бол аль ч үеийн шавь нар дуудлагаа эрхэмлэн дээдлэхэд ашигладаг хүч юм. “Энэ ажлыг зөвхөн та нарынх ч биш, минийх ч биш гэдгийг санаарай. Энэ нь Их Эзэний ажил бөгөөд бид Их Эзэний ажлыг гүйцэтгэх үедээ Их Эзэний туслалцааг авах эрхтэй юм. Их Эзэн дуудсан

нэгнээ тэнцэхээр болгодог”⁷ хэмээн ерөнхийлөгч Томас С.Монсон (1927–2018) заасан. Тэгээд дараа нь Габриел “Хамгийн Дээдийн хүч чамайг бүрхэнэ.⁸ Тиймээс төрөх ариун нэгэн нь Бурханы Хүү гэж дуудагдах болно” (35-р шүлэг) хэмээн Мариагийн нөхцөлд тохирох хариултыг өгдөг.

2. Хоёрт, Габриел Мариад яг адилхан биш ч гэлээ гайхамшигтай байдлаар хүүхэд тээх Елизабетын тухай хэлдэг (36-р шүлгийг үзнэ үү). Елизабетын жирэмсэн болсон явдал Мариад өөрийг нь ганцаараа биш бөгөөд өөрт нь тохиолдсон зүйлийг ойлгох ядаж ганц хүн байгаа гэсэн ойлголтыг өгсөн юм.
3. Гуравт, Габриел эргэлт буцалтгүйгээр “Учир нь Бурханд боломжгүй юм гэж нэг ч байхгүй” хэмээн тунхагласан (37-р шүлэг). Елизабетыг жирэмслүүлснээр Бурхан боломжгүй зүйлийг боломжтой болгосон юм.⁹ Габриелийн тунхаглал бүх үеийн шавь нарт Бурханы урилгыг хүлээн авах юм бол гайхамшгууд тохиодгийг сануулдаг.



Мариа болон Елизабетын түүх хэрэгцээтэй үед нь нэг нэгэндээ үзүүлсэн хайр, дэмжлэг тусалцаагаар холбогддог.

Шавийн бэлэн байдал

Миний бодлоор “Эзэний шивэгчнийг харагтун. Хэлсэн үгсийн тань дагуу надад биелэх болтугай” (Лук 1:38) хэмээх уг түүхэн дэх Мариагийн хоёр дахь хариулт шавь хүний итгэл үнэмшил, үзлийг шингээсэн байдаг. “Шивэгчин” гэдэг нь Мариа Бурханы өөрт нь өгсөн дуудлагыг хүлээн

авах сонголт хийснийг үзүүлж байгаа болно. Энэ нь Хүүгийнх нь Гетсеманид “Миний хүсэл бус, харин Таны хүсэл биелэгдэг” (Лук 22:42) хэмээн хэлсэн үгийн Мариагийн хувилбар юм. Хэдийгээр Мариа өөрийн амьдралын энэ үед өөрөөс нь хүссэн бүхнийг ойлгох боломжгүй байсан гэдэг нь ойлгомжтой ч Симеон дараа нь түүнд “Сэтгэл чинь хүртэл илдэнд нэвт сүлбэгдэх болно” (Лук 2:35) хэмээн бошиг-лосончлон, итгэлтэйгээр урагш явах сонголтыг хийдэг.

“Тэнгэр элч түүнийг орхин одлоо” (Лук 1:38). Габриелийг явсны дараа Мариа ганцаараа үлдсэн. Шавийн хувьд тэнгэр элчийн дэргэд түүнийхтэй адил тунхаг хэлэх нь нэг хэрэг ч, харин тэнгэр элчийг явсны дараа тэр юу хийсэн бэ? Тэр энэ үйл явдлыг эцэг эхдээ бас Иосефт хэрхэн тайлбарладаг вэ? Тэд болон Назарын оршин суугчид түүнд итгэхгүй бол түүний хувьд энэ нь ямар нөлөө үзүүлэх байсан бэ? Назар дахь жижигхэн сууринд түүнд амьдрахад хэцүү болох байв.

Тиймээс тэр асуултад нь өгсөн Габриелийн хариултын хоёр дахь хэсгийг санаж, Елизабетын гэр рүү явж очдог. Лукийн эхний хоёр түүх дахин сүлжилдэн холбогдсон байна. Мариа Елизабеттай мэндлэнгүүт “хэвлий дэх хүүхэд нь хөдлөв. Елизабет Ариун Сүнсээр дүүрч, чанга дуугаар хашхиран, эмэгтэйчүүдийн дундаас ерөөлтэй нь чи мөн. Хэвлий дэх үр чинь ерөөлтэй ээ!” (Лук 1:41–42) гэв. Сүнсээр өдөөгдсөн мэндчилгээ нь Мариаг бусад эмэгтэйчүүдийн дундаас адислагдсан нэгэн хэмээн Габриелийн хэлсэн тунхгийг бататгасан юм. Мариа одоо дуудлагынхаа талаар хоёр дахь гэрчийг хүлээн авсан ч энэ нь зөвхөн өөрийн хүслээр дуудлагаа хүлээн авсны дараа л ирсэн.

Мариа болон Елизабетын түүх орчин үеийн шавь нарын амьдралын хоёр чухал талыг сануулдаг. Энэ нь янз бүрийн насны, амьдралынхаа өөр өөр үе шатанд байх эмэгтэйчүүд хүнд хэцүү цаг үед бие биеэ дэмжиж, туслахаар хамтдаа цуглардаг гэсэн дэлхий даяарх Халамжийн нийгэмлэгийн сууринд байх агуу бэлгэдлийн үнэ цэнийг сануулдаг. Энэ нь мөн Бурхан Өөрийн дуудсан хүмүүсийг хүнд хэцүү цаг мөчид нь хаядаггүй бөгөөд Өөрийн дуудсан өөр хүнээр дамжуулан тэднийг тэврэн авдаг гэдгийг сануулдаг билээ.

Эх Мариагийн магтаал дуу

Эх Мариагийн магтаал дуу хэмээн нэрлэгддэг Мариагийн хамгийн сүүлд хэлсэн үгс нь Елизабетын тунхаглалд хариулахдаа илэрхийлсэн баяр баясгаланг нь харуулдаг. Тэр өөрийнх нь амьдралд тохиолдсон үйл явдлын талаар

сэтгэгдлээ илэрхийлж, Бурханы төлөвлөгөөнд эзлэх байр суурийнхаа талаарх ойлголтыг эргэцүүлэн боддог. Юуны түрүүнд тэр өөрийн Аврагч гэдэгт баярлан, Бурханаа магтан дуулж, алдаршуулдаг (Лук 1:46–47-г үзнэ үү). Тэр өөрийн туршлагаас Бурхан үнэндээ түүн шиг “даруу” (48–50-р шүлгийг үзнэ үү) нэгнийг сонгосноос мөн Абрахамын гэрээг гүйцэлдүүлэхэд гол үүрэг гүйцэтгэхээр түүнийг сонгосон (54–55-р шүлгийг үзнэ үү) явдлаас Түүний нигүүлслийг олж харсан.

“Мариа Елизабетын хамт гурван сар орчим байгаад, гэртээ буцлаа” (55-р шүлгийг үзнэ үү). Мариа одоо өөрийн бурханлаг дуудлагыг гүйцэлдүүлэхэд илүү бэлтгэгдсэн байв.

Бидэнд өгсөн Мариагийн үлгэр жишээ

Орчин үеийн шавь нар Мариагийн түүхээс соёлын хувьд болон 2000 жилийн туршид таслагдсан. Гэсэн хэдий ч түүний түүх шавь байхын үнэ цэнийн талаарх мөнхийн сануулга болдог. Бурхан өгсөн урилгадаа шавь нарыгаа хариулаасай гэж хүсдэг. Ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсон бидэнд “Бурхан Өөрийн гэрээт хүүхдүүдээс үргэлж хүнд, хэцүү зүйлийг хийхийг хүсэж ирсэн”¹⁰ гэдгийг сануулсан. Мариа ч мөн бид ч гэсэн уг шаардлагаас чөлөөлөгдөөгүй. Бид өөрсдийн хүслийг Түүний хүсэлтэй нийцүүлэн үйлчилж байхад Түүний Сүнс дуудлагаа эрхэмлэн хүндлэхэд бидэнд тусална гэдэгт итгэн хүлээн авах үүрэгтэй. Мөн Залуу эмэгтэйчүүдийн ерөнхий ерөнхийлөгч Бонни Х.Кордон “бид хүнд хэцүү зүйлсийг хийж чадна,” “гэхдээ бид бас тэдгээрийг баяр баясгалантай хийж чадна”¹¹ гэдгийг сануулсан.

Орчин үеийн шавь болох бидний Магтаал дуу ямар байх вэ? Бид Бурханд баясаж байгаагаа хэрхэн илэрхийлж болох вэ? Түүний бидний амьдрал дахь нигүүлслийн гайхамшигийг бид хэрхэн илэрхийлж болох вэ? Энэ цаг үед Абрахамын гэрээг гүйцэлдүүлэхийн тулд өөрсдийн үүргийг биелүүлэх арга замуудыг бид хэрхэн олж болох вэ? Мариагийн шавь байх талаарх гайхалтай түүхээс бид эдгээр арга замын заримаас нь суралцаж болох юм. ■

Эшлэлүүд

1. Матай ч гэсэн Мариа бол Иммануел нэртэй хүүг төрүүлэх онгон бүсгүйн бошиглолын биелэл байсан гэдгийг ойлгож байсан (Исаиа 7:14-ийг үзнэ үү). “Онгон охины” тухай түүний эшлэлийг МЭӨ 2-р зуунд грек хэл дээрх Исаиа номын орчуулгаас авсан бөгөөд үүнийг эхэн үеийн Христэд итгэгчид ашигладаг байсан мөн хаан Жэймсийн Библийн хувилбар дээрх Исаиа 7:14-т ашигласан.

2. Мормоны Номын 1830 оны хэвлэл дээрх 1 Нифай 11:18-д Мариаг мөн “Бурханы эх” хэмээн дүрсэлсэн байдаг.
3. Bruce R. McConkie, *Mortal Messiah*, 4 vols. (1981), 1:326–27, footnote 4.
4. James E. Strange, “Nazareth,” *Anchor Bible Dictionary*, 4:1050; Jonathan L. Reed, *Archaeology and the Galilean Jesus: A Re-examination of the Evidence* (2002), 131-ийг үзнэ үү.
5. Reed, *Archaeology and the Galilean Jesus*, 131-ийг үзнэ үү.
6. Ken Dark, “Has Jesus’ Nazareth House Been Found?” *Biblical Archaeology Review*, vol. 41, no. 2 (March/April 2015), 54–63; see also Ken Dark, “Early Roman-Period Nazareth and the Sisters of Nazareth Convent,” *The Antiquities Journal*, vol. 92 (2012), 37–64-ийг үзнэ үү.
7. Thomas S. Monson, “Duty Calls,” *Ensign*, May 1996, 44.
8. “Бүрхэнэ” гэж орчуулагддаг грек үг (*episkiazo*) нь Хуучин Гэрээний грек хэлэн дээрх орчуулгад табернеклыг барьж дууссаны дараа дээр нь буусан үүлийг дүрслэхдээ ашигласан үг юм. Энэ нь Их Эзэний алдар сууг дүрсэлдэг.
9. Абрахам, Сара хоёрыг хөгшин насандаа хүүхэдтэй болно гэдгээ олж мэдэх үед Их Эзэн мөн энэ үгийг хэлсэн (Эхлэл 18:14; Ром 4:19–21-ийг үзнэ үү).
10. Рассэлл М.Нэлсон, “Жинхэнэ мянган жилийнхэн мэт байх нь,” *Лиахона*, 2016 оны 10-р сар, 49.
11. “Bonnie H. Cordon: Young Women General President,” *Liahona*, May 2018, 129.



Есүсийн хайртай шавь Иохан

Хайрт шавь Иохантай холбоотой Шинэ Гэрээний бичвэрүүд түүнийг бидний багш мөн шавь байхын загвар гэдгээр нь танилцуулдаг.

Бригам Янгийн Их Сургуулийн эртний судар судлалын профессор
Эрик Д.Хантсмэн

Иохан нь Есүс Христийн унаган арван хоёр төлөөлөгчийн дундаас Петрээс гадна олонд хамгийн их танигдсан төлөөлөгч юм. Тэр Өөрийн ах Иаковтой болон Петртэй цуг Аврагчийн мөнх бус амьдрал дахь тохинууллын хамгийн чухал цаг мөчид хамт байсан бөгөөд түүнийг ихэвчлэн Шинэ Гэрээний 5 өөр номтой холбодог.¹ Түүнийг Их Эзэнтэй ойр дотно байсан талаар Иохан 13:23-т “Түүний шавь нарын нэг болох Есүсийн хайрласан хүн Есүсийн цээжийг налаад сууж байлаа” хэмээн өгүүлсэн байдаг. Хэдэн зууны туршид Христэд итгэгчдийн уран зурагт энэ дүр зургийг буюу Иоханыг Аврагчийн мутрыг налж буй залуугаар дүрслэн үзүүлсээр ирсэн. Энэ нь хайрт Иохан гэх өвөрмөц нэрийнх нь гарал үүсэл боловч түүний гэрч болон номлол шавь байхтай холбоотой бидний дагавал зохих талуудыг илчилдэг.

Зебедеен хүү Иохан

Иоханы нэр еврей хэлээр *Johanan* буюу “Бурхан нигүүлсэнгүй байсаар ирсэн” гэсэн утгатай. Аврагчийн мөнх бус амьдрал дахь тохинууллын талаар гол төлөв нэг өнцгөөс илэрхийлэн бичсэн эхний гурван сайн мэдээнд түүний талаар бидний мэдэх ихэнх мэдээлэл багтдаг. Тэд бүгд Иохан нь өөрийн гэсэн завьтай, өөртөө болон хүүхдүүддээ ажлаа хийхэд нь туслах хөлсний ажилтнуудыг хөлслөх чадалтай Галилын баян чинээлэг загасчин Зебедеен хүү байсантай санал нэгддэг. Иохан ах Иаковтайгаа хамт ах дүү Петр, Андрей хоёртой хамтрагчид байсан ба Есүс тэднийг бүрэн цагаар Өөрийг нь дагахад дуудахад дөрвүүлээ загасчлаа ажлаа орхиж явсан юм.²





Есүсийг дуудахад Иохан, Иаков хоёр “завинд эцэг Зебедеегээ хөлсний ажилчдын хамт орхиж, Есүсийг даган одоцгоолоо” (Марк 1:20).

Сайн мэдээнүүдэд Зебедее дахин дурдагдаагүй ч Иаков, Иохан хоёрын ээж Есүсийг дагагч болж, хөвгүүдийнхээ өмнөөс хүсэлт тавьж, цовдлуулагдахад нь байсан талаар өгүүлдэг.³ Иаков, Иохан хоёрын эхийг ихэвчлэн Саломе хэмээн нэрлэдэг байсан бөгөөд тэр Есүсийн эх Мариагийн эгч ч байсан байж болох ба хэрэв тийм бол Есүс баптисм хүртээгч Иоханы үеэл болох юм.⁴

Иохан анх дуудагдсаныхаа дараахан Их Эзэний эхэн үеийн олон гайхамшиг, сургаалын гэрч болсон билээ.⁵ Иохан эдгээр гайхамшгийг харж, Уулан дээрх номлол гэх мэт яриаг нь сонсож байсан тул Есүс түүнийг арван хоёр төлөөлөгчийнхөө нэгээр дуудахад бэлдсэн нь гарцаагүй.⁶ Эдгээр онцгой гэрчийн дундаас Петр, Иаков, Иохан нар ойр дотнын шавь нарынх нь хүрээг бүрдүүлж байсан ба тэд Есүсийн дэлхий дээрх тохинууллын эхэн үед болж өнгөрсөн дараах чухал үйл явдлуудын үеэр хамт байсан. Тухайлбал:

- Иайрын охиныг үхлээс босгох үед үхлийг ялах Их Эзэний хүчийг өөрсдийн нүдээр харсан.⁷

- Хувиралтын уулан дээр Есүс Өөрийн алдар сууг илчилж, Эцэгийн дуу хоолой Есүс бол Түүний таалал оршдог Хүү гэдгийг гэрчлэхийг тэд сонссон.⁸
- Чидун ууланд хожмын өдрүүдийн тухай эцсийн бошиглолоо өгөхөд байсан.⁹
- Гетсеманийн цэцэрлэгт Аврагч Өөрийн Цагаатгалын агуу үйл хэргийг хийж эхлэхэд ойрхон байсан.¹⁰

Есүс Христ Симонд “хад чулуу” гэсэн утгатай *Кеф* буюу Петр гэсэн нэр өгсний адил Иаков, Иохан хоёрыг “аянгын хөвгүүд” буюу *Бонергес* хэмээн нэрлэсэн.¹¹ Есүсийг эсэргүүцсэн самаричуудын тосгон дээр тэнгэрээс гал буулгах (Лук 9:51–56-г үзнэ үү) эсэх талаар тэд Түүнээс асуусан учраас тэднийг түргэн ууртай, зөрүүд байсан гэдгийг энэ нэр хэлж байж болох юм. Гэсэн ч Петрийн нэр өмнө нь үнэн байсан ч, түргэн зантай байсныг нь биш, харин Есүсийн Амилалтын дараах гуйвшгүй байдал, хүч чадлыг нь тусган харуулж байсны адил уг нэрийг тэдэнд хүчтэй гэрчүүд болно гэдгийг нь бодолцон өгсөн байж болох юм.¹²

Үйлс номд Иоханыг Петрийн хүчтэй, байнгын хамтрагч гэж харуулсан байдаг. Петрийг ариун сүмд доголлон хүнийг эдгээхэд Иохан түүнтэй хамт байж, тэд хамтдаа Иерусалим дахь иудейн удирдагчдад зоригтойгоор номлож байсан юм. Филиппийн зааж, баптисм хүртээсэн самаричуудад Ариун Сүнсний бэлэг өгөхийн тулд хоёр төлөөлөгч хамтдаа Самари руу аялжээ.¹³

Гэсэн хэдий ч Иохантай холбоотой бичвэрүүдээс түүнийг өөрийн эзэн, найз Есүс Христийн бурханлаг байдлын хүчтэй гэрч гэдгээр нь харж болно. Шинэ Гэрээний эдгээр номд Иоханыг бидний багш мөн шавь байхын загвар гэдгээр нь танилцуулсан байдаг.

Хайрт шавь

Сонирхолтой нь, уламжлал ёсоор түүнийх хэмээн үздэг Сайн мэдээний номуудад Иохан огтхон ч дурдагддаггүй. Иоханы номын сүүлийн бүлэгт Зебедеен хоёр хүүг ганцхан удаа дурдсан байдаг. Энэ сүүлийн бүлэгт өгүүлснээр тэд Галилын тэнгист амилсан Их Эзэнтэй уулзсан долоон шавийн хоёр нь байжээ. Тэнд ч гэсэн тэднийг нэрээр нь дурдаагүй. Харин уламжлалт ёсоор, Сэргээгдсэн судар дахь эшлэлүүдийн бататгаснаар¹⁴ Иохан бол Сүүлчийн зоогт болон цовдлуулагдахад нь мөн хоосон булшин дээр, түүнчлэн хамгийн сүүлд Есүсийг Галилын тэнгист харагдах үед байсан, нэр нь дурдагддаггүй тэрхүү “Есүсийн хайртай шавь” мөн болохыг тодорхойлдог.¹⁵

Тэр мөн Андрейтэй хамт Баптисм хүртээгч Иоханы дагалдагчид байсан бөгөөд Есүс бол Бурханы хурга хэмээн гэрчлэхийг сонссон “нөгөө шавь” нь байсан байж болох (Иохан 1:35–40-ийг үзнэ үү) төдийгүй Есүсийг баривчлагдсаны дараа Петртэй хамт явж, дээд пристийн шүүхийн танхимд ороход нь Петрт тусалсан шавь байх магадлал өндөр юм (Иохан 8:15–16-г үзнэ үү).

Иоханы номд хайрт шавийг Их Эзэний ойр дотнын, найз нь байсан хэмээн өгүүлдэг. Сайн мэдээний энэ номд Марта, Лазар, Мариа

нартай хамт Иоханыг Есүс хайрладаг байсныг тодорхой дүрсэлдэг (Иохан 11:3, 5-ыг үзнэ үү). Сүүлчийн зоогийн ширээнд суусан байрлал нь нэр төрөөс гадна ойр дотно байсныг нь харуулдаг.

Аврагчийн найз байхын зэрэгцээ тэр Есүсийн номлолын үеэр болж өнгөрсөн хамгийн чухал үйл явдлуудын, тухайлбал загалмайн хөлд зогсож Их Эзэн нүглийн золиослол болгон амиа өгснийг харж, Амилалтын дараа булш руу хоосон байгааг нь шалгахар гүйн очиж, амилсан Аврагчийг харсан хүчирхэг гэрч байсныг нь бусад шүлэг илчилдэг.

Иоханы номд энэ бүхэн хайрт шавийнх нь харсан зүйл дээр үндэслэгдсэн бөгөөд түүний гэрчлэл үнэн гэдгийг хоёр ч удаа онцолсон байдаг.¹⁶ Энэ нь Иосеф Смит Сайн мэдээний энэ номыг “Иоханы гэрчлэл”¹⁷ хэмээн дахин нэрлэсний шалтгаан юм.

*“Эдгээрийг гэрчилж,
эдгээрийг бичсэн хүн бол
тэр шавь нь мөн. Түүний
гэрчлэл үнэн гэдгийг бид
мэднэ” (Иохан 21:24).*

Хайрт шавь гэдэг нь хэн болох талаар эрдэмтэд мэтгэлцдэг ч, хэрэв тэр төлөөлөгч Иохан байсан юм бол Сайн мэдээний номын анхны бичээч биш юм гэхэд ядаж эх сурвалж нь байх байсан.¹⁸ Тэгвэл яагаад тэнд түүний нэрийг дурдаагүй, төлөөлөгч Иохан гэж нэг ч удаа шууд тодорхойлоогүй юм бэ? Энэ асуултын хариулт нь тэр зарим талаараа өөрийн туршлагыг бүхий л цаг үеийн итгэгч, шавь нарт зориулан бичсэнд оршиж байж болох юм. Нэргүй

байснаар тэр өөрт тохиолдсон үйл явдлаа бидэнд өөрсөд дээрээ тусган хүлээн авах боломжийг олгон, хэрхэн Их Эзэнийг хайрлаж мөн Түүгээр хайрлуулахыг сурч, дараа нь өөрсдийн гэсэн гэрчлэлтэй болж, уг гэрчлэлээ бусадтай хуваалцахад дууддаг.

Захидлууд: 1, 2 болон 3 Иохан

Иоханы номын адил Иоханы гэх гурван захидлын алин дээр нь ч түүний нэрийг шууд дурдсан байдаггүй. Гэсэн хэдий ч захидал гэхээс илүү сургаалын шастир болох 1 Иохан нь Сайн мэдээний номуудтай загвар, сэдвийн хувьд, тухайлбал Сүүлчийн зоогийн түүх дээр Аврагчийн заасан хайр, дуулгавартай байдлын ач холбогдол гэсэн үндсэн санаануудтай нягт холбоотой.

Сайн мэдээний номуудын дараа бичигдсэн 1 Иохан нь “Эхнээсээ байсан бөгөөд бидний сонсож, нүдээрээ үзэж, харж, гараараа барьж үзсэн Амийн Үгийн тухай,” Их Эзэн Есүс Христийн тухай зохиогчийн гэрчлэлийн тунхаглалаар эхэлдэг (1 Иохан 1:1; онцлон

тэмдэглэлт нэмэгдсэн). Зохиогч Иоханы номын нээлтийн үгийг дахин дурдахын зэрэгцээ бие махбодоор хийгдсэн Бурханы Үг болон Есүс Христийн тухай өөрийн хүчтэй, хувийн, бодит гэрчийг онцлон тэмдэглэсэн.

Есүс Сүмийг орхисон гэсэн буруу зүйлд итгэдэг бүлгээс болж номын анхны уншигчид болох эхэн үеийн Христэд итгэгчид хоорондоо хагаралджээ.¹⁹ 1 Иоханд зохиогч нь гэрч байхын зэрэгцээ буруу номлолыг залруулж, Христийн эсрэг, худал хуурмаг сүнснүүдийн итгэлийг үгүйсгэх гэсэн оролдлогыг зогсоохоор дуудагдсан эрх мэдэлтэн байсан юм (1 Иохан 2:18–27; 4:1–6-г үзнэ үү). Түүний номлол итгэлтэй хэвээр үлдсэн хүмүүст Бурхан, Христ хоёрын тухай мөн итгэлтэй, зөв шударга үлдэхийн ач холбогдлын талаар утга учир бүхий үнэнүүдийг хуваалцах замаар тэднийг урамшуулан дэмжихэд чиглэж байв.

2 Иохан болон 3 Иоханд тэр өөрийгөө зүгээр л “ахлагч” гэж дуудан, хайр, дуулгавартай байдал, худал хуурмаг багш нарын талаар болон Сүмийн зохих ёсны эрх мэдлийг хүлээн зөвшөөрдөггүй хүмүүсийн аюулын талаар үргэлжлүүлэн онцолсон.²⁰

Энэ гурван ном гурвуулаа илчлэгдсэн Есүс Христэд үргэлж үнэнч байхын ач холбогдлын талаар заадаг.

Илчлэгч

Түүнийх гэж үздэг 5 номоос зөвхөн Илчлэлт дээр Иохан зохиогч нь гэдгийг эхний шүлгүүдэд нэрийг нь ашиглан дурдсан байна (Илчлэлт 1:1, 4, 9-ийг үзнэ үү). Зохиогч нь өөрийгөө Бурханы үйлчлэгч гэхээс гадна өөрийн байр суурь, дуудлагын талаар өөр ямар ч мэдээлэл өгөөгүй ч эхэн үеийн Христийн шашны удирдагчид тэр бол Иохан, Зебедесн хүү байсан гэдэгт итгэдэг байжээ.

Мормоны Ном болон Сургаал ба Гэрээ төлөөлөгч Иоханд илчлэлт хүлээн авч, үзсэн үзэгдлээ буулган бичих онцгой зөвшөөрөл өгөгдсөн байсныг нь баталдаг.²¹ Нарийн төвөгтэй, бэлгэ тэмдгээр дүүрэн Илчлэлт ном нь бүхий л цаг үед хавчлага, зовлон зүдгүүр амссан Христэд итгэгчдийг тайтгаруулж, урам дэм өгөхийн зэрэгцээ түүхийн туршид Есүс Христийн гүйцэтгэсэн үүргийг илчлэх зорилготой юм.

Хэдийгээр яг хэзээ Иохан Илчлэлт номыг бичсэн тухай хоёр өөр огноог буюу хаан Нирогийн хаанчлалын үеэр, МЭ 60 он болон хаан Домитианы үеэр, МЭ 90 оныг санал болгодог ч хоёулаа Петрийг алсны дараа байсан буюу энэ нь түүнийг амьд үлдсэн хамгийн ахмад төлөөлөгч болгох юм.

Гэвч түүний дуудлага зөвхөн номд бичиглэгдсэн байгаа үзэгдлийг харж, тэмдэглэх явдал байгаагүй. Нэг үзэгдэлд нь нэгэн тэнгэр элч Илчлэгч Иоханд жижигхэн номыг эсвэл хуйлмал бичгийг аваад ид хэмээн хэлдэг. Энэ нь эхлээд аманд амттай байснаа дараа нь ходоодыг нь хорсгосныг Иосеф Смит бүх зүйлийг сэргээх ажлынх нь нэгэн хэсэг болох Израилийг цуглуулах зорилгыг төлөөлсөн хэмээн орчуулсан билээ (Илчлэлт 10:9–11; Сургаал ба Гэрээ 77:14-ийг үзнэ

үү). Иохан хувиргагдсаныхаа дараа тохинууллаа үргэлжлүүлсэн тул энэ үйл хэрэг боломжтой болсон юм. Эртний болон орчин үеийн тайлбарлагчид Сайн мэдээний төгсгөлд Иоханы хувь заяаны тухай Петрт Есүсийн хэлсэн мэдэгдлийн утга агуулгын талаар санал хуваагдаг ч (Иохан 21:20–23-ыг үзнэ үү), Иохан үхлийг үзэлгүй үйл хэргээ Аврагчийг ирэх хүртэл үргэлжлүүлэн хийнэ гэдгийг баталсан илчлэлтийг Иосеф Смит хүлээн авсан (Сургаал ба Гэрээ 7:1–6-г үзнэ үү). Өөрөөр хэлбэл, тэрээр цаг үеийн төгсгөлийн талаар гэрчилсэн

*“Бид Бурханыг хайрлаж,
Түүний тушаалуудыг
сахиж байгаа цагт Бур-
ханы хүүхдүүдийг хайр-
ладаг гэдгээ бид үүгээр
мэднэ” (1 Иохан 5:2).*

төдийгүй өөрийнх нь зорилгод тэдгээр бошиг-
лолыг гүйцэлдүүлэх мөн илчлэгдсэн зүйлс нь
гүйцэлдэхийг гэрчлэх явдал ордог юм.

Хэдийгээр бидний зорилго түүнийхтэй адил
агуу биш ч гэлээ Иоханы үлгэр жишээ Есүс
Христийг гэх бидний хайр өөрсдийн дуудлага
болон амьдралын сорилт бэрхшээлийг хэчнээн
гашуун байсан ч хүлээн авахыг бидэнд заадаг.

Өөрсдөө хайрт шавь нар болох нь

Иохан Есүсийн анхны Арван хоёр төлөөлөг-
чийн удирдах гишүүн байсан бөгөөд Аврагч-
тай ойр дотно харилцаатай мөн Түүний гэрч,
Сүмийн удирдагч, илчлэгчийн хувьд чухал
үүрэг гүйцэтгэдэг байв. Хэдий ийм байсан
ч тэр өөрийнхөө нэрээр нэрлэгдсэн Сайн

мэдээний номд өөрийгөө хайрт шавь хэмээн дурдсан нь өөрсдийгөө шавь болох загвар болгох боломжийг бидэнд олгож байгаа юм. Есүс Христийн дагалдагчдын хувьд бид бүгдээрээ Түүний хайранд өлгийдөгдөх болно гэдгийг бид түүнээс мэдэж авдаг. Бид Сүүлчийн зоогийн үеэрх ёслолтой адил ёслолуудаар дамжуулан энэхүү хайраас бүрэн дүүрэн хүртдэг. Бид ч гэсэн загалмайн хөлд бэлгэдэл болон зогсож, бидний өмнөөс Есүс амиа өгснийг гэрчилж, Их Эзэн амьд гэдэгт өөрсдөө суралцахаар бүрэн итгэлтэй байх боломжтой. Иохантай адил, хайрт шавь нь болох бидний дуудлага бол уг гэрчээ бусадтай хуваалцан, үнэнийг гэрчилж, Их Эзэнийг эргэн ирэх хүртэл ямар ч дуудлагыг хийж гүйцэтгэх явдал юм. ■

ЭШЛЭЛҮҮД

1. Сонирхолтой нь, зөвхөн Илчлэлт номд зохиогч нь Иохан гэдгийг шууд бичсэн байдаг байна (Илчлэлт 1:1, 4-ийг үзнэ үү). Иохан гэх мэт Сайн мэдээний аль ч номонд зохиогчийг нь илчилдэггүй. Эхэн үеийн Христэд итгэгчдийн уламжлал ёсоор Иоханы сайн мэдээн дэх хайрт шавийг түүнтэй адилхан нэртэй төлөөлөгч мөн гэж үздэг аж. Нотолгооны талаар авч хэлэлцэх, эрдэмтдийн хэлэлцүүлэг хөтлөн явуулах, хэн болох тухай энэхүү тодорхойлолтын талаарх Сэргээлтийн ойлголтыг авах бол 17-р тэмдэглэлийг үзнэ үү. 1 Иоханд мөн л зохиогч нь хэн болохыг огтхон ч тодорхойлоогүй ч загвар, сэдвийн хувьд Иоханы сайн мэдээтэй нягт холбогдсон байдаг. 2 болон 3 Иохан дээр зөвхөн “ахлагч” хэмээн дурдсан байдаг ч эхэн үеийн Христэд итгэгчид уламжлал ёсоор тэдгээрийг Иохантай болон 1 Иоханы зохиогчийг холбосон байдаг.
2. Марк 1:19–20; Матай 4:21–22; Лук 5:10–11-ийг үзнэ үү. Ихэнх эрдэмтэд Маркийн номыг МЭ 60-аад оны дунд үед эхлээд бичиж, харин Матай, Лукийг МЭ 70-аад онд эсвэл МЭ 80-аад оны эхээр бичсэн гэдэгтэй санал нэгддэг. Тиймээс эхлээд Марк номын эшлэлүүдийг унших нь хэрхэн Матай, Лук хоёрыг эхний түүхэн дээр нэмсэн буюу тохируулсан гэдгийг олж харах боломжийг бидэнд олгодог.
3. Марк 10:35–37-д Иаков, Иохан хоёрыг Есүсийн хаант улсад Түүний баруун болон зүүн гар талд суулгахыг хүссэн гэж цэдэглэсэн бол Матай 20:20–21-д энэхүү хүсэлтийг ээж нь тавьсныг нэмж тодруулсан байдаг. Повдлуулалтын үеэр мөн дараа нь хоосон булшны дэргэд түүний байсныг Марк 15:40; 16:1–8; мөн Матай 27:55–56; Лук 23:49, 55; 24:1–10 болон Иохан 19:25-аас үзнэ үү.
4. Энэ бүхэн Салометэй холбоотой байж болохыг мөн Зебедеен гэр бүлийн болон загасчлах бизнесийн талаар R. Alan Culpepper, *John, the Son of Zebedee: The Life of a Legend* (2000), 7–23-аас үзнэ үү.
5. Марк 1:21–31, 40–45; 2:1–12; 3:1–6 мөн Матай 8:1–4; 9:1–8; 12:9–14; Лук 4:33–39; 5:12–15, 17–26; 6:6–11-ийг үзнэ үү.
6. Уулан дээрх номлолын талаар Матай 5–7-г үзнэ үү. Иохан болон анхны бусад төлөөлөгчийн талаар Марк 3:13–19; Матай 10:2–4; Лук 6:13–16-аас үзнэ үү.



7. Марк 5:37; Матай 9:23–26; Лук 8:51-ийг үзнэ үү. Гэхдээ Матайн номд Петр, Иаков, Иоханыг нэрлэдэггүй.
8. Марк 9:2–10; Матай 17:1–8; Лук 9:28–36-г үзнэ үү.
9. Марк 13:3–37-г үзнэ үү.
10. Марк 14:32–34; Матай 26:36–38-ыг үзнэ үү.
11. Марк 3:17-г үзнэ үү. *Бонергес* гэдэг нь “аянгын хөвгүүд” гэсэн утгатай *bene regesh* буюу *r'm* гэсэн арамайк үгний грек хэлээр махчилан орчуулсан орчуулга юм.
12. Culpepper, *John, the Son of Zebedee*, 38–40, 50-ийг үзнэ үү.
13. Үйлс 3:1–11; 4:1–21; 8:14–17-г үзнэ үү.
14. Сургаал ба Гэрээ 7; 77; 88:141-ийг үзнэ үү.
15. Иохан 13:23; 19:26, 34–35; 20:2–10; 21:1–14, 20–25 мөн Culpepper, *John, the Son of Zebedee*, 57–69-ийг үзнэ үү.
16. Иохан 19:35; 21:24–25; Иохан 20:30–31-ийг үзнэ үү.
17. *Joseph Smith's New Translation of the Bible: Original Manuscripts*, edited by Scott H. Faulring, Kent P. Jackson, and Robert J. Matthews (2004), 234-ийг үзнэ үү.
18. Хайрт шавь гэж хэн болох талаарх эрдэмтдийн хэлэлцүүлгийг, *John, the Son of Zebedee*, 72–85, and Raymond E. Brown, *An Introduction to the Gospel of John*, edited by Francis J. Moloney (2003), 189–199-өөс үзнэ үү. Төлөөлөгч Иохан Иоханы сайн мэдээний эх сурвалж эсвэл зохиогч байсан талаар Richard Neitzel Holzapfel, Eric D. Huntsman and Thomas A. Wayment, *Jesus Christ and the World of the New Testament* (2006), 126–27, and my own recent treatment in “The Gospel of John” in *New Testament History, Culture, and Society* (2018), ed. Lincoln Blumell-ээс үзнэ үү.
19. Raymond E. Brown, *The Epistles of John* (The Anchor Bible, vol. 30 [1982]), 49–55, 71-ийг үзнэ үү.
20. Culpepper, *John, the Son of Zebedee*, 90–95, and Holzapfel, Huntsman, and Wayment, *Jesus Christ and the World of the New Testament*, 274–277-г үзнэ үү.
21. Holzapfel, Huntsman, and Wayment, *Jesus Christ and the World of the New Testament*, 281–82, and especially 1 Nephi 14:18–27; Ether 4:16; and Doctrine and Covenants 7:1–3; 77-г үзнэ үү.

Есүсийн номлолын үеэр болж өнгөрсөн хамгийн чухал үйл явдлуудын гэрчийн хувьд Иохан загалмайн хөлд зогсож, Их Эзэний үгэхийг харж мөн Амилалтын дараа булшруу хоосон байгааг нь шалгахар гүйж очин, амилсан Аврагчийг харсан билээ.



АЛТАН УРГАЦ, ДЭВИД МЭРРИЛЛ, СҮМБЭЙН ТҮҮНИЙ МУЗЕЙН ЗӨВШӨӨРЛӨӨР НИЙТЛЭВ

Есүс Христэд болон
Түүний Цагаатгалд итгэх
итгэл нь ургац хураах
итгэлийг хэлдэг. Энэ бол
өөрийн биш, харин Түүний
хүчинд итгэх итгэл юм.





Далын
Ахлагч Вилфорд
В.Андэрсэн

Итгэлийн хоёр түвшин

Лихайг гэр бүлийнхэнтэйгээ аглаг буйдад хэдхэн өдөр болсны дараа Их Эзэн түүнд Лебенээс гуулин ялтаснуудыг авахуулахаар хөвгүүдээ Иерусалим руу буцааж явуул хэмээн хэлсэн. Бид Лихайн хоёр дуулгаваргүй хүү Лемен, Лемүелийн талаар тэр болгон таатай ярьдаггүй ч тэд үнэндээ явахад бэлэн байсан юм. Тэдэнд үзээд алдах хангалттай итгэл байсан.

Лемен, дараа нь Лемүел ах дүү нартайгаа хамт Лебенээс ялтаснуудыг өгөхийг гуйсан юм. Ах дүү нар үүнийг хийх гэж оролдох явцдаа гэр бүлийнхээ эд баялгийг алдах байтугай, өөрсдийн амийг алдах шахдаг. Тэр үед Лемен, Лемүел хоёр итгэл алдарч, бууж өгөхөд бэлэн байсан. Харин Нифай аюултай, урам хугарам нөхцөл байдлыг даван гарч чадсан. Тэр:

“Их Эзэн амьдын адил, мөн бидний амьд нь илэрхийн адил, бид Их Эзэний зарлигласан зүйлийг гүйцэлдүүлэх хүртэл бид аглаг буйдад буй эцэг уруугаа очихоор явахгүй.

Иймийн тул, Их Эзэний зарлигийг дагахад итгэлийг хичээе” хэмээн хэлдэг (1 Нифай 3:15–16).

Дараа нь Нифай өөрийн агуу итгэлийг ашиглан Лебенээс ялтаснуудыг авч, ах нартайгаа хамт аглаг буйдад байх эцэг дээрээ эргэж очсон билээ.

Итгэлийн хоёр тодорхой түвшин байдаг бололтой. Эхний түвшин нь оролдож үзэх, хадуураараа хадах итгэл, харин хоёр дахь түвшин нь үйлдэх итгэл юм. Хадуураа хадахаас илүү дээр итгэл бол хураах итгэл билээ.

Лемен, Лемүел хоёрт оролдож үзэх, харин Нифайд үйлдэх итгэл байсан. Лемен, Лемүел хоёрт хадуураараа хадах хангалттай итгэл байсан бол Нифайд хураахад хангалттай итгэл байв.

Хадуураараа хадах, хураах гэсэн хоёр итгэлийн хоорондын нарийн ялгаа амьдралд тань асар их өөрчлөлтийг авчрах болно. Тэнгэрлэг Эцэгтэй хамт дахин амьдарч, дэлхий дээр үр дүнтэй, баяр хөөрөөр дүүрэн амьдрахын тулд бид хураах итгэлийг хөгжүүлэх ёстой.

Бид Их Эзэний гайхамшигтай амлалтыг, тухайлбал энэ амьдралдаа аз жаргал, баяр баясгаланг, харин ирэх амьдралдаа өргөмжлөл хүртэнэ гэсэн амлалтыг хүлээн авсан. Гэвч өдөр тутмын амьдралын асуудал, бэрхшээлүүд бидний итгэл найдварыг үгүйсгэдэг талтай. Бидэнд амлагдсан нутаг асар хол, боломжгүй мэт санагддаг тул бид эргэлзэж эхэлдэг.

“Бид тэр зорилгод хүрч, адислалуудыг хүлээж авах боломжгүй юм байна. Их Эзэн эдгээр амлалтыг өгөхдөө өөр хүний талаар бодож байсан байх” гэж бид боддог.

Гийм биш ээ, Тэрээр та бидний талаар бодож байсан. Бид зөвхөн адислалуудаасаа хүртэх хангалттай итгэлтэй буюу хэтийн амлалтыг одоо бодит зүйл болгон өөрчилж чадах хүчтэй итгэлтэй байх хэрэгтэй. Бидэнд хураах итгэл хэрэгтэй.

Энэ итгэл нь яг ямар итгэл вэ, бид үүнийг хэрхэн хөгжүүлж болох вэ?



Тэнгэрлэг Эцэгт
өөрийн хүслийг
Түүнийхтэй
нийцүүлэх зөв
шударга хүслээр
адислахыг хүсэн
өдөр бүр залбир.

Есүс Христэд итгэлтэй бай

Юуны түрүүнд хадуураараа хадах итгэлтэй харьцуулбал хураах итгэл нь өөртөө итгэх итгэл биш юм. Энэ нь өөрөө өөртөө итгэлтэй байх, эерэг хандлагатай байхтай адил биш. Тэр ч бүү хэл, сайн зүйл ч гэлээ энэ нь гэр бүл, найз нөхдөдөө итгэх итгэл биш юм. Хураах итгэл нь Есүс Христэд болон Түүний Цагаатгалд итгэх итгэлийг хэлдэг. Энэ бол өөрийн биш, харин Түүний хүчинд итгэх итгэл юм.

Намайг Аризонагийн Месагийн Марикопа гадасны ерөнхийлөгчөөр дуудагдах үед Далын ерөнхий эрх мэдэлтэн байсан ахлагч В.Мак Лоорэнс эхнэр бид хоёрыг гадасны ерөнхийлөгчийн албан өрөөнд урьж, уг дуудлагыг өгч билээ. Би дуулгавартай хүлээн авсан. Тэгээд дараа нь тэр биднийг дээд зөвлөлийн өрөөнд орж, өөрийн зөвлөхөөр санал болгох эрчүүдийн талаар залбирч бодож үзэхэд урьсан. Би тэр өрөөнд ороод, гадас зохион байгуулагдсанаас хойш тэнд үйлчилж байсан бүх ерөнхийлөгчийн зургуудыг харж, зүрх минь шимшрэв. Тэд Сүмийн болон орон нутгийнхаа гайхалтай сайн удирдагчид байв.

Би эхнэр рүүгээ хараад, “Кайтлин, би энэ дуудлагыг хийж чадна гэж бодохгүй байна. Би тэдний хэмжээнд хүрэхгүй шүү дээ” гэв.

Тэр минь “Надад хэлээд хэрэггүй дээ. Чи ахлагч Лоорэнстэй ярьсан нь дээр” гэлээ.

Намайг түүнд уг дуудлагыг хийж чадна гэдэгтээ итгэхгүй байна гэдгээ хэлэхэд ахлагч Лоорэнс “Тийм ээ, таны зөв ч байж болох юм” гэж хариулсан нь миний гайхширлыг төрүүлсэн бөгөөд дараа нь “Андэрсэн ах аа, та хийж

чадахгүй ч, Их Эзэн чадна. Түүнд Өөрийн ажлыг хийх хүч бий. Хэрэв та зохистой мөн шаргуу хөдөлмөрлөх юм бол Тэр хийх болно. Та үүнийг харна” гэж хэлсэн юм.

Тэр ч хийх ажлаа хийсэн.

Хадуураараа хадах итгэл бол оролдож үзэх итгэл юм. Энэ нь өөртөө итгэх итгэл бөгөөд асуудал хүндрэх үед замхран алга болдог. Тэгээд дараа нь бид эргэлзэж эхэлдэг. Харин хураах итгэл бол Их Эзэн Есүс Христэд итгэх итгэл юм. Энэ нь хэзээ ч алга болдоггүй.

Өөрийн хүслийг Бурханы хүсэлтэй нийцүүл

Хураах итгэлийг хөгжүүлэхийн тулд бид өөрсдийн хүсэл, зорилгыг Бурханы хүсэлтэй нийцүүлсэн байх ёстой. Бурхан бидний ургацтай санал нийлэхгүй бол бид хэзээ ч хураах итгэлээ хөгжүүлж чадахгүй. Түүний тусламжийг хүлээн авахын тулд бид өөрсдийн хүслийг Түүнийхтэй нийцүүлэх ёстой.

Хиламаны номд гардаг бошиглогч Нифай зөв шударга, итгэлтэй хүн байсан тул Их Эзэн түүнд “Би чамайг үүрд адислах болно; мөн би чамайг үгэнд мөн үйлэнд, итгэлд мөн ажилд ч хүчирхэг болгох болно; тийм ээ, бүр бүх зүйл чиний үгийн дагуу чамд хийгдэх болно” хэмээн хэлсэн. Ямар гайхалтай амлалт вэ! Дараа нь Их Эзэн “учир нь тааллын минь эсрэг зүйлийг чи эс гуйдаг билээ” хэмээн нэмж хэлсэн байдаг (Хиламан 10:5).

Түүнчлэн Моронай бидэнд “Мөн Христ хэлдэг: Хэрэв та нар надад итгэлтэй байх аваас та нар миний хувьд шаардлагатай болох аливаа зүйлийг хийх хүчтэй байх болно” (Моронай 7:33) гэж хэлсэн.

Өөрсдийн хүслийг Бурханыхтай нийцүүлэх нь хураах итгэлтэй болохын өмнө тавигддаг шаардлага юм.

Хөвгүүд маань бага байхдаа ахлах сургуулийнхаа сагсан бөмбөгийн багт тоглодог байв. Тэр үед тэд тоглолт бүрийн өмнө залбирдаг байсан. Хажуунаас нь харж байхдаа би тэд юуны төлөө залбирч байгаа бол гэж боддог байв. Хэрэв тэд тоглолтод ялахын төлөө залбирсан бол хураах итгэл дутсаных байлаа. Энэ нь тэдний хожигдсон тоглолтын тооноос илт байв. Их Эзэн тоглолт бүрд хожих гэсэн тэдний хүслийг хуваалцахгүй байсан бололтой.

Өөрөөр хэлбэл, Бурхан зөвхөн бидэнд сайн гэж үзсэн зорилгодоо л хүрэхэд туслах болно. Яагаад гэвэл, Тэр биднийг хайрладаг бөгөөд бидэнд юу сайн болохыг биднээс илүү мэддэг. Бид үүнд нь талархдаггүй гэж үү? Бид Тэнгэрлэг Эцэгтээ Түүний хүсэлд өөрсдийн хүслийг нийцүүлэх зөв шударга хүслээр адислахыг хүсэн өдөр бүр залбирах ёстой. Бид Их Эзэн Гетсеманийн цэцэрлэгт залбирсны адил, бидний биш Бурханы хүсэл биелэгдэг гэж залбирч сурах ёстой (Лук 22:42). Зөвхөн тэгсэн цагт л бид хураах итгэлийг хөгжүүлэх боломжтой юм.

Явж ажилла

Хураах итгэлд тавигддаг гурав дахь шаардлага бол ажил юм. Төлөөлөгч Иаков үйлсгүй итгэл нь үхмэл гэдгийг тодорхой хэлсэн. Хадуураараа хадахад итгэл үнэмшил хэрэгтэй ч, хураах итгэл нь итгэл үнэмшлээс илүү зүйлийг шаарддаг. Чөтгөрүүд ч мөн үүнд итгэж, чичирдэг хэмээн Иаков бичсэн (Иаков 2:17, 19-ийг үзнэ үү).

Охин нь орныхоо хажууд өвдөг сөгдөн суугаад, ахынхаа барьж, хашаанд байрлуулсан шувууны торонд жижигхэн шувуудыг орохоос хамгаалаач гэж Тэнгэрлэг Эцэгт хандан залбирч байхыг олж харсан нэгэн эцгийн түүхийг би сонсож байсан. Тэр өдрийн орой аавынх нь санаа зовж эхлэв. Тэр тор нь сайн болсон гэдгийг мэдэж байлаа. Тэр хүүдээ уг торыг барихад тусалсан байв.

“Чамайг өглөө Тэнгэрлэг Эцэгээс жижигхэн шувуудыг ахынхаа хавхан торноос хамгаалаач гэж залбирч байхыг би сонссон. Гэхдээ заримдаа залбирсан ч гэсэн эмгэнэлтэй зүйлс тохиолддог” гэж тэр охиндоо хэллээ.

Тэр “Аав аа, тэр ямар ч шувуу барихгүй гэдгийг би мэдэж байна” хариулав.

“Охин минь, чиний итгэлийг би хүндэлж байна л даа. Хэрэв түүнд шувуу баригдах юм бол энэ нь итгэлд чинь муугаар нөлөөлөхгүй байх гэж би найдаж байна” гэж аав нь хэлэв.

“Аав аа, тэр барихгүй ээ. Түүнд баригдахгүй гэдгийг би мэднэ” гэж охин нь хариулжээ.

Харин аав нь түүнээс “Хаанаас чамд ийм их итгэл байдаг байна аа?” гэж асуухад,

Охин нь “Залбирч дууссаныхаа дараа би гадаа гараад, шувууны бүх торыг юу ч үгүй эвдэлсэн” гэж хариулжээ.

Тэнгэрлэг Эцэгээс адислал хүсэн залбирах нь зөв ч “амен” гэж хэлснийхээ дараа бид гарч, ажлаа хийх ёстой. Бид хөлөө ч хөдөлгөхийг хүсэхгүй атлаа Их Эзэн бидний алхмыг удирдан залахыг хүсэн хүлээж болохгүй. Бид мөн өөрсдийн хийж чадах, мөн хийвэл зохих зүйлээ Түүгээр хийлгэхийг хүсэх ёсгүй.

Бид өөрсдийн зөв шударга зорилгод хүрэхийн тулд ажиллаж, зарлиг тушаалуудыг сахихын тулд шаргуу хөдөлмөрлөх ёстой. Бурхан амлалтаа биелүүлдэг гэдэгт баттай итгэх бус, харин өөрсдийн амлалтыг баттай биелүүлэх үед бидний гэрээний мөн хураах итгэлийн бодит хүч жинхэнээсээ хэрэгжиж эхэлдэг. Тэрхүү агуу үнэн нь ирээдүйн амлалтуудыг өнөөгийн бодит байдал болгон хувиргадаг юм. Бид ажиллах ёстой.

Бүтэлгүйтэх, алдаа гаргах зэрэгт сэтгэлээр бүү уна, харин үргэлж хичээл зүтгэл гарган, тууштай бай. Хураах итгэл нь төгс байхыг шаарддаггүй ч шаргуу байхыг шаарддаг.

Би таныг хураах итгэлээ хөгжүүлэхэд урьж байна. Итгэлээ Аврагч Есүс Христэд болон Түүний Цагаатгалд бат бөх суурилуул. Өөрийн хүслийг Түүний хүсэлтэй нийцүүлэн, тааруулахад анхаар. Харин дараа нь бүхий л зүрх сэтгэл, хүчин чадал, оюун хийгээд чадлаараа, шаргуу, шийдэмгий байж, ажиллахаар гар. Хураах итгэлд саад болох ямар ч бэрхшээл, асуудал, саад гэж байхгүй. ■

2015 оны 3-р сарын 17-нд Айдахо дахь Бригам Янгийн Их Сургуулийн онцгой цугларалт дээр хэлсэн “The Faith to Reap” үгээс авав.



ИТГЭЛЭЭ ХАРУУЛ


“Түүнд итгэснээр итгэл тань үргэлж аюулгүй, найдвартай байж болох цорын ганц Хүн байдаг. Тэр бол Их Эзэн Есүс Христ юм. Иймээс та нар итгэлээ харуулах хэрэгтэй!”

Ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсон, “Итгэлээ харуул,” 2014 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 46.

БОШИГЛОГЧ

*Мосеф
Смитийн*

ГАЙХАМШИГТ ЗОРИЛГО



Б и бошиглогч, энгийн хүн болох Иосеф Смитийн талаар үг хэлэхээр сонгосон билээ. Би түүний талаар ярихдаа энэ эрин үеийг үндэслэсэн бошиглогчийн өвөрмөц, гайхамшигт ололт амжилтын талаарх та бүхний ойлголтод нэмэр болно байх хэмээн найдаж байна.

Иосеф Смитийн талаарх мэдлэг, гэрчлэл нь номлолын ажилд амин чухал. Зарим сонирхогч сайн мэдээний үндсэн сургаалуудыг хүлээн зөвшөөрдөг ч 14-хөн настай хүүхэд дээр Эцэг, Хүү хоёр ирж, мөн тэр Мормоны Номыг орчуулан, бидний мэдэх бошиглогч болсон гэдгийг огтхон ч хүлээн зөвшөөрдөггүйг бид бүгд мэднэ. Бошиглогч Иосеф Смитийг хүлээн зөвшөөрөхөд асуудалтай хүмүүс ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсоний сургаалаас суралцах хэрэгтэй. Тэр:

“Иосеф Смит мөнх бус оршихуй дахь ажлыг хийхээр урьдчилан томилогдсон билээ. Түүний хүлээн авах чадвартай, цэвэр ариун оюун ухаан Их Эзэний удирдамжийг хүлээн авахад нээлттэй байв. Гэвч дэлхийн жишгээр бол Иосеф огтхон ч тохирохгүй байлаа. Харин энэхүү сүүлчийн эрин үеийн бошиглогч байх үүрэгт ажил нь огтхон ч боломжгүй мэт санагдаж байв. Энэ жишээ Их Эзэн ихэвчлэн ямар арга замаар ажилладаг болох зарчмыг үзүүлдэг. Тэрээр санаанд оромгүй зүйлийг ашиглан боломжгүй зүйлийг гүйцэлдүүлдэг!”¹

Манай номлогчид Иосеф Смитийн тэнгэрлэг дуудлага, гайхамшигт ажлын талаар гэрчлэлтэй байх нь маш чухал.

Би бол Иосеф Смитийн амьдралыг судлан суралцагч



Тэргүүн Зөвлөлийн нэгдүгээр зөвлөх Ерөнхийлөгч Даллин Х.Өүкс

Иосеф Смит маш богино хугацаанд ямар ч хүний хийж бүтээснээс илүү их зүйлийг хийж бүтээсэн. Үүнд өгч болох цорын ганц тайлбар бол тэнгэрлэг тусламж юм.



Иосеф Смит нас барах үедээ Науву хотын захирагч, Науву легионы дэслэгч генералаар үйлчилж байсан юм.

бөгөөд 65 настай. Миний бие 1932 онд, Сүм зохион байгуулагдсанаас хойш дөнгөж 100 гаруй жил болж байхад төрсөн. Би өөрийгөө 2 дахь зууны энгийн итгэлтэй хожмын үеийн гэгээнтнүүдийн нэг гэж боддог. Бид Иосеф Смиттэй уулзаж байгаагүй ч түүнийг мэддэг мөн түүний илчилж, заасны дагуу түүнийг хайрладаг. Бид “ийн хүмүүс ‘Иосеф ахыг’ мэдэцгээнэ”² гэсэн яруу найргийн үгээр зөгнөн хэлсэн үгс үнэн болохыг гэрчилдэг гэрчүүд билээ.

I. Бошиглогч Иосеф Смит

Иосеф Смит энэ эрин үеийн анхны бошиглогч, Их Эзэний мутар дахь сэргээлтний зэмсэг байсан гэдгийг бид бүгдээрээ мэднэ. Гэхдээ Их Эзэн энэ бошиглогчоор дамжуулан юуг сэргээсэн бэ? Хожмын үеийн гэгээнтнүүд бүгдээрээ (мөн зарим гишүүн бус хүн) Их Эзэн Иосефт сүнслэгээр нөлөөлж, Христийн сургаалд нүсэр том тайлбар, нэмэлтийг хийсэн гэдгийг мэддэггүй. Хураангуйлсан жагсаалтыг өгье.

- Эцэг, Хүү, Ариун Сүнсний мөн чанар
- Бурхан Тэргүүтэний энэ гурван гишүүн тус бүрийн үүрэг, мөнх бус биестэй ямар харилцаа холбоотой болох
- Хүмүүний уналтын мөн чанар
- Эцэгийн хүүхдүүдэд мөнхийн хувь тавиландаа хүрэхэд нь зориулсан Түүний төлөвлөгөөг урагшлуулахад гүйцэтгэдэг мөнх бус амьдралын зорилго
- Үхэшгүй байдлыг хүлээн авч, мөнх амьдралд очих боломжийг олгоход Христийн Цагаатгалын гүйцэтгэдэг үүрэг
- Эцэгийн төлөвлөгөөнд дэлхийн болон мөнхийн гэрлэлтийн гүйцэтгэдэг үүрэг
- Эцэгийн төлөвлөгөөнд санваар болон ёслолуудын гүйцэтгэдэг нэн чухал үүрэг
- Эцэгийн төлөвлөгөөнд ариун сүм болон төлөөлөн гүйцэтгэх ёслолуудын гүйцэтгэдэг үүрэг
- Бурхан бүх хүүхдээ аврахыг хүсдэг бөгөөд энэ дэлхий дээр амьдарч байсан хүн бүр Есүс Христийг мэддэг байсан эсэхээс үл хамааран энэ амьдралын дараа тэнгэрийн хамгийн өндөр түвшинд хүрэх боломжтой
- Ертөнцийн болон хүмүүний тухай үнэний гурван үндсэн эх сурвалж бол шинжлэх ухаан, судрууд, үргэлжилсээр буй илчлэлт болой.

Тэр 1805 оны
12-р сарын 23-нд
АНУ-ын Вермонт
мужийн Шаронд
төржээ.



Энэ жагсаалтаас өчүүхэн бага хэсгийг судалсан хэн боловч, шүтлэгтэй, шүтлэггүй байхаас үл хамааран, Иосеф Смит шашны тод томруун, шинэлэг бөгөөд эрхэм дээд үзэл бодлын асар хүчтэй урсгалын эх булаг дээр зогсдог гэдгийг хүлээн зөвшөөрсөн байх ёстой. *Миний сайн мэдээг номло* товхимлоос сайн мэдээний бүрэн байдлыг Иосеф Смитээр дамжуулан дэлхийд сэргээсэн болохыг бид уншдаг.³

Миний жагсаалтад Иосеф судрын шинэ боть, мэдээж, шашны олон шинэлэг санааны эх сурвалж болох Мормоны Номыг урагш авчирсан талаар онцгойлон дурдаагүй байгааг та ажигласан байх. Энэ номд онцгой анхаарал тавих шаардлагатай. Номын гарчиг хамгийн чухал үүргийг нь буюу “Есүс Христийн бас нэгэн гэрээ” болохыг тунхагладаг. Гэвч үндсэн үүргээс нь гадна өөр олон үүрэг бий. Олонд алдартай эрдэмтэн энэ номын талаар ийн өгүүлсэн.

“*Мормоны Ном* нь Америкт эрх чөлөөний эзэнт гүрний оронд зөв шударгын улс орон болох шинэ зорилгыг санал болгосон байдаг. Эд баялаг, тэгш бус байдал улам бүр газар авч байгаа энэ үед *Мормоны Ном* ядуусын эрх ашгийг хамгаалдаг. . . . Бүгд найрамдах намын засгийн газрын эсрэг энэ нь Бурханы хуулийн доор шүүгч, хаадаар удирдуулахыг санал болгодог. Библиэс өөр судар, гайхамшигийг хүлээн зөвшөөрдөггүй шашны оронд *Мормоны Ном* гайхамшиг, илчлэлт, бүх улс оронд зориулсан илчлэлт үргэлжилж байгааг тэмдэглэдэг. Энэ нь үл итгэх үзлийн оронд итгэлийг мөн үндсэрхэг үзлийн оронд нэгдмэл Израилийг дэмждэг. Хэрэв улс орон эд баялгийг хайрлаж, илчлэлтийг үгүйсгэх юм бол харийн үндэстэн ястнууд Израиль, зөв шударга ёс, илчлэлтийг дарангуйлахыг энд зөгнөн өгүүлдэг.”⁴



Иосеф Смит
шашны тод
томруун,
шинэлэг
бөгөөд
эрхэм дээд
үзэл бодлын
асар хүчтэй
урсгалын эх
булаг дээр
зогсдог.

Хамгийн чухал нь ерөнхийлөгч Нэлсоний Мормоны Номын талаар саяхан хэлсэнчлэн, энэ

нь “Израилийг цуглуулна гэсэн амлалт гүйцэлдэхэд зэмсэг болох юм.”⁵

Бошиглогч Иосеф Смит Мормоны Ном бол “манай шашны тулгуур чулуу” хэмээн хэлснийг бид *Миний сайн мэдээг номло* товхимлоос уншдаг.⁶

Ихэнх хожмын үеийн гэгээнтэн Иосеф Смитийн шашны үзэл бодолд оруулсан агуу их хувь нэмрийг мэддэггүй. Санал асуулга явуулагч Гари Лоорэнс улс даяар явуулсан судалгаагаар хүмүүсийн бараг тал нь хожмын үеийн гэгээнтнүүдийг хөндий, нууцлаг, “хачирхалтай итгэл үнэмшилтэй”⁷ хэмээн боддог болохыг олж мэджээ. Харин санал асуулгад оролцож байгаа хүмүүсээс “Мормонизмын гол итгэл үнэмшил юү вэ?” гэж асуухад долоон хүний нэг нь л сэргээлт эсвэл анхны Христийн шашныг сэргээсэн талаар ойролцоо зүйл

хэлсэн аж. Үүнтэй адил, өөр нэгэн улс даяар хийгдсэн судалгаагаар манай шашны талаарх ойлголтоо хэлэхийг хүсэхэд ганц ч хүн анхдагч буюу Христийн шашны сэргээлтийн талаар дурдаагүй байна.⁸

Эдгээр судалгааны үр дүн манай номлогчид манай шашны талаар хүмүүс сайн мэддэг гэж бодож болохгүй болохыг бидэнд сануулж байна. Тэдний заах хүмүүс *Мормон* гэсэн үгийг сонссон байж болох ч ихэнхэд нь манай шашны үндсэн зарчмуудын талаар наад захын ойлголт ч байхгүй гэдгийг мэдэх ёстой.

II. Энгийн хүн Иосеф Смит

Би Иосеф Смитийн гайхамшигт амьдралын талаар зарим хувийн бодлоосоо хуваалцъя.⁹ Ихэвчлэн АНУ-ын Иллинойс мужид байхдаа хийсэн судалгаагаар танил болсон

Иосеф Смит нь шинийг санаачлагч залуухан, сэтгэлийн хөдлөл ихтэй, эрч хүчтэй нэгэн байсан ба хүмүүсийн хайрыг татсан, нөхөрсөг нэгэн байсан тул хүмүүс түүнийг гол төлөв “Иосеф ах” хэмээн дууддаг байжээ. Хамгийн сонирхолтой нь тэр харьцангуй залуу насандаа бошиглолын тохинуулалд дуудагдсан байв. Анхны үзэгдлийн үеэр тэр 14-тэй, алтан ялтаснуудыг хүлээн авахдаа 21-тэй, Мормоны Номыг (ажлын 60 хоногоос бага хугацаанд) орчуулж дуусахдаа дөнгөж 23 настай байжээ.

Сургаал ба Гэрээн дэх илчлэлтүүдийн талаас илүү хувь нь бошиглогчийг 25-тай эсвэл үүнээс залуу байхад өгөгдсөн. Тэргүүн Зөвлөлийг зохион байгуулагдахад тэр 26-тай, Миссури дахь шоронгоос оргон гарч, гэгээнтнүүдийг дахин удирдахдаа 33-тай байв. Түүнийг 38 нас хагастай байхад амийг нь егүүтгэжээ.

Богинохон наслахдаа Иосеф Смит мөнх бус амьдралын бүхий л зовлонг амссан. 7 настай байхдаа тэр хөлөндөө маш хүнд мэс засал хийлгэсэн байв. Гэр бүл нь ядуу байсан тул албан ёсны боловсрол бараг эзэмшээгүй бөгөөд өсвөр насандаа гэр бүлээ тэжээхэд туслахын тулд олон цагаар ажиллах шаардлагатай байжээ. Түүний биед олон тохиолдолд халдаж байв. Ариун дуудлагынхаа олон үүрэг хариуцлагыг гүйцэтгэх гэж хичээхийн зэрэгцээ тэр гэр бүлээ тэжээхийн тулд фермер, худалдаачин зэрэг ажлыг хийх хэрэгтэй байжээ. Тэр энэ бүхнийг бошиглолын дуудлагад нь дэмжин тусалдаг байсан гайхалтай сүнслэг бэлэггүйгээр хийдэг байв. Их Эзэн түүнд “цаг зуурын хөдөлмөрүүдэд чи хүчирхэгжих нь үгүй, учир нь энэ бол чиний дуудлага биш” (Сургаал ба Гэрээ 24:9) хэмээн хэлсэн.

Сүнслэг асуудлын хувьд ярихад, Иосеф Смитэд хэрхэн бошиглогч, удирдагч болоход суралцах, үлгэр дуурайл болгочих хүн байсангүй. Тэрээр туршлагагүй хамтрагчдаа тулгуурлах хэрэгтэй байв. Тэд хамтдаа хичээж суралцсан юм. Иосеф мэдлэгийг асар хурдан олж аван, төлөвшжээ. Түүнд онцгой бэлгүүд байсныг хэн ч үгүйсгэхгүй. Өнөө үед тэр бидний хэлдгээр “хурдацтай сурч” байлаа. Тэрээр өөрийг нь тэнгэрлэг элч болон Бурханаас ирсэн өөр бусад илчлэлт зааж сургасан гэж хэлсэн байдаг бөгөөд би үүнд итгэдэг.

Түүнийг дагасан гайхалтай хүмүүсийн хайр энэрэл, үнэнч байдлаас хувь хүний хувьд түүнд байсан бэлгүүдийнх нь нэгийг харж болно. Иосеф дагалдагчдаа мөнх бус оршихуйн сул дорой байдлаасаа салахыг уриалахдаа өөрийгөө тэднээс дээгүүр тавиагүй бөгөөд тэд ч үүнийх нь төлөө түүнийг хайрладаг байсан билээ. Иосеф амиа алдахаасаа сар гаруйхны өмнө сургаал айлдахдаа “Би та нарт өөрийгөө төгс гэж хэзээ ч хэлээгүй, гэвч миний заасан илчлэлтүүдэд алдаа байхгүй”¹⁰ хэмээн хэлсэн. Иосеф Смит “төрөлхийн хөгжүүн баяр хөөртэй зан чанар[тай]” (Иосеф Смит—Түүх 1:28) байсан нь таньж мэддэг бараг бүх хүнд нь таалагддаг байжээ. Түүнийг таньдаг нэгэн хүн “Гэгээнтнүүдийн түүнийг хайрлах хайрыг үгээр илэрхийлэхийн аргагүй”¹¹ хэмээн хэлсэн байдаг. Иосефын хувьд найз нөхдийнх нь нөхөрлөл баяр баясгаланг авчирдаг байсан ба тэр нийгэм, хамт олныг зохион байгуулах нь сайн мэдээний үндсэн зорилгууд хэмээн үздэг байжээ.

Би нэг удаа “Иосеф Смит амьдралынхаа туршид зах хязгаар нутгаар амьдарч байсан ба тэнд амьдрахын тулд хүмүүс байгаль дэлхий, заримдаа нэг нэгнийхээ эсрэг адгуусны адил хүчээр тэмцэх шаардлага гардаг байв. Тэр биеийн хувьд том, хүчтэй, хөдөлгөөнтэй хүн байв. Тэр мөн саваа булаацалдах гэх мэт биеийн хүч чадал сорьсон спортод дуртай байжээ (*History of the Church*, 5:302-ыг үзнэ үү). Манай архивт түүнийг найз нөхөд, танил хүмүүстэйгээ барилдаж байсан тухай олон түүх агуулагддаг. Нэгэн Хүндэтгэлийн өдөр Бригам Янг тэр хоёр Наувугаас мориор нэг өдрийн зайд орших Иллинойсын Рамус дахь гэгээнтнүүдэд номлож байжээ. Даваа гарагт Рамусаас явахынхаа өмнө Иосеф ‘Рамусын танхай этгээд’ хэмээн нэрийдсэн эртэй барилдан, хүч сорив (*Joseph Smith Journal*, 13 March 1843, recorded by Willard Richards, Joseph Smith Collection, LDS Church Archives-ийг үзнэ үү). Иосеф түүнийг авч шиджээ. Өнөө үед манай орон нутгийн гишүүдэд хүрэлцэн ирсэн эрх мэдэлтнүүдийг ийм маягаар сорих боломжийг чуулганы хуваарьт оруулдаггүйд би талархдаг”¹² гэдгийг олж мэдсэн.

Номлолынхоо явцад эсвэл тэдний санаж байгаагаар Иосеф Смитээс олон удаа халдлагад өртөж байсан хүн цөөхөн. Би хувиараа судалгаа хийж байхдаа түүнд тулгасан хэргүүдийг Иосефын амьдралынхаа сүүлийн таван жилийг өнгөрүүлсэн

Анхны үзэгдлийн үеэр тэр 14-тэй, алтан ялтаснуудыг хүлээн авахдаа 21-тэй, Мормоны Номыг (ажлын 60 хоногоос бага хугацаанд) орчуулж дуусахдаа дөнгөж 23 настай байжээ.



Иллинойсийн эх бичвэрүүдээс судалсан. Иосеф Смитийг Науву хотын захирагч байхад тус хотын зөвлөл *Naivoo Expositor* буюу сөрөг хүчний сонин үйл ажиллагааг хаахад түүнд ийм нэгэн хэрэг тулгажээ. Энэхүү хаасан явдал нь Сүмийн эсрэг дайсагналыг өдөөж, Иосефын аллагад шууд нөлөөлжээ.

Сүмийн эхэн үеийн хожмын үеийн гэгээнтэн түүхчид, түүний дотор ахлагч Б.Х.Робертс энэхүү үйлдэл нь хууль бус байсныг хүлээн зөвшөөрсөн байдаг. Харин би хуулийн залуухан багш байхдаа үүнийг судлан, энэ арга хэмжээг авах хууль эрх зүйн үндэслэлийг 1844 оны Иллинойс мужийн хуулиас олохдоо гайхсан юм. Иргэний дайнаас өмнө хил хязгаар нутагт сонинуудын үйл ажиллагааг хаадаг байсан явдал түгээмэл байжээ. АНУ-ын Үндсэн хуульд хот, мужийн засаг захиргааны үйлдэлд хэвлэлийн эрх чөлөө хамаатай болохыг 1931 он хүртэл тунхаглаагүй бөгөөд үүнийг зөвхөн 1868 оны үндсэн хуульд хийгдсэн нэмэлт өөрчлөлтийг АНУ-ын Дээд шүүхийн гишүүдийн дөрөв нь түдгэлзэж тав нь дэмжсэн тул оруулсан байдаг.¹³ Хүмүүс Иосеф Смитийн үйлдлийг бидний үеийн бус, харин тухайн үеийн хууль, нөхцөл байдалд тулгуурлан шүүх нь зүйтэй.

Түүхч Марвин С.Хилл бид хоёр Чикагогийн Их сургуулийн оюутан байхдаа Иосеф Смитийн аллагын хэргээр таван хүн Иллинойсийн шүүхээр орсон тухай олны сайн мэддэггүй баримтыг олоод гайхаж билээ. 10 гаруй жилийн хугацаанд бид улсынхаа өнцөг булан бүрд байх номын сан, архиваас 1845 онд болсон энэхүү шүүх хурал болон үүнд оролцсон хүмүүсийн тухай ямар нэгэн мэдээлэл олохоор хайсан юм. Бид номондоо Иосеф Смитийг биесчлэн таньж мэддэг, хайрладаг, түүний төлөө амиа ч өгөхөд бэлэн мөн түүнийг үзэн ядаж, алахыг завдаж байсан Иллинойсын иргэдийн



аль алиных нь үгс, үйлдлүүдийг оруулсан. Бидний олсон шүүхийн баримтад мөн урт хугацаанд үргэлжилсэн шүүх хуралдааны гэрчлэлд амиа алдсан хүний нэрийг гутаан доромжилсон ямар ч зүйл олдоогүй болно.¹⁴

Иллиной мужийн шүүхийн баримттай танилцах боломж нь Иосеф Смитийн талаар урьд өмнө хөндөгдөж байгаагүй өөр нэгэн судалгаа руу хөтөлсөн юм. Тухайн үед Чикагод хуулийн сургуульд сурч байсан оюутан Жозеф И.Бэнтлий бид хоёр Иосеф Смитийн бизнесийн үйл ажиллагааны талаар олон баримт мэдээлэл олсон билээ. 1976 онд бид хамтдаа


Нас: *Үйл явдал:*

- 14** Анхны үзэгдэл
- 21** Алтан ялтаснуудыг хүлээн авсан
- 23** Мормоны Номыг орчуулж дууссан
- 25** Сургаал ба Гэрээн дэх илчлэлтүүдийн хагасыг нь хүлээн авсан
- 26** Тэргүүн Зөвлөлийг зохион байгуулсан
- 33** Миссури дахь шоронгоос оргон гарч, удирдлагыг эргүүлэн авсан
- 38** Амиа алдсан

Brigham Young University Law Review сэдвээр нийтлэл бичсэн.¹⁵ 1840-өөд онд улс орныг хамарсан санхүүгийн хямрал, уналтын үе ирэв. Иллинойс гэх мэт хил хязгаар мужийн санхүүгийн нөхцөл байдал сүйрлийн хэмжээнд хүрсэн байжээ. Жишээлбэл, Абрахам Линкольны намтар судлаачид бизнес тогтворгүй, зээлүүд төлөгдөхгүй, шүүх ажиллагаа нийтлэг байсан энэхүү арван жилийн туршид түүний санхүү ямар ичгэвтэр байдалд байсныг өгүүлсэн байдаг.¹⁶

Иосеф Смитийн дайснууд түүнийг ихэвчлэн Сүмийн өмнөөс хийсэн янз бүрийн үл хөдлөх хөрөнгийн худалдааны залилан хийсэн хэргээр шүүхэд татсан байна. Бараг 10-аад жилийн туршид явагдсан дараа дараагийн шүүх хурлуудаар эдгээр хэргийг маш нарийн судалсан байдаг. Эцэс сүүлд нь 1852 онд буюу гэгээнтнүүдийг Иллинойсоос дүрвэн гарснаас бүр хойно (тухайн үед гэгээнтнүүд болон тэдний удирдагчийн талыг улс төрийн

1844 онд Иосеф Смит АНУ-ын ерөнхийлөгчийн сонгуульд оролцсон. Энэ сурталчилгааны хуудсан дээр амийг нь егүүтгэхээс тавхан хоногийн өмнө түүний үг хэлэх хуваарийг зарласан байжээ.



болон өөр бусад шалтгаанаар дэмжих ямар ч шалтгаан байгаагүй) холбооны шүүгч энэхүү шүүн таслах ажиллагаагаар Иосеф Смитийн зүгээс залилан хийгээгүй мөн ёс суртахууны өөр бусад зохисгүй үйлдэл гаргаагүй гэсэн дүгнэлт гаргажээ.¹⁷

Энэ цаг үеийн олон нийтийн асуудлын талаар өргөн мэдлэгтэй эрдэмтэд Иосеф Смитийн АНУ-ын ерөнхийлөгчийн сонгуульд оролцсон компани ажлынх нь талаар ийн бичсэн байдаг.

“Хэдийгээр 1844 оны сонгуульд түүнд ялах бодит боломж байгаагүй ч, тэр Нэгдсэн Улсад хууль эрх зүйн шинэчлэлтийг хөхиүлэн дэмжих талаар нухацтай хандаж байсан гуравдагч намын нэр дэвшигчээр ухаалгаар ажиллаж байв. Тэр боолчлол, шашны эрх чөлөө, шорон, нийтийн эзэмшлийн газар гэх мэт маш чухал асуудлын талаар олон нийтийн ойлголтыг сайжруулахыг хүсэж, үүний төлөө ажиллаж байсан. Зөвхөн тэр болон Роберт Ф.Кэннеди хоёр л Нэгдсэн Улсын ерөнхийлөгчийн албанд нэр дэвшигч байх явцдаа алуулсан юм.”¹⁸

Иосеф Смитийн зан чанарыг зөвхөн түүнийг сайн таньдаг, Сүмийн удирдлагад хамгийн ойр хамтран ажиллаж байсан хүмүүс л мэдэх байх. Тэд түүнийг гүнээ хүндэлж, бошиглогчоор дэмжин баталсан. “Түүний ах Хайрум хажууд нь үхэхээр шийдсэн байлаа. Түүнийг егүүтгэгдэх үед хамт байсан Жон Тэйлор: ‘Би Бурхан, тэнгэр элч болон хүмүүний өмнө тэр сайн, ариун явдалт, шударга хүн байсан . . . ба түүний хувийн болон олны өмнөх зан төлөв өөгүй байсан, мөн тэр Бурханы хүний хувьд амьдарч, нас барсан’ гэжээ (*The Gospel Kingdom* [1987], 355; мөн С ба Г 135:3-ыг үзнэ үү). Бригам Янг: ‘[Иосеф Смитийг] надаас илүү сайн мэдэх хүн энэ дэлхий дээр байхгүй биз ээ. Есүс Христийг үл тооцвол, энэ дэлхий дээр түүнээс илүү сайн хүн байгаагүй хэмээн би тод томруун хэлж байна’ гэж тунхаглажээ [“Remarks,” *Deseret News*, Aug. 27, 1862, 65].”¹⁹

III. Иосеф Смит ба хууль

Би хууль эрх зүйн түүхийг олон жил судлахдаа тухайн цаг үед Иосеф Смит америкийн хууль эрх зүйн системтэй хэрхэн холбогдож байсныг онцгойлон сонирхсон болохыг дээр дурдсан миний жишээнээс харж болно. Уламжлал ёсоор Иосеф Смит 40 гаруй шүүх ажиллагаанд татагдан орж

байсныг түүхчид өгүүлдэг. Өнөө үед *The Joseph Smith Papers* (Иосеф Смитийн гар бичвэрүүд)-ийг гаргахаар хийсэн ажлын үр дүнд энэ тоо 220-оос давсан болохыг бид мэднэ. Эдгээр хуулийн үйл ажиллагаанд “энгийн мөнгө босгох хэргээс эхлэн хууль зүйн боловсронгуй онол оролцсон илүү нарийн төвөгтэй [зарга] хэргүүд орж байв. Иосеф . . . иргэний болон эрүүгийн [ийм] хэргүүдийн аль алиныг нь үүсгэх, хамгаалах зорилгоор . . . олон өмгөөлөгчтэй байсан.”²⁰

Бошиглогчийн амьдралтай холбоотой баялаг мэдээлэл дээр үндэслэн хожмын үеийн гэгээнтэн эрдэмтэн Жэффри М.Вокер: “Иосеф Смит америкийн хууль эрх зүйн системтэй салшгүй, идэвхтэй, тасралтгүй холбогдож байсныг үгүйсгэхийн аргагүй. Эдгээр чухал үйл ажиллагааг үл тоомсорлох нь тэр цаг хугацаа, эрч хүчээ хэрхэн ухаалаг бөгөөд үр дүнтэй ашиглаж байсныг харахгүйгээр өнгөрөөнө гэсэн үг. Тэр ч бүү хэл Смитийн сайн танил хуульч, шүүгч, мужийн ерөнхий прокурор Даниэль Х.Вэллс өөрийн биеэр ‘Би бүх насаараа хуульчидтай хамт ажиллаж байсан. Иосеф Смит миний мэдэх хамгийн сайн хуульч байсан’ гэж мэдэгдсэн [*The Journal of Jesse Nathaniel Smith: Six Decades in the Early West: Diaries and Papers of a Mormon Pioneer, 1834–1906* (1953), 456]”²¹.

Хожмын үеийн гэгээнтэн гурван зохиолч ийн хураангуйлжээ. “Хууль эрх зүйн системтэй нягт холбогдсоноор Смит тоглоомын дүрмийг хурдан сурсан бөгөөд тэдгээр дүрмийг хууль ёсоор өөрийн талд бүрэн ашиглаж, залуухан улс орны хуулиар олгогдсон шинэ боломж бололцоо, хамгаалалтыг бүрэн ашиглахыг эрэлхийлдэг байжээ. Түүний хууль эрх зүйн сонголт, үйлдэл нь мөн эрх зүйн асуудлын талаар өргөн мэдлэгтэй байсан нь муж улсын хуулийн дагуу Мормоны Номын зохиогчийн эрхийг авах, Огайогийн хуулийн дагуу гэрлэлтийг батлах, Науву хотын дүрмийг гаргаж, шашны эрх чөлөөг бүрэн хамгаалахыг уриалах, муж улсын газрыг арилжаалан худалдах тухай шинэ хуулийг үр ашигтай ашиглах, habeas corpus буюу шүүгдэхийн өмнө баривчлан хоригдогсдын эрхийг хамгаалах, зохих газар нь шүүх хурал явуулахыг шаардах эсвэл муж улсын дампуурлын тухай шинэ хуульд хамрагдах гээд аль ч үед хуулийн хүрээнд хийх боломжтой бүхий л алхмыг ил тод, зохих ёсоор



“Иосеф Смит миний амьдралдаа таньж мэддэг байсан хамгийн сайн хуульч байсан.”

—Ютагийн бүс нутгийн ерөнхий прокурор Даниэл Х.Вэллс

ашиглаж байснаас тод томруун харагддаг. Чөлөөт цагаараа тэрээр хуулийн номуудыг судалдаг байжээ. Тэр үндсэн хуулийн үг хэллэг, муж улсын хуулийн баримт бичгийн хэлийг ягштал мэддэг байв. Амьд байхдаа тэр тухайн үеийнхээ муж болон холбооны улсын хэмжээнд боловсруулан гаргасан хуулийг сайн мэддэг байсан нь гарцаагүй.”²²

Энэ гурван зохиолчийн “Тэрээр шүүгдэгчийн хувьд ямар ч гэмт хэрэгт ял шийтгэл хүлээж байгаагүй юм. Шүүх хурал шударга явагдсан үед түүнийг үлгэр жишээ, зөв шударга иргэн болохыг нь тогтоодог байжээ”²³ хэмээн мэдэгдсэн мэдэгдлийг нэмж дурдъя.

Миний эш татсан номонд сонгож, шинжлэн судалсан бошиглогчтой холбоотой шүүх хурлын нарийн хураангуй мэдээлэл нь энэ сэдвээр хичээл авч, энэ гурван зохиолчийн бичсэн номонд орсон нарийн ажлыг хийсэн Ж.Рүбэн Кларкийн нэрэмжит хуулийн сургуулийн олон оюутны хийсэн ажил дээр суурилагдсан болно. Тэдгээр хуулийн оюутны өгсөн тайлбар миний сонирхлыг татсан юм. Тэд:



“Энэ номын өмнөх хувилбарыг хичээлдээ ашиглаж байсан хуулийн оюутнууд Иосеф нь, ялангуяа шашны болон бусдын иргэний эрхийг хамгаалах эсвэл өөрийн хүлээн авсан үүрэг хариуцлагыг биелүүлэхдээ хариуцлагатай, үүргээ ухаардаг, үнэнч, хашир, энэрэнгүй, болгоомжтой, нямбай, хуулийг чандлан сахидаг, тэвчээртэй, эерэг, авхаалжтай, сүйхээтэй, овсгоотой, хүнийг сайн таньж мэддэг, хуулийн гойд сайн мэдлэгтэй (тэдний ашигласан үгээр бол) байсан гэсэн дүгнэлтэд хүрсэн байжээ. . . . Иосеф Смит үндсэн хуульд хэзээ ч итгэл алдраагүй бөгөөд хэдийгээр тэр хуулийг хэрэгжүүлэгчдэд сэтгэл гонсойн, урам хугарч, болгоомжилдог байсан ч үндсэн хуулийн заалтын доор ажиллахыг үргэлж эрэлхийлдэг байв.”²⁴

IV. Дүгнэлт

Иосеф Смит амьдралынхаа маш богино хугацаанд ямар ч хүнээс илүү их зүйлийг хийж бүтээсэн. Үүнд өгч болох цорын ганц тайлбар бол тэнгэрлэг тусламж юм. Надад дараах товч дүгнэлт таалагддаг.

Тэр Нью-Йоркт Мормоны Номыг орчуулж, хэвлэн гаргаж, Сүмийг зохион байгуулсан; дараа нь Огайо, Миссури, Иллинойст суурьшсан; Көртланд, Фар Вест, Науву гэх мэт хотуудыг барьж байгуулсан; Сүмийн олон зуун удирдагчийг дуудаж, зааж сургасан; еврей хэл, Библийг судалсан; Наувуд Халамжийн нийгэмлэгийг үүсгэн байгуулсан; ганцаараа болон бусадтай хамтран бизнес эрхэлж, нийтлэл болон тэргүүн өгүүлэл бичиж байсан ба өнөр өтгөн гэр бүлтэй, найз нөхөд ихтэй байв; мөн цагдаагийн том цэргийн ангийн ерөнхий командлагч, Науву хотын захирагч ба ерөнхий шүүгч гэх

мэт төрийн хэд хэдэн албанд тус тус алба хашиж байсан. Тэр долоо хоног бүрийн шүтэн бишрэх цугларалт, онцгойлон адислал дээр болон оршуулгын ёслолын үеэр тогтмол үг хэлдэг байсан ба олон арван мянган дагалдагчийг цуглуулан, хөрвөгдсөн цагаачдыг давалгаалуулан, Нэгдсэн Улсад авчирчээ.”²⁵

20 гаруй жилийн өмнө Ерөнхий чуулганаар хэлсэн үгэндээ би:

“Бусад итгэлтэй хожмын үеийн гэгээнтэнтэй адил би ч гэсэн өөрийн амьдралыг бошиглогч Иосеф Смитийн гэрчлэл, үйл хэрэг дээр суурилуулан босгосон. Миний уншсан бүх зүйл, судалгааны эх бичгүүд түүний бошиглолын дуудлага, сайн мэдээнд болон түүгээр дамжуулан сэргээгдсэн Их Эзэний санваарын талаарх гэрчлэлдээ эргэлзэхэд хүргэж байгаагүй. 1842 оны алдарт Wentworth захидалд Иосеф Смитийн хэлсэн гэрчлэлийг би чин сэтгэлээсээ баталж байна:

“ . . . Үнэний жишгүүд тогтоогдсон бөгөөд ямар ч бохир гар энэ ажлыг зогсоож чадахгүй. Хавчлага дарамт гарч ирэн, дээрэмчид нэгдэж, арми цугларч, гүтгэлэг доромжлол ил гарсан ч Бурханы үнэн тив бүрд, улс орон болгонд хүрч, хүн бүрд сонсогдох хүртэл Бурханы зорилго гүйцэлдэх ба улмаар Аугаа Иехова ажил дууслаа хэмээн хэлэх хүртэл зоригтой, нэр төртэй, юунаас ч үл хамааран урагшлах болно” (*Times and Seasons*, 1 March 1842, 709; quoted in Daniel H. Ludlow, ed., *Encyclopedia of Mormonism*, 5 vols. [1992], 4:1754).”²⁶

Ах, эгч нар аа, би Эцэгтэй хамт бяцхан бошиглогч дээр ирж, мөн Эцэг нь “Энэ бол Миний Хайртай Хүү. Түүнийг сонс!” гэж хэлсэн Аврагч Есүс Христийн талаар гэрчилж байна (Иосеф Смит—Түүх 1:17). Бид мөн тэр цагаас эхлэн Их Эзэн Есүс Христийг илчлэлтээр сонсох болсон. Энэ бол Түүний Сүм юм. Бид Түүний ариун санваарын эрх мэдлийг атгадаг билээ. Бид түүний зорилгын төлөө урагшилдаг. Би бошиглогч Иосеф Смитийн дуудлага болон та бүхний гар бие оролцдог энэхүү агуу ажлыг хүлээн авсан бошиглогчдын дуудлагыг гэрчилж байна. ■

2018 оны 6-р сарын 25-нд Номлолын удирдагчдад зориулсан семинар дээр хэлсэн “Иосеф Смит: Бошиглогч хийгээд энгийн хүн” үгээс авав.

1844 оны 6-р сарын 27-нд бошиглогч Иосеф Смит өөрийн ах Хайрумтай хамт амиа алдахдаа 38 настай байв.





“Бурханы үнэн тив бүрд, улс орон болгонд хүрч, хүн бүрд сонсогдох хүртэл Бурханы зорилго гүйцэлдэх ба аугаа Иехова ажил хийгдэж дууслаа гэж хэлэх хүртэл зоригтой, нэр төртэй, юунаас ч үл хамааран урагшлах болно.”

—*Joseph Smith, in the Wentworth letter, March 1, 1842*

ЭШЛЭЛҮҮД

1. Russell M. Nelson, *Accomplishing the Impossible* (2015), 1–2.
2. “Тэр хүнийг магтъя,” *Сүмийн дуулал болон хүүхдийн дуу*, х. 50.
3. *Миний сайн мэдээг номло: Номлогчийн үйлчлэлд зориулсан удирдамж* (2004), 37-г үзнэ үү.
4. Richard Lyman Bushman, *Joseph Smith: Rough Stone Rolling* (2005), 105.
5. Russell M. Nelson, in Sarah Jane Weaver, “President Nelson Shares the ‘Hopes of My Heart’ with New Mission Leaders,” *Church News*, June 26, 2018, news.lds.org.
6. *Миний сайн мэдээг номло*, 103; мөн Мормоны Номын удиртгал-ыг үзнэ үү.
7. Gary C. Lawrence, *How Americans View Mormonism: Seven Steps to Improve Our Image* (2008), 32.
8. Gary C. Lawrence, *How Americans View Mormonism*, 42-ыг үзнэ үү.
9. Энэ болон 10 дахь эшлэлийн бичвэрийг Даллин Х. Өүксийн, “Joseph Smith in a Personal World,” in John W. Welch, ed., *The Worlds of Joseph Smith: A Bicentennial Conference at the Library of Congress* (2006), 159-аас авсан болно.
10. *Сүмийн Ерөнхийлөгчдийн сургаалаас: Иосеф Смит* (2007), 522.
11. Mary Alice Cannon Lambert, in “Joseph Smith, the Prophet,” *Young Woman’s Journal*, Dec. 1905, 554.
12. Dallin H. Oaks, “Joseph, the Man and the Prophet,” *Ensign*, May 1996, 72.
13. Dallin H. Oaks, “The Suppression of the *Nauvoo Expositor*,” *Utah Law Review*, vol. 9, no. 4 (1965), 862–903-ыг үзнэ үү.
14. Dallin H. Oaks and Marvin S. Hill, *Carthage Conspiracy: The Trial of the Accused Assassins of Joseph Smith* (1975)-ийг үзнэ үү.
15. Dallin H. Oaks and Joseph I. Bentley, “Joseph Smith and Legal Process: In the Wake of the Steamboat Nauvoo,” *BYU Law Review*, vol. 1976, no. 3 (1976), 735–782-ийг үзнэ үү.
16. David Herbert Donald, *Lincoln* (1995), 94–118-ийг үзнэ үү.
17. Dallin H. Oaks and Joseph I. Bentley, “Joseph Smith and Legal Process,” 781-ийг үзнэ үү.
18. Gordon A. Madsen, Jeffrey N. Walker, and John W. Welch, eds., *Sustaining the Law: Joseph Smith’s Legal Encounters* (2014), x–xi.
19. Dallin H. Oaks, “Joseph, the Man and the Prophet,” 73.
20. Jeffrey N. Walker in Gordon A. Madsen and others, eds., *Sustaining the Law*, vi.
21. Jeffrey N. Walker in Gordon A. Madsen and others, eds., *Sustaining the Law*, vii.
22. Gordon A. Madsen and others, eds., *Sustaining the Law*, xvii.
23. Gordon A. Madsen and others, eds., *Sustaining the Law*, xvii–xviii.
24. Gordon A. Madsen and others, eds., *Sustaining the Law*, xviii.
25. Gordon A. Madsen and others, eds., *Sustaining the Law*, xi–xii.
26. Dallin H. Oaks, “Joseph, the Man and the Prophet,” 73.

Сонирхогчид модноос бууж ирэх болно

1995 онд Аргентины Буэнос Айресын гудамжаар сонирхогчдыг олохоор явдаг номлогч-дод “Хэрэв та нар шаргуу хөдөлмөрлөж, бүхий л тал дээр дуулгавартай байх юм бол сонирхогчид модноос унаж ирэн баптисм хүртэх болно” гэж Бүсийн ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүнээс хүлээн авсан амлалт хачирхалтай санагдаж байсан байх. Бид уг амлалтын талаар удалгүй олж мэдсэн юм.

Аав маань гэрийнхээ явган хүний замын дагуу байх нэг модыг тайрч

байлаа. Тэр модоо дээрээс нь тайрч байхдаа гудамжаар хоёр залуу алхаж байхыг олж харав. Модны доогуур өнгөрөхөд нь аав тэднийг англиар дууджээ.

Аав маань үнэндээ англиар ярьдаггүй ч хэдхэн үг мэддэг байсан ба тэд сонирхлыг нь татсан байв. Тэд юун залуучууд вэ, манай энд юу хийж байгаа юм бол?

Номлогчид ч зогтусан, хаана дуугараад байгаа юм бол гэж гайхав. Аав маань модноос бууж ирээд, тэдэнтэй ярьсан юм. Тэдний хүргэж буй захиас,

биеэ авч яваа байдал зэрэг нь өндөр сэтгэгдэл төрүүлсэн тул тэр тэднийг гэртээ урив.

Шашин шүтлэгтэй холбоотой аавын маань өмнөх туршлага тун таагүй байсан хэдий ч сэргээгдсэн сайн мэдээний тухай захиас зүрх сэтгэлийг нь хөнджээ. Тэр амьдралдаа хүнд хэцүү үеүдийг туулсан бөгөөд өөрчлөгдөх хэрэгтэй гэдгээ мэдэж байсан юм. Номлогчдыг түүнд болон ээж, эмээ хоёрт маань мөн надад зааж байхад тэр чих тавин сонсдог байв.

Аав маань модоо дээрээс нь тайрч байхдаа гудамжаар хоёр залуу алхаж байхыг олж харав.



Би дөнгөж 11 настай байсан ч тэдний заасан үнэн миний төдийгүй ээж, эмээ хоёрын маань зүрх сэтгэлд бас хүрсэн юм. Үүний үр дүнд бид бүгдээрээ 1995 оны 9-р сард баптисм хүртэж билээ.

Бидний зүрх сэтгэлд номлогчдын суулгасан итгэлийн үрийг удалгүй сүмийн найз нөхдийн нөхөрлөл, сайн мэдээний нэмэлт хичээлүүд, хүчирхэг Сүмийн удирдагчидтай хамт хуримтлуулсан сайн туршлагауд тэжээсэн юм. Биднийг халуун дулаан хүлээн авсан учраас итгэлийн маань үр “сайн хөрсөнд унаж, ургаад, зуу дахин илүү ургац өг[сөн]” (Лук 8:8).

Бараг 25 жил өнгөрсөн ч хүлээн авсан итгэлийн маань үр жимсэнд Есүс Христийн сэргээгдсэн сайн мэдээнд итгэх бат бөх итгэл үнэмшил, ариун сүмийн адислалууд, мөнхөд холбогдсон гэр бүлийн шинэ үеийнхэнтэйгээ хамт бүрдүүлсэн бүрэн бүтэн бөгөөд аз жаргалтай амьдрал ордог.

Сүнсээр өдөөгдсөн амлалтыг сорихоор шийдсэн хоёр номлогчид бид үргэлж талархах болно. ■

**Амила Каминос,
Аргентины Буэнос Айрес**

Айдсаа орхин, Бурханы үгэн дээр найрлах болсон нь

Би бүхий л амьдралынхаа туршид Сүмд идэвхтэй байлаа. Би бүрэн цагийн номлолд үйлчлэн, ариун сүмд гэрлэж, дөрвөн гайхалтай сайхан



охиныг өсгөхөд тусалсан. Гэхдээ он жилүүд өнгөрөх явцад зарим найз маань Сүмийн гишүүн байхаа больсныг би ажиглав. Зарим гэр бүлийн гишүүд маань олон нийтийн хэрэгслээр Сүмийн удирдагчдад эргэлзэж байгаагаа илэрхийлж, шүүмжлэх болжээ. Би ч гэсэн амьдралдаа анх удаа Сүмийн талаар эргэлзэж эхэллээ. Эргэлзээ маань ирээдүйгээсээ айхад хүргэв. Заримдаа ямар ч итгэл найдваргүй байдалд орсон мэт санагддаг байлаа.

Энэ хүнд хэцүү үед би өөрийгөө хүчлэн, гадасны чуулганд очив. Гадасны ерөнхийлөгч маань “Хэрэв бид өмнөө байх хүнд хэцүү цаг мөчийг даван гарья гэж бодож байвал Бурханы үгээс хайхрамжгүй хүртдэг байхаа больж, үүн дээр нэн даруй найрладаг болох хэрэгтэй. Бид судраас тогтмол, анхаарлаа төвлөрүүлэн суралцах үйл явцыг амьдралынхаа нэн чухал хэсэг болгох хэрэгтэй. Ийнхүү хийж чадах юм бол бид айх хэрэггүй гэдгийг амлаж байна” гэсэн юм.

“Айх” гэдэг үг миний анхаарлыг татаж билээ. Би сайн мэдээг хайхрамжгүй судалдаг болсноо ухаарав. Үүний үр дүнд айдас амьдралыг маань эзэмдсэн байлаа. Би гадасны ерөнхийлөгчийнхөө зөвлөгөөг туршиж үзэхээр шийдсэн юм.

Өрөөнийхөө мухарт би тухтайхан сандалтай жижигхэн ширээ байрлуулаад, залбиран, сайн мэдээнээс суралцаж эхлэв.

Би гэртээ хариад, сайн мэдээг судлах орон зай гаргав. Өрөөнийхөө мухарт би тухтайхан сандалтай жижигхэн ширээ байрлууллаа. Би Аврагчийн хэдэн зургийг хананд байрлуулж; судар, харандаа, тэмдэглэлийн дэвтэр цуглууллаа. Би сургалтаа залбирч эхлүүлэв.

Нэг, хоёр долоо хоног өнгөрсний дараа би өдөр бүр судалдаг дадал хэвшилтэй болсон. Би эхлээд Ерөнхий чуулганы үгээс сонсож, дараа нь сайн мэдээний тодорхой сэдвийг судалдаг байв. Тэгээд дараа нь Мормоны Номын хэдэн бүлгийг уншаад, Тэнгэрлэг Эцэгтээ чин сэтгэлээсээ залбирснаар өндөрлөдөг байсан.

Янз бүрийн зүйлс анхаарлыг маань сарниулдаг байсан ч би зургаан сарын турш бараг өдөр алгасалгүй сайн мэдээг судалсан юм. Би сайн мэдээний төрөл бүрийн сэдвээр илүү гүн гүнзгий ойлголттой болж, тогтмол, чин сэтгэлээсээ залбирснаар Тэнгэрлэг Эцэгтэйгээ өөрийн харилцааг бэхжүүлж чадсан билээ.

Би гэрчлэлдээ дахин тулгуурлаж чаддаг болж эхлэв. Сэргээгдсэн сайн мэдээний талаар хүлээн авсан шинэ гэрчийнхээ ачаар эргэлзээ маань замран алга болсон. Би Бурханд илүү их найдах болсон тул санаа зовох маань багасаж байгааг анзаарсан. Айдас, мухардмал байдал намайг орхихыг би мэдэрч, цагийг дэмий өнгөрүүлдэг үйл ажиллагаануудыг сонирхохоо больж, бусдад илүү их өгөөмөр, эелдэг ханддаг болсноо анзаарав.

Гадасны ерөнхийлөгчийнхөө зөвлөгөөг анхаарч сонссоноор Бурхан намайг өөрчилж чадсан юм. Намайг Түүний үгэн дээр найрлахад Тэрээр Өөрийн биеэр намайг эдгээж, сэргээсэн. ■

Мэтт Максвэлл, АНУ, Юта



Бид бүтэн өдөржингөө шаргуу хөдөлмөрлөсөн. Бид өлсөж байв. Мөнгө олсон нь үйлчлэлийн маань адислал байсан ч юм бил үү.



Гэхдээ би өлсөөд байна!

Нэг бороотой өдөр Колумбид номлолд байхад хамтрагч бид хоёрт гэртээ очих хүртэл ганцхан цаг үлдсэн байв. Бид өдөржин алхсан тул ядарч, өлссөн байв. Бид заах ямар ч хүн олсонгүй.

Бид мөн мөнгөө авч гараагүй, бас хүнсний дэлгүүрээс хоол хүнсээ цуглуулаагүй байв. Гэрт очиход бидэнд идэх ямар ч хоол унд байхгүй гэдгийг бид мэдэж байлаа. Би тэдгээр сөрөг бодлоо хойш тавиад, ажилдаа анхаарлаа төвлөрүүлэхийг хичээж байлаа.

“Би юу олсныг хараач!” гэж хамтрагч маань гэнэт уулга алдлаа.

Тэр газраас мөнгө олсон байв. Надтай адил бодол түүнд төрснийг би царайнаас нь харж байлаа. Би идэх юм худалдан авч болох байв!

Гэхдээ хэдэн мөч өнгөрсний дараа хамтрагч маань “Энэ мөнгө биднийх биш” гэлээ.

“Гэхдээ би өлсөөд байна!” гэж би бодсон.

“Хэнийх ч байсан, ийм оройн цагаар бид түүнийг олохгүй” гэж би түүнд хэлэв.

Тэр хамтдаа залбирахыг санал болголоо. Ингэх нь зөв болохыг би мэдэж байсан ч дотроо солиорол гэж бодож байв. Бид бүтэн өдөржин шаргуу хөдөлмөрлөсөн. Бид өлсөж байв. Мөнгө олсон нь үйлчлэлийн маань адислал байсан ч юм бил үү.

Гэтэл ээж минь санаанд орж ирэв. Бага байхад ээж минь эгч бид нарт ямар ч үед үнэнч шударга байхыг заадаг байсан юм. Тэр бидэнд үлгэр жишээ болсон бөгөөд биднийг үнэнч шударга байх зүрх зоригтой байгаасай хэмээн залбирдаг байлаа. Хэрэв тэр энд байсан бол зөв шийдвэр гаргагчид минь дурамжхан байх байсан гэдгийг би мэдэж байв.

Тиймээс бид залбирлаа. Бид Тэнгэрлэг Эцэгээс эзнийг нь олж өгч туслаач хэмээн гуйв. Хэдэн минутын дараа нэгэн залуу ирж, юм хайж байгаа бололтой харагдав. Түүний нүдэнд

нулимс цийлгэнэж, сэтгэлээр унасан бололтой харагдлаа. Би хамтрагчтайгаа хамт түүн рүү дөхөж очоод, түүний хайж байсан зүйлийг өгсөн юм.

Бид түүнд мөнгийг нь эргүүлэн өгч, тэр ч бидэнд ахин дахин талархлаа. Тэр энэ мөнгөөр коллежийн төлбөрөө төлөх гэж байснаа хэлэв. Энэ мөнгөгүйгээр тэр бүртгэлээсээ хасагдах байлаа. Нүд маань нулимсаар дүүрч, өмнө нь мөнгийг үрэхийг хүсэж байсан тул би наманчлав. Бид холбоо барих мэдээллийг нь авсан ба түүнээс гадна таван хүнд заах боломж тохиосон. Тэр орой би хамтрагчдаа сайн үлгэр жишээ үзүүлсэнд нь талархаж билээ.

Биднийг зөв шударга байвал Сүнс адисалдаг гэдгийг би мэднэ. Тэр орой бидэнд идэх ямар ч хоол байгаагүй ч би орондоо өлсгөлөн орсноо огтхон ч санадаггүй. Мөнгө олсон нь эцсийн эцэст адислал байсан юм. ■

**Исадора Маркиз Гарсиа,
Бразилын Сан Пауло**

Зуух маань итгэлээр халж байв

Нөхөр бид хоёр бага насны таван хүүхэдтэйгээ Нэгдсэн Улсын зүүн эрэгт, тосон зуухаар халаадаг байшинд амьдардаг байсан юм. Тосны түвшинг шалгахын тулд бид хэмждэг савааг тосны саванд нь хийдэг байлаа. Тосны түвшин багассан бол бид дулааны тосны компанитай холбогдож дүүргүүлдэг байв.

Ер бусын хүйтэн 1-р сард бид санхүүгийн асуудалтай тулгарчихаад байв. Би орлогоо нэмэхээр хоолны газар хагас цагаар оройгоор ажиллаж байсан ч амьдралаа арай ядан залгуулдаг байлаа. Эцэст нь бүр аравны нэгийн өргөлөө өгөх үү эсвэл байшингийнхаа дулааны төлбөрийг хийх үү гэдгийн аль нэгийг сонгох хэрэгтэй болов. Тосныхоо түвшинг хэмжихэд тос 2 инч буюу 5 см хүрч байлаа. Энэ нь ганц хоёрхон өдөрт л хүрэхээр байв. Гэсэн ч бид Их Эзэнд итгэж, аравны нэгээ төлөхөөр шийдлээ.

Дараагийн өдөр Марк тосоо дахиад хэмжив. 2 инч хэвээр л байлаа. Марк дараагийн өдөр дахин хэмжихэд 2 инч л байв. Зуух ажиллаж байсан ч тосны хэмжээ буурсангүй. Дараагийн хоёр өдөр ч гэсэн тосны хэмжээ 2 инч хэвээр байв. Оройдоо дулаан өгч эхлэхийг сонсоод би уйлж байснаа санадаг. Зуух маань тосоор биш, харин итгэлээр халж байлаа.

Биднийг тосныхоо түвшинг хэмжихэд тос 2 инч буюу 5 см хүрч байлаа. Энэ нь ганц хоёрхон өдөрт л хүрэхээр байв.

Бошиглогч Елиаг хооллож, “савандахь гурил ч, мөн домбон доторх тос ч дууссангүй” (1 Хаан 17:16) гэдгийг олж мэдсэн бэлэвсэн эмэгтэйтэй адил сэтгэгдэл надад төрж байв. Цалин буух өдөр болоход Марк тосоо дахин нэг удаа хэмжсэн юм. Энэ удаа харин 1 инч буюу 2,5 см байв. Энэ удаад тосны түвшин багассан байсан ч бид саваа тосоор дүүргэх мөнгөтэй болсон байлаа.

Манай гэр бүл Малахи 3:10-т байх “Миний өргөөнд хоол хүнс байхын тулд бүхий л аравны нэгээ агуулахад авчир. Би та нарын төлөө тэнгэрийн цонхыг нээж, та нарын төлөө ивээлийг хальтал асгах эсэхийн талаар Намайг одоо үүгээр шалга гэж түг түмдийн ЭЗЭН айлдаж байна” гэсэн Их Эзэний өгсөн амлалтыг шалгасан юм.

Аравны нэгийн өргөлөө өргөснөөр ирэх адислалд эргэлзэж буй ямар ч хүнийг би “Намайг одоо үүгээр шалга” гэсэн Их Эзэний урилгыг хүлээн авахад урамшуулах гэсэн юм. Аравны нэгийг төлөх нь тэнгэрийн үүд хаалгыг нээдэг бөгөөд бид Их Эзэний хууль, зарлигуудыг дуулгавартай дагаж, итгэлтэй байснаар олон талаар адислагддаг.

Тосоор халдаг зуух маань тосоор биш, итгэлээр халж байсныг гэр бүлийнхэн маань хэзээ ч мартажгүй. ■
Луис Мансиус, АНУ-ын Техас муж

Өөрсдийн өмхий хүрэнгийн арьсыг өвчиж сурсан нь (хийх ёстой зүйлээ өөрөө хийж сурах нь)

Бие даасан байдлын талаар бодох бүрд надад номлолын ерөнхийлөгчийн маань хэлсэн “Өөрсдийн өмхий хүрэнгийн арьсыг өөрсдөө өвчиж сур” гэх хэллэг санаанд орж ирдэг. Тийм ээ, энэ нь хачирхалтай хэллэг ч өөрсдөд тулгарсан зүйлийг бусдад үүрүүлэхийг хүсэж болдоггүй **хүнд хэцүү зүйлс амьдралд тохиолддог** гэсэн энэ санаанд олон үнэн агуулагддаг.

Тиймээс бид сэтгэл зүйн хувьд бие даахын тулд хэрхэн “өөрсдийн өмхий хүрэнг өөрсдөө өвчиж” болох вэ? Бид урам хугарах байдалд хэрхэн хандаж, **бүх сэтгэл хөдлөлөө хэрхэн удирдаж сурах вэ?**

Аз болоход биднийг хоосон орхиогүй бөгөөд бидэнд хангалттай эх сурвалжууд бий. Бид тэдгээрийн заримыг “Сэтгэл зүйн эрүүл мэндээ сайжруулах 14 арга зам” нийтлэлээс олж мэдэх болно. Хамгийн чухал нь зарлиг, тушаалуудыг сахиснаар **бид амьдралаа хялбарчлах боломжтой** (44-р хуудсыг үзнэ үү).

Бидний амьдралд тохиолддог бүх зүйлд хариулж сурна гэдэг бол үйл явц юм. Сэтгэл санааны бие даасан байдал гэдэг нь бид хүссэн зүйлээ үргэлж мэдрээд байхыг хэлдэггүй. Энэ нь Есүс Христийн ач ивээлээр мөн өөрсдийн хүчин чармайлтаар **бид сэтгэл хөдлөлөө эрүүл бөгөөд үр бүтээлтэй арга замаар удирдах боломжтой болно** гэсэн үг юм. Ерөнхийлөгч М.Рассэлл Баллард энэхүү тэнцвэртэй байдалд хэрхэн хүрэх талаар зарим бодит зөвлөгөөг бидэнд өгсөн.

Сэтгэл санааны хувьд бие даасан байхыг эрэлхийлэх үед бидэнд сул дорой болжмор шувуу мэт мэдрэмж төрж магадгүй (46-р хуудсыг үзнэ үү), гэвч бид хүчин чармайлт гаргаж, Тэнгэрлэг Эцэгтэй хамтрах юм бол хэзээ нэгэн цагт “бүргэд мэт жигүүр дээрээ элин хали[x]” (Исаиа 40:31) ба энэ нь “өөрсдийн өмхий хүрэнгийн арьсыг өөрсдөө өвчих” хүчтэй байх болно гэдгийг уран сайхан үгээр хэлж байгаа юм.

Хүндэтгэсэн,

Heather Johnson

ТҮҮХЭЭ ХУВААЛЦ

Танд хуваалцах гайхалтай түүх байна уу? Эсвэл та ямар нэгэн сэдвээр бичсэн нийтлэл уншихыг хүсэж байна уу? Хэрэв тийм бол бид таныг сонсохыг хүсэж байна! Та нийтлэл болон санал хүсэлтээ liahona.lds.org руу илгээнэ үү.

ХАМГИЙН САЙН ЗӨВЛӨГӨӨ...

Залуучууд өөрсдийн оюун санаа, сэтгэл зүйн эрүүл мэндэд анхаарал тавих талаар хүлээн авсан хамгийн сайн зөвлөгөөгөө хуваалцав.

“Биеийн дасгал хийж, тархиа амраан, хор хөнөөлтэй бодол санаа, мэдрэмжээсээ салахад цаг зав гарга.”

—*Брианна Форрестэр, АНУ, Вашингтон*

“Мэргэжилтэнд хандахаас бүү эмээ. Би мэргэжлийн болон сүнслэг тусламж хүлээн авснаар өөрийн амьдралаар амьдарч чадсан ба одоо Их Эзэнд үйлчлэх номлолын дуудлагаа хүлээж байна.”

—*Нэйт Сийл, АНУ, Юта*

“Амьдралаа Христ дээр төвлөрүүлэхийн зэрэгцээ бүх сайн сайхан зүйлийг зохих хэмжээгээр хий.”

—*Нэн Круз, АНУ, Луизиана*

“Сайн унтаж амрахаа бүү март. Энэ нь инээдтэй сонсогдож болох ч үнэхээр чухал зүйл юм.”

—*Сидний Смит, АНУ, Калифорни*

Та өөрөө өөртөө хэт хатуу хандахгүй байх талаар ямар сайн зөвлөгөө хүлээн авсан бэ? Өөрийнхөө хариулыг iahona.lds.org руу 2019 оны 1-р сарын 31-ээс өмнө илгээнэ үү.

ТАНД ЗОРИУЛСАН ӨӨР ЗҮЙЛС

Долоо хоног тутам гарах цахим эх сурвалжийг Gospel Library аппликэйшний залуучуудад зориулсан хэсгийн “Залуучуудад зориулсан долоо хоног тутмын нийтлэл” хэсгээс авна уу. Мөн биднийг [facebook.com/iahona](https://www.facebook.com/iahona) хаягаар дагаж, зөвхөн онлайн-тавигдах нийтлэл, нэмэлт агуулгыг авна уу.

Лори Фуллэр нь *Friend* сэтгүүлийн редактороор ажилладаг. Тэр шинэ хамтлагуудыг олж, радиогоор мэдээ сонсон, дэлхийн олон орны хоолыг хийх дуртай. Заримдаа тэр нийтлэл бичдэг.



Валэри Дюрант нь АНУ-ын Калифорнид амьдардаг бөгөөд нөхөр Райантайгаа



гэрлээд 4 жил болж байгаа. Тэр саяхан бяцхан хүү төрүүлсэн. Тэр йогоор хичээллэх, зураг зурах, ном унших, ууланд алхах дуртай.

Хээдэр Ж.Жонсон

нь нийтлэгч, редактороор ажилладаг. Тэр усан цанын спортоор хичээллэх, өвлийн цагт уулаар аялах дуртай. Тэр английн зохиолчдын уран бүтээлийг илүүд үздэг ба “Y'all” гэдэг үгийг өдөр тутмын яриандаа хэрэглэх хэрэгтэй гэж үздэг.



Дэйв Кларк нь эхнэр, хүүхдүүдтэйгээ цагийг өнгөрүүлэх дуртай.



Тэр нягтлан бодох мэргэжлийнхээ дагуу тооцоолон бодох ажлаа хийгээгүй байгаа үедээ чөлөөт цагаа агаарт гүйх, унадаг дугуй унах, сагсан бөмбөг тоглох зэрэгт зарцуулдаг.

ЗАЛУУЧУУДАД ЗОРИУЛАВ



ЭНЭ ХЭСЭГТ

- 44 **Сайн мэдээ: Мөнх амьдралын арга ухаан**
Лори Фуллэр
- 46 **Надад нисэхийг заагаач: Их Эзэний арга замаар сэтгэл зүйн хувьд бие даах нь**
Валэри Дуррант
- 48 **Амьдралын хэрэгцээ шаардлагыг тэнцвэржүүлэх 8 зөвлөгөө**
Ерөнхийлөгч М.Рассэлл Баллард

ЗӨВХӨН ОНЛАЙНААР

Өөрт тохирсон сэтгэл зүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлдэг мэргэжилтэнг олох нь
Кэвин Тэриот

Сэтгэл зүйн эрүүл мэндээ хэвийн байдалд буцаан оруулах 14 арга зам
Хээдэр Ж.Жонсон

Би яагаад сэтгэл зүйн эрүүл мэндийн зөвлөгөө авахаас айхаа больсон бэ?
Дэйв Кларк





САЙН МЭДЭЭ

Мөнх амьдралын арга ухаан

Лори Фүллэр

Сүмийн сэтгүүл

Зарлигуудыг дагах нь яагаад бидний амьдралыг хавьгүй амар хялбар болгодог юм бол гэсэн бодол танд төрж байсан уу?

Сарын өмнө би хэдэн найзтайгаа хамт өнгөрсөн долоо хоногт болж өнгөрсөн зүйлээ ярилцан суусан юм. Нэг найз маань ээжийгээ архины донтолтоос гаргахад ямар хэцүү байгаагаа хуваалцсан. Тэр надаас дүү байсан бөгөөд тэр нь хамгийн хүнд ажил юм шиг сонсогдож байлаа.

Орой нь бид тамхи татахад ямар их мөнгө зарцуулдаг болох мөн бидний таньдаг хүн өдөрт л нэг хайрцгийг татаж дуусгадаг талаар ярьж эхлэв. (Тооцоолж үзээрэй, ямар их мөнгө гээч!) Тэр тамхинаас гарах гэж оролдож байгаа ч гарч чадахгүй байв. Харин хүү нь тамхинаас гарч байгаад нь баярлаж байгаа аж. Аав нь хар тамхи хэтрүүлэн хэрэглэснээс болж нас барсан тул хүү нь ямар ч хорт бодисноос илүү ихээр айдаг болсон байна.

Эцэст нь бидний яриа кофегоор өндөрлөлөө. Хүмүүс өглөө бүр (мөн өдөр, заримдаа бүр орой) кофег хэр их хэрэглэдэг мөн тэд одоо латтегаа өдөр бүр авч ууж чадахгүй байгаа тул түүнийгээ хэр их санагалзаж байгаагаа ярьцгаав.

Би гэр лүүгээ машинаа барин явах зуураа тэр бүх ярианы талаар бодонгоо “Мэргэн ухааны үг үнэндээ амьдралын хамгийн чухал арга ухаан” юм байна гэж бодов. (Хэрэв та “амьдралын арга ухаан” гэж юу болохыг мэдэхгүй бол энэ нь амьдралыг тань сайжруулж, илүү үр дүнтэй болгодог арга зам юм. Онлайнд хэн нэгний тайлбарласнаар бол амьдралын арга ухаан гэдгийг





өмнө нь “сайн санаа” гэдэг байжээ.) Энэ нь Бурхан “Энэ бол мөнгөө хэмнэх, эрүүл байж, үр хүүхдээ хамгаалан, өөрийн болон бусдын донтолтоос үүдэлтэй сэтгэл санааны бодит хүнд ачаанаас салахад туслах арга зам” гэж хэлж байгаа мэт. Энэ нь яг л Бурхан бидэнд тулгарах бүх асуудлыг мэдэж байсан тул тэдгээрийн хагасаас нь салгах арга замыг өгсөн мэт. . . .



Бурханы аль ч зарлигийн хувьд бид тэдгээрийг дагах эсвэл үл ойшоох сонголтыг хийж чадна. Гэхдээ би Мэргэн ухааны үг нь биднийг олон сорилт бэрхшээлээс сэрэмжлүүлэн, хамгаалдаг Бурханаас өгсөн дүрэм журам юм байна гэж тунгаан бодох үедээ “Бурханы бүх зарлиг ийм арга замаар ажилладаг болов уу?” гэж бодсон. Биднийг хайрладаг, энэ амьдралыг болон саад бэрхшээлийг Өөрийн биеэр туулсан Тэнгэрлэг Эцэг дэлхийг аль болох зовлон бэрхшээл багатайгаар үзэн туулахад туслах удирдамж зааварчилгааг бидэнд өгсөн ч юм бил үү? Мөн Тэрээр биднийг хайрладаг мөн хамгаалахыг хүсдэг учраас тэдгээрийг өгсөн ч юм бил үү?

Байгаадаа сэтгэл хангалуун, аз жаргалтай, баяр талархлаар дүүрэн байхыг

хүсэж байна уу? “Чи хөршийнхөө гэр оронд бүү шуна” (Гэтлэл 20:17).

Гэм буруутай мэдрэмж, эрх чөлөөгөө хасуулах, амьдралыг зэрэмдэглэдэг батлан даалтын төлбөр, шүүхийн хураамж зэргээс зайлсхийхийг хүсэж байна уу? Хүмүүсийн итгэл, хүндлэл, ажил төрлөө авч үлдэхийг хүсэж байна уу? “Чи бүү хулгайл” (Гэтлэл 20:15).

Бурхантай ойрхон байж, Түүний удирдамж, зааврыг хүлээн авч, ачаагаа хөнгөлүүлэхийг хүсэж байна уу? “Чи бүх зүрх, бүх сэтгэл, бүх оюунаараа өөрийн Бурхан Эзэнээ хайрла” (Матай 22:37).

Жагсаалтыг энэ маягаар үргэлжлүүлж болно. Зарлиг бүр биднийг сэтгэлийн шаналлаас хамгаалж, амьдралыг маань хөнгөвчилж, асуудлаас хол байлгаж, эсвэл зүгээр л амар амгаланг олоход тусалж болно. Харин энэ бүхнээс хувийнхаа зүгээс маш бага золиослол, зардал гаргаж байж хүртэх боломжтой. (Бас далд төлбөр байхгүй гээч!)

Би Бурханы зарлигуудыг жирийн нэгэн амьдралд тустай арга ухаан болгон жижгэрүүлэх гэсэнгүй. Тэдгээр нь үүнээс хавьгүй агуу гэдэг нь мэдээж. Үүний зэрэгцээ тэдгээр нь бас маш энгийн. Тэнгэрлэг Эцэг биднийг бүхнээс




хамгаалж чадахгүй. Харин хайртай эцгийн хувьд Тэрээр биднийг сонголынхоо үр дагаварт бэлдэж, тэдгээрээс хамгаалан, илүү сайн хүн болоход биднийг удирдан залахыг хүсдэг.

Мэдээж, зарлигуудыг дагасан ч муу зүйл тохиолдож болно. Тийм байхад дагах хэрэгтэй гэж үү?

Яагаад гэвэл, бид дуулгавартай байснаар өөрсдийгөө юунаас хамгаалуулж байгаагаа хэзээ ч мэдэхгүй байх болно. Энэ нь бас биднийг өөрсдийгөө шархлуулдаг амьдралаас зайлсхийхэд тусалдаг. Дуулгавартай байдал нь мөн бидэнд Бурхантай ойр үлдэхэд тусалдаг. Түүнчлэн энэ нь бидэнд бурууг сонгосон үедээ наманчлах боломжийг олгодог. Мөн бид Бурхан биднийг хэрхэн адисалж, хамгаалахаа мэднэ гэдэгт итгэдэг.

Жагсаалтыг энэ маягаар үргэлжлүүлж болно. Энэ жагсаалт нь зарлигуудыг дагахгүй байх шалтгааны жагсаалтаас хамаагүй урт юм.

Юу ч болж бай, Бурхан бидэнд хэр дуулгавартай байхаа сонгох сонголтыг өгсөн. Би Түүний надад бэлдсэн адислалуудаас хүртэхэд өөрийгөө хэрхэн нээхээ сонгож болно. Тиймээс яагаад зарлигуудыг дагах хэрэгтэй вэ? Яагаад гэвэл, би өөрийн амьдралыг Бурханы өгөх гэсэн тусламжийг хүлээн авахад хангалттай өргөн нээхийг хүсэж байна. ■



Бид сэтгэл зүйн хувьд бие даах зорилгодоо хүрэхийн тулд Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христэд итгэж найдан, өөрсдийн зүгээс хүчин чармайлт гаргах ёстой.

Надад нисэхийг заагаач

Их Эзэний арга замаар сэтгэл зүйн хувьд бие даах нь

Валэри Дуррант

Бид нисэх гэж оролдож буй бяцхан шувуухайн талаар бодох үедээ хамгийн сүүлчийн баатарлаг оролдлогыг нь олонтоо хардаг. Дэгдээхэй үүрнээсээ далавчаа дэвсээр гарч ирэн, далавчаа дэлгэж, тэнгэр өөд нисэн оддог. Амжилттай нисэж суртал тэрээр тэнгэр өөд нисэхийнхээ өмнө олон удаа бүтэлгүйтэж, газарт унаж байв.

Нисэж сурч буй шувуутай адил бид ч гэсэн сэтгэл зүйн хувьд бие даахын тулд ахин дахин унаж магад. Харин бид Их Эзэнд хандан тусламж гуйж, хүчин чармайлт гаргах юм бол, амьдрал бидний төлөвлөснөөр болохгүй үед бууж өгөлгүй мөн сорилт бэрхшээлийг ганцаар үүрэхэд хэцүү болох үед Түүнд найдаж болно.

Нисэж сурах нь

Нисэж сурах үйл явц хэцүү байж болох ч яагаад шувуу эхлээд үүрээ орхидог вэ? Яагаад гэвэл, ээж нь түүнийг шахан шаарддаг юм. Хүүхдийнхээ амьдралын эхэн үед эх шувуу идэх хоолыг нь үүрэнд нь шууд авчирч өгдөг. Харин цаг хугацаа өнгөрсний дараа тэр хоолыг нь үүрний гадна тавьж эхэлдэг бөгөөд дэгдээхэйнүүд нь хоолоо идэхийн тулд тав тухтай газраа орхин гарах хэрэгтэй болдог юм.

Энэ нь сэтгэл зүйн хувьд бие даахын тулд бидний дагах ёстой үйл явцтай яг адилхан. Гэхдээ биднээс бие дааж нисэхийг хараахан шаардах болоогүй байдаг.

Эх шувуу хүүхдүүддээ үүрнээсээ унах боломжийг олгодгийн адил Тэнгэрлэг Эцэг бидэнд өвдөлт, зовлон, урам хугалж болох сорилт бэрхшээл, туршлагыг туулах боломжийг олгодог. Авралын төлөвлөгөө нь биднийг Түүнтэй адилхан болгоход туслах зорилготой тул бидэнд тулгардаг зовлон бэрхшээл бүр сурч, өсөж хөгжих боломжийг олгож болох юм. Эх шувуутай адил зөвхөн Тэнгэрлэг Эцэг бидэнд оюун санаа болон сэтгэл зүйн хувьд эрүүл



болж, үүнийгээ хадгалан авч үлдэхэд тусалж чадах учраас бидэнд тайтгарал, удирдамжийг өгдөг.

Өөрсдийн далавчийг дэвэх нь

Хэдийгээр Тэнгэрлэг Эцэг бидний хамтрагч ч гэлээ, Түүнийг бидний өмнөөс бүх зүйлийг хийнэ хэмээн хүсэн хүлээж болохгүй. Тэрээр биднээс сэтгэл зүйн хувьд бие даасан болох замдаа бидэнд өгсөн сонгох эрх, эх сурвалжийг нь ашиглаасай хэмээн хүсдэг.

Жишээлбэл, сэтгэл шархалж, уурлаж, хайрт нэгнээ алдах үед маань Тэр биднээс Өөрөөс нь зөвлөгөө аваасай хэмээн хүсдэг. Гэхдээ зөвхөн үүгээр зогсохгүй бид Түүний өгсөн удирдамжийн дагуу үйлдэж, зарлигуудыг сахин, амар амгалан, тайтгарал, хариултыг эрэлхийлэхээр ариун сүмд очиж, бошиглолын зөвлөгөөг сонсож, Түүний бидэнд зориулсан төлөвлөгөөнд итгэхийн тулд чадлынхаа хэрээр хичээх ёстой.

Тэнгэрлэг Эцэг бидэнд сэтгэл зүйн хувьд бие даахад туслах олон арга хэрэгслийг өгсөн. Гэвч бид бүхнээ зориулсан ч гарах газаргүй мэт байдалд

орж, сэтгэл зүйн эрүүл мэндийн тал дээрээ асуудалтай хэвээр байвал нэмэлт тусламж авах нь зүйтэй байж болох юм. Урагшлан цаашлахын тулд сэтгэл зүйн эрүүл мэндийн тусламж үзүүлдэг мэргэжилтэнд хандах эсвэл бишопоосоо зөвлөгөө авах хэрэгтэй үе гарч магад.

Гэвч бид саад бэрхшээлтэй тулгарах бүрдээ бусдаас зөвлөгөө авахыг эрэлхийлэх юм бол өөрөө бие даан сурч, өсөж хөгжих боломж бололцоогоо алдаж болох юм. Дахин хэлэхэд, бид урагшлахын тулд өөрсдөө хангалттай хүчин чармайлт гаргах хэрэгтэй.

Их Эзэний загварыг дагах нь

Сургаал ба Гэрээний 9-р хэсэгт Оливер Каудерийг Мормоны Номын ялтаснуудыг “чи [Бурханаас] асуухаас өөрөөр санаа тавиагүй” байж орчуулахыг оролдсон хэмээн зэмлэсэн байдаг (7-р шүлэг). Тэгээд дараа нь түүнд “оюундаа тунгаан бодо[ж]” өөрийн дүгнэлтэд хүрч, “дараа нь энэ нь зөв үү гэдгийг чи [Бурханаас] асуух ёстой” хэмээн зөвлөсөн (8-р шүлэг).

Энэ загварыг дагах үед Тэнгэрлэг Эцэг биднийг сэтгэл зүйн хувьд бие

даахын тулд зөвхөн өөрсдийн чадвар, бодолд найд хэмээн ганцаар орхиогүй. Тэрээр бидэнд сонгох эрхээ хэрхэн ашиглаж суралцах боломжийг олгож байгаа нь тэр юм. Түүний тусламжтайгаар асуултынхаа хариултыг олж, асуудлынхаа шийдвэрийг хайх нь бидэнд эцсийн эцэст Түүнтэй адилхан болоход тусална. Иймээс бид Түүнээс зүгээр л биднийг дээрдүүлээд өг гэж гуйлгүй, харин хэрхэн сэтгэл санааны хувьд илүү тэнцвэртэй болж болох вэ гэж асууж болно.

Бид сэтгэл санааны хувьд соригдох бүрдээ ийнхүү өөрсдийн сонгох эрхийг ахин дахин ашигласнаар аажим аажмаар сайжирч, өөртөө итгэлтэй болж эхэлдэг. Хэдийгээр биднээс нисэхийг хараахан шаардаагүй ч Тэрээр бидэнтэй бүхий л замд хамт байгаад нь итгэж мөн бага багаар сайжрахад тусалж байгаад нь бид баярлаж болно. Өдөр бүр шинэ өндөрлөгт гарах боломж гарч ирдэг бөгөөд энэ нь бие дааж нисэж чаддаг болох тэрхүү өдөрт биднийг бэлддэг юм. ■

Зохиогч нь АНУ-ын Калифорнид амьдардаг.



Арван хоёр
Төлөөлөгчийн
Чуулгын ерөн-
хийлөгчийн
үүрэг гүйцэтгэгч
Ерөнхийлөгч
М.Рассэлл
Баллард

Амьдралын хэрэгцээ шаардлагыг хэрхэн тэнцвэржүүлэх тал дээр санаа зовж буй хүмүүст үнэ цэнтэй байж болох хэдэн зөвлөгөөг би өгөх гэсэн юм.

Амьдралын хэрэгцээ шаардлагыг тэнцвэржүүлэх

8 ЗӨВЛӨГӨӨ

- 1. Нэгдүгээрт, амьдралаа бодож, нэн чухал зүйлсээ тодорхойл.** Цаг зав тогтмол гарган хаашаа явж байгаагаа мөн тийшээ очихын тулд юу хийх хэрэгтэй болохоо байнга тунгаан бод. Бидний үлгэр дуурайл болох Есүс олонтоо “Эзгүй зэлүүд газар уруу явж, залбирдаг” байсан (Лук 5:16). Бид Аврагчтай адил сүнслэг байдлын хувьд өөрсдийгөө сэргээхийн тулд үүнийг үе үе хийж байх хэрэгтэй. Өдөр бүр хийж гүйцэтгэх ажлаа бичиж тэмдэглэ. Өдөр тутмын хуваариа гаргахдаа Их Эзэнтэй байгуулсан ариун гэрээгээ юуны түрүүнд сана.
- 2. Хоёрдугаарт, хүрэх боломжтой богино хугацааны зорилго тавь.** Сайн тэнцвэртэй зорилгуудыг тавь. Тэдгээр нь хэт олон эсвэл хэт цөөхөн мөн хэт өндөр эсвэл хэт доогуур байж болохгүй. Хүрэх боломжтой зорилгоо бичиж тэмдэглэн, хамгийн чухлаас нь эхэлж ажилла. Зорилго тавихдаа бурханлаг удирдамжийг хүсэн залбир.
- 3. Гуравдугаарт, төсвөө ухаалгаар тооцоолсноор өөрийн бодит хэрэгцээг хянаж, амьдралын олон хүсэлтэй**



харьцуулан нарийвчлан тооцоол.

Хэт олон хүн мөн гэр бүлүүд дэндүү их өр зээлэнд орж байна. Мөнгө зээлдүүлэх гэсэн олон таатай саналуудаас болгоомжил. Зээлдэх нь эргүүлэн төлөхөөс хавьгүй амархан. Санхүүгийн хувьд хөл дээрээ зогсоход туслах богино зам гэж үгүй. Санхүүгээ хяналтдаа бүрэн оруулахгүйгээр амьдралаа тэнцвэртэй болгох боломжгүй.

Аравны нэгийн өргөлөө бүрэн төлдөг байхад анхаар.

4. Дөрөвдүгээрт, эхнэр, нөхөр, үр хүүхэд, хамаатан садан, найз нөхөдтэйгөө ойр дотно бай.

Тэд танд амьдралаа тэнцвэртэй байлгахад тань тусална. Нээлттэй, шударга харилцаагаар дамжуулан гэр бүлийнхэн болон найз нөхөдтэйгөө харилцаагаа бэхжүүл.

Үгээ хайраар, эелдэг зөөлөн, сайтар бодож хэлснээр сайн гэрлэлт, гэр бүлийн сайхан харилцаагаа хадгалан авч үлдэх боломжтой. Зэрвэсхэн харах, нүдээ ирмэх, толгой дохих, бие биендээ хүрэх зэрэг нь үгээс хавьгүй их зүйлийг хэлдэг гэдгийг сана. Хошин шогийн мэдрэмжтэй байх, анхааралтай сонсох зэрэг нь сайн харилцаа холбооны амин чухал хэсэг юм.

5. Тавдугаарт, судраас суралц.

Эдгээр нь Их Эзэний Сүнстэй холбогдоход туслах эх сурвалжуудаас хамгийн сайныг нь бидэнд боломжтой

болгодог. Есүс бол Христ хэмээх баттай мэдлэгээ олж авсан арга замын маань нэг бол судраас суралцсан явдал юм. Ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсон Сүмийн гишүүдээс Мормоны Номоос өдөр бүр залбиран байж суралцахыг хүссэн.

6. Зургаадугаарт, бид өдөр тутмын хуваарьтаа унтаж, дасгал хийж, амрах хангалттай цагийг оруулсан байх ёстой.

Ингэснээр бид эрүүл бөгөөд тэнцвэртэй амьдрах боломжтой. Гаднах төрх байдалдаа анхаарах нь нэр хүнд, өөрийгөө хүндлэх байдлыг нэмэгдүүлдэг.

7. Долоодугаарт, долоо хоног бүр гэр бүлийн үдшээ хий.

Гэр бүлүүдийг мөнх амьдрал өөд хөтөлдөг “хаант улсын сургаалыг бие биендээ заах” энэхүү онцгой боломжийг бид алдах ёсгүй (С ба Г 88:77).

Сатан бидний гэрчлэлийг устгахыг үргэлж эрэлхийлдэг ч, биднийг сайн мэдээнээс суралцаж, зарлигуудыг дагах үед түүнд бидний чадавхаас илүү уруу татаж, үймүүлэх хүч байхгүй.

8. Миний хамгийн сүүлд өгөх зөвлөгөө бол байнга залбирч бай.

Та өдөр бүр тогтмол, чин сэтгэлээсээ залбирснаар гаргах зөв шийдвэрээ мэдэх болно. Сүнстэй холбоотой байснаар би амьдралынхаа бүх зүйлийг хавьгүй амархан тэнцвэржүүлж чаддагаа хардаг.

Үүн дээр өөр зөвлөгөөнүүдийг нэмж болно гэдгийг би мэднэ. Гэвч бид хэдхэн

зорилго дээр анхаарлаа төвлөрүүлэх юм бол амьдралын олон шаардлага хэрэгцээг илүү үр дүнтэй зохицуулах чадвартай байх болно гэдэгт би итгэдэг. Аливаа зүйл амьдралд хэт их давамгайлах нь тэнцвэртэй байдлыг алдагдуулдаг гэдгийг бүү март. Үүний адилаар чухалчилж үздэг зүйлс хэт бага байх нь мөн л тэнцвэрийг алдагдуулдаг. “Бүх . . . зүйл мэргэн ухаанд мөн эмх цэгцэнд хийгддэг” (Мозая 4:27) хэмээн хаан Бенжамин зөвлөсөн.

Зүг чиг, зорилгоо тодорхойлохгүй байх нь цаг хугацаа, эрч хүчээ дэмий зүйлд зарцуулан, амьдралынхаа тэнцвэрийг алдагдуулахад хүргэдэг. Бидний гол зорилго бол “үхэшгүй байдал хийгээд мөнх амьдралыг” эрэлхийлэх явдал байх ёстой (Мосе 1:39). Энэ нь бидний зорилго тул бид бодол санаа, мэдрэмж, эрч хүчийг маань хумсалдаг ч уг зорилгод хүрэхэд тус болдоггүй зүйлсээ өөрсдийн амьдралаас яагаад авч хаяж болохгүй гэж?

Зүгээр л өдөр бүр хийж чадах бүх зүйлээ хамгийн сайнаараа хий. Үндсэн чухал зүйлсийг хий. Нэг л мэдэхэд амьдрал тань Тэнгэрлэг Эцэг таныг хайрладаг гэдгийг батлах сүнслэг ойлголтоор дүүрэн байх болно. Аливаа хүн үүнийг мэддэг болох цагт амьдрал нь зорилго, утга учраар дүүрч мөн тэнцвэртэй байлгахад илүү хялбар болдог. ■

1987 оны 4-р сарын Ерөнхий чуулган дээр хэлсэн үгээс.





ЭНЭ ХЭСЭГТ



Хэрэв намайг нүүгээд явчихвал юу болох бол?

Намайг анх энд нүүж ирэхэд салбар маань хоёрхон залуу эмэгтэйтэй байв. Бид найзууд болж, би тэднийг сайн мэддэг болсон юм. Гэвч тэд сүмд явахаа болив.

Нэг удаа би ариун сүмд орохдоо номлолын ерөнхийлөгчтэй тааралдлаа. Би түүнд найзуудынхаа талаар ярьж, Сүмд буцаж ирэхэд нь тэдэнд туслахын тулд юу хийж болох талаар асуув. Тэр надад байгаа газраа үлдэн, хүчтэй байж, тэдний төлөө залбир гэж хэлсэн юм.

Тэр явдлаас хойш удалгүй би нэг охинтой нь тааралдаж, түүнийг харсандаа үнэхээр их баярлаж билээ. Тэр орой би гэртээ эргэж ирэн залбираад, байгаа газраа үлдэж, сүмдээ явж, семинартаа сууж, найзууддаа үлгэр жишээ үзүүлсээр байх хэрэгтэй гэсэн хүчтэй мэдрэмжийг хүлээн авсан юм. Харин намайг тэндээс нүүгээд явчихсан байх үед маань нэг нь эргэж ирэх бол яах вэ? Хэн тэдэнтэй найзалж, эргэж ирэхэд нь туслах вэ? Аливаа зүйлийг хамтдаа хийвэл хөнгөрдөг.

Алёна,

Украин, Харьков муж

52 Аврагчтай адил дөрвөн чухал талаараа өсөж хөгжих нь
Дайян Томас

56 Хүндийг өргөгчийн бат бөх зогсох удирдамж
Куинини Манумуа

58 2019 оны Мючелийн сэдэв: “Хэрэв та нар Намайг хайрладаг бол, Миний тушаалуудыг сахь”
Залуу эмэгтэйчүүд, Залуу эрэгтэйчүүдийн ерөнхий ерөнхийлөгчийн зөвлөлүүд



60 2019 оны Мючелийн уриа дуу: Түүнийг хайрлаваас
Ник Дэй

64 Сүүлчийн үг: Ариун ёслол ба Христтэй илүү адил болох нь
Ахлагч Д.Тодд Кристоффэрсон

АВРАГЧТАЙ АДИЛ

4 чухал талаараа өсөж
хөгжих нь

*Бид Есүс Христийн хэрхэн
өсөж торнисон талаар сайн
мэдэхгүй ч Лук 2:52-т томоо-
хон санааг өгсөн байдаг.*

“Тэгээд би... юу хийх ёстой
гэнээ?”

Би сонссон. Үнэхээр сонссон.
Зааварлагч миний бүсийг шал-
ган, уяагаа яг хэрхэн суллахыг
зааж өгснийхөө дараа миний
нүд рүү эгц ширтэн, “Би чамайг
УНАГААХГҮЙ!” гэж хэллээ.

Яг тэр шийдвэрлэх мөчид би
чичирч, хөлрөн зогсож байлаа.
Мөрөн дээгүүрээ харан, доо-
шоо... бүр доошоо харахдаа
эхний алхмыг хийж,

хавцлаас доош буух хэрэгтэй
гэдгээ би мэдэж байв.

Магадгүй танд надтай тохиолдсон шиг аюулгүй буухад хангалттай сайн бэлтгэгдсэн гэдэгтээ итгэж найдан, хавцлаас доош буух хэрэг гарч байгаагүй байж болох юм. Гэхдээ сүнслэг байдлын хувьд та ийм нөхцөл байдалд орж байсан нь гарцаагүй. Та судраас бие даан суралцаж мөн багш нарыг үнэн сургаал, зарчмуудын талаар гэрчлэхийг сонсож байхдаа ийм байдалд орж байсан. Аврагчтай илүү адилхан болоход туслах арга замаар үйлдэхэд Сүнс таныг урьж байгааг та мэдэрдэг. Та тэр алхмаа хийж, Их Эзэний сайн мэдээнд хэр үнэнч гэдгээ Түүнд харуулах гэж байгаадаа баярлана.

Тэгээд дараа нь та “Би үүнийг хэрхэн хийж болох вэ?” гэж бодно.

Мөн хэдхэн мөчийн өмнө тодорхой, хийх боломжтой мэт санагдаж байсан зүйл тань замхран алга болно. Та сүнслэг байдлын хавцлын ирмэг дээр, хүлээн авсан үнэнийг хэе дагуу үйлдэхэд хэрэгтэй зохих хэрэгсэл буюу бэлтгэл тань хангагдсан эсэхэд эргэлзэн зогсоно.

Есүс Христтэй адилхан болохын тулд та үүнийг хэрхэн *хийх* вэ?

Эхнээс нь эхэл

Аврагч мөнх бус амьдралаа та бидний адил бяцхан хүүхэд болон төрснөөр эхлүүлсэн. Цаг хугацаа өнгөрч, Есүс бидний адил өссөн (Сургаал ба Гэрээ 93:11–17-г үзнэ үү). Тэр алхаж, ярьж, инээж сурсан. Тэр бас ажиллаж, уншиж, бусадтай харилцаж сурсан.

Үнэндээ Их Эзэн хэрхэн “өссөн” талаар Лук 2:52-т “Есүсийн бие болон мэргэн ухаан нь өссөөр байсан бөгөөд Бурханы болон олон түмний тааллыг олжээ” гэж цэдэглэсэн байдаг.

Хэрэв бид Аврагчтай адилхан болохыг хүсвэл Түүний үлгэр жишээг дагах ёстой.

Тиймээс энэ загварыг авч үзэн, Есүс Христтэй хэрхэн адилхан *болох* боломжтой болохыг харцгаая!



Та сүнслэг байдлын хавцлын ирмэг дээр, хүлээн авсан үнэнийг дагуу үйлдэхэд хэрэгтэй зохих хэрэгсэл буюу бэлтгэл тань хангагдсан эсэхэд эргэлзэн зогсоно..

“Мэргэн ухаан нь өссөн”

Бурхан бидний оюун ухаанд дүн шинжилгээ хийх, боловсруулах, хэрэгжүүлэх гайхалтай чадахыг өгсөн. Бодит мэдээлэл, тоо хэмжээ, ур чадвар, үйл явц гээд бидний цуглуулж болох мэдээлэлд хэмжээ хязгаар гэж үгүй!

Гэхдээ бид зөвхөн мэдээлэл биш, харин Аврагчтай адил *мэргэн ухаанаа* өсгөхийг эрэлхийлдэг. Мэргэн ухаан гэдэг нь мэдээллийг зөв ашиглан, сонголтуудаа ойлгож, сайн шийдвэр гаргах чадварыг хэлнэ.

“Мэдлэгийг зүй зохистой ашиглах нь мэргэн ухааныг бүрдүүлдэг” хэмээн Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын

ахлагч Жэймс Э.Талмэйж (1862–1933) заасан.¹ Тэр мөн Аврагчийг мэргэн ухаанаа хэрхэн олж авсан талаар “Тэрээр судалж суралцах замаар мэдлэг эзэмшиж, залбирч, тунгаан бодож, хүчин чармайлт гаргаснаар мэргэн ухаантай болсон юм”² хэмээн тайлбарлажээ. Алма хүү Хиламандаа “Ай, санагтун, хүү минь, мөн насны залууд *мэргэн ухаанд* суралц, тийм ээ, насны залууд Бурханы зарлигуудыг дагаж сурагтун” хэмээн заасан (Алма 37:35 тодруулгыг нэмсэн). Бодоод үз дээ. Итгэх, суралцах, дуулгавартай байх нь бидний мэдлэгтэй болж, мэргэн ухаанаа өсгөн нэмэгдүүлэх чадварыг сайжруулдаг.

МЭРГЭН УХААН

Та мэргэн ухаанд өсөхийн тулд итгэл, дуулгавартай байдлын зарчмуудыг хэрхэн хэрэгжүүлэх вэ? Мэргэн ухаанаар өсөх нь ямар арга замаар танд Есүс Христтэй илүү адилхан болоход туслах вэ?

ИЛҮҮ ИХИЙГ ОЛЖ МЭД.

Тухайлбал: 2 Нифай 9:28–29; Сургаал ба Гэрээ 130:18–19-ийг үзнэ үү.

“Биеэр өсөх”

Нифай том биетэй, хүчирхэг эр байв. Сударт бичигдсэнээр тэр “бие ханхар” байжээ (1 Нифай 2:16). Харин миний бие бол тийм том биш. Нифайн бие миний биеийг бодвол огт өөр ажил хийхэд зориулагдсан байв. Яагаад гэвэл, Их Эзэнд Нифайгаар хийлгэх өөр ажил байсан юм. Нифай усан онгоц барьж, гэр бүлийнхэндээ хоол хүнс олж, аглаг буйдаар аялахад нь тусалж байсан.

Бидний бие махбодод амьдрах, мөнх бус амьдралаас таашаал авахад хэрэгтэй бүх

БИЕ

Бие махбоддоо анхаарал тавих нь сүнсэндээ анхаарал тавихтай хэрхэн холбоотой вэ? Та бие махбоддоо анхаарал тавих арга замаа хэрхэн өөрчилж, сайжруулж болох вэ?

ИЛҮҮ ИХИЙГ ОЛЖ МЭД.

Ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсоны Ерөнхий чуулган дээр хэлсэн “Thanks Be to God” үгийг уншина уу.

зүйл бий. Бурханы бурханлаг загварын дагуу төрсөн нялх хүүхдийн бие цаг хугацаа өнгөрснөөр өсөх боломжтой. Том болсноор бидэнд эрхтэн, гар хөл нэмэгддэггүй. Тэд биеийн маань нэгэн хэсэг болон аль хэдийн өгөгдсөн байдаг. Дахиад угсрах ч шаардлагагүй. Харин Бурханд болон эргэн тойрныхондоо үйлчлэхийн тулд бид биеийн эрүүл мэнддээ анхаарах ёстой.

Бидний бие махбод бол сүнсэнд маань зориулагдан төгс бүтээгдсэн ариун сүм буюу гэр юм (1 Коринт 3:16–17; 6:19–20-ийг үзнэ үү). Ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсон “Таны бие, байгалиас заяасан ямар ч бэлэгтэй байлаа гэсэн, Бурханы гайхамшигт бүтээл юм. Таны бие бол сүнсний тань ариун сүм юм”³ хэмээн заасан байдаг.

Бид мөнх бус оршихуйд байгаа тул бие махбод маань хүнд бэрхшээл, эмгэг согог, өвчин зовиур зэргийг мэдэрч болох ч Тэнгэрлэг Эцэг маань бидний биеийг амьдралд олгогдсон боломж бололцоог амжилттай хийж гүйцэтгэж болохуйц төгс бүтээсэн.

“Бурханы тааллыг олох”

Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Жэффри Р.Холланд “мөнх оршихуйн хамгийн эхний агуу үнэн бол Бурхан биднийг бүх зүрх сэтгэлээрээ, өөрийн бүх хүчин чадал, оюун хийгээд чадлаар хайрладаг явдал юм”⁴ хэмээн заасан.

Тэр танд *хайртай*. Таны хувьд бүтэлгүй өдөр болж байсан ч Тэрээр *таныг* бүх хүчтэй болон сул тал, асуулт болон итгэл найдвартай тань хамт хайрладаг. Тиймээс та хэрхэн “Бурханы таалалд өсөж” болох вэ? Та хариуд нь Түүнийг хайрладаг гэдгээ харуулах хэрэгтэй!

Есүс нэгэн удаа шавь нартаа хандан “Хэрэв та нар Намайг хайрладаг бол, Миний тушаалуудыг сахь” (Иохан 14:15) хэмээн хэлсэн. Таны дуулгавартай байдал Бурханыг хайрлах хайрыг тань харуулдаг. Өдөр тутмын өчүүхэн жижиг үйл ажилд дуулгавартай байх нь таныг ирээдүйд Түүнээс ирэх урилыг хүлээн авч, агуу зүйлсийг хийхэд бэлдэнэ.

БУРХАНЫ ТААЛЛЫГ ОЛОХ

Аврагч Тэнгэрлэг Эцэгийг хайрладаг гэдгээ хэрхэн харуулсан бэ? Энэ нь танд Аврагчийн тухай юу зааж байна вэ? Та Бурханыг хайрладаг гэдгээ харуулахын тулд өнөөдөр ямар зөв шударга үйлдэл хийж болох вэ?

ИЛҮҮ ИХИЙГ ОЛЖ МЭД. ТУХАЙЛБАЛ:

Мозая 2:22-ыг үзнэ үү. “Бид Есүс Христийн талаар суралцах тусмаа Түүнд итгэх улам агуу итгэлийг хөгжүүлж, өөрийн эрхгүй үлгэр жишээг нь дагах хүсэлтэй болж эхэлдэг.”

Жийн Б.Бингам, “Та нарын баяр баясгалан дүүрэн болохын тулд.” 2017 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 80.

“Олон түмний тааллыг олох”

Гайхаж байгаа биз дээ! Олон нийтийн хэрэгсэл дээр хамгийн олон дагагчтай байх нь “олон түмний тааллыг олсон” гэсэн үг *биш* юм.

Есүс бусдад нөлөөлөх өөр арга замыг мөн Өөртөө нөлөөлөх боломжийг хэнд олгох вэ гэдгийг үзүүлсэн. Тэр “сайныг үйлдэж явсан юм, . . . учир нь Бурхан түүнтэй хамт байв” (Үйлс 10:38).

Тэргүүн Зөвлөлийн хоёрдугаар зөвлөх ерөнхийлөгч Хэнри Б.Айринг нэгэн

ИЛҮҮ ИХИЙГ ОЛЖ МЭД:

Аммон Лемонай хаанд
ямар найз байсны
адил найз нь бай. Алма
17:19-18:41-ийг үзнэ үү.

ОЛОН ТҮМНИЙ ТААЛЛЫГ ОЛОХ

Та ямар арга замаар эргэн тойрныхон-
доо илүү сайн найз нь байж болох вэ?
Аврагчийн “сайныг үйлдэж явсан” үлгэр
жишээг дагах нь бусдад үзүүлэх зөв
шударга нөлөөг тань хэрхэн
нэмэгдүүлж болох вэ?

удаа: “Олон жилийн өмнө миний амьдралд сайнаар нөлөөлсөн найзуудаа би одоо ч гэсэн мартдаггүй. Тэд минь халин одсон ч тэдний хайр, үлгэр дуурайл, итгэл гэрчлэл одоо ч гэсэн намайг өргөн дэмждэг”⁵ хэмээн хэлсэн.

Та амьдралд сайнаар нөлөөлдөг найз байснаар өөрийн нөлөөг өсгөн нэмэгдүүлэх боломжтой! *Залуучуудын бат бөх байдлын төлөө* товхимолд “Бусдад жинхэнэ анхаарал тавьж, инээмсэглэж мөн тэдний төлөө санаа тавьдаг гэдгээ мэдүүл. Бүх хүнтэй эелдэг, хүндэтгэлтэй харьцаж, эргэн тойрныхныгоо шүүж, шүүмжлэхээс зайлсхий . . . Ичимхий эсвэл ганцаардмал, онцгой анхаарал шаардлагатай эсвэл нийтэч бус хүмүүстэй нөхөрлөхийн тулд илүү санаачлагатай бай”⁶ хэмээн заадаг.

Чин сэтгэлээсээ биширч, хүндэлдэг буюу *таалдаг* хүмүүсийнхээ талаар бод. Тэд Есүс Христийг сануулах ямар зан чанаруудыг хөгжүүлсэн байна вэ? Найз нөхөд маань сайн байж болох ч бидний хамгийн сайн Найз бол Есүс Христ бөгөөд Түүний үлгэр жишээг бид дагах хүсэлтэй байх ёстой!

Бүх зүйл хоорондоо уялдаа холбоотой

“Есүсийн бие болон мэргэн ухаан нь өссөөр байсан бөгөөд Бурханы болон олон түмний тааллыг олжээ” (Лук 2:52). Та Аврагчийн өссөн загварыг дагахдаа, элементүүд хоорондоо төгс уялдаа холбоотой ажилладаг бөгөөд та Түүнтэй адилхан болох *болно* гэдгийг олж мэднэ. Таны оюун ухаан, бие махбод, сүнс таны сайн сайхны төлөө ажиллах бөгөөд та өөр олон хүний амьдралыг адислан, “[Бурханд] бүхий л зүрх сэтгэл, хүчин чадал, оюун хийгээд чадлаараа түүнд үйлчлэх]” болно! (Сургаал ба Гэрээ 4:2). ■

ЭШЛЭЛҮҮД

1. James E. Talmage, *Articles of Faith*, 12th ed. (1924), 90.
2. James E. Talmage, *Jesus the Christ* (1916), 112.
3. Russell M. Nelson, “We Are Children of God,” *Liahona*, Jan. 1998, 85–4
4. Жэффри Р.Холланд, “Маргааш Эзэн та нарын дунд гайхамшигт зүйлсийг хийх болно,” *2016 оны 4-р сарын Ерөнхий чуулган*, 114.
5. Henry B. Eyring, “True Friends,” *Liahona*, July 2002, 29.
6. Залуучуудын бат бөх байдлын төлөө (товхимол, 2011), 16.



Куинини Манума

Намайг ахлах сургуулийн 9-р ангид байхад дасгалжуулагч надаас хүндийг өргөх багт орохыг хүссэн юм.

“Ммм, үгүй дээ. Миний чадах зүйл биш” гэж би хариулав.

Тэгсэн ч тэр бууж өгсөнгүй. Бүр хэдэн долоо хоногийн турш ятгасан гээч.

Эцэст нь би үзээд алдахаар шийдэв. Түүний зөв байлаа. Хүндийг өргөх надад үнэхээр таалагдав. Би үүнтэй адил зүйлийг өмнө нь өөрийн биеэр огтхон ч хийж байгаагүй тул эхлээд үнэхээр эвгүй байсан. Гэхдээ би дасгал хийх дуртай болсон юм. Надад бас багийнхан маань төдийгүй, тэмцээнд оролцох нь таалагддаг байв. Би бүр амжилт гаргаж эхлэв!

Одоо харин хүндийг өргөх нь амьдралд маань том байр суурь эзлэх болсон юм. Би өдөр бүр хамгийн багадаа 2-3 цаг нуруун дээрээ штангтай суулт хийж, түлхэж, өргөх дасгал хийдэг. (Хэрэв та эдгээр нь юу болохыг мэдэхгүй байвал санаа бүү зов. Би ч гэсэн мэддэггүй байсан.)

Аливаа зүйлтэй адил хүндийг өргөх нь цаг хугацаа, тэвчээр шаарддаг бөгөөд хүнд хэцүү байх үе ч гардаг байв. Аз болоход гэр бүлийнхэн маань, бүр намайг бие хөндүүрлэлээ гэж (байнга) үглэдэг байхад ч үргэлж



ХҮНДИЙГ ӨРГӨГЧИЙН БАТ БӨХ

ЗОГСОХ

миний хажууд байж, урамшуулан дэмждэг. Аав минь намайг дасгалаасаа гэртээ ирэхэд дандаа мөстэй уут бэлдчихсэн, урамшуулах үгс хэлэн угтан авдаг бол харин ээж минь намайг тэмцээнд явуулахын тулд үргэлж золиослол хийдэг.

Хэдэн жилийн өмнө би тэмцээнд оролцохоор АНУ-ын Пенсильвани мужийн Филадельфи рүү явсан юм. Би эх орныхоо өнцөг булан бүрээс ирсэн хүндийг өргөгчидтэй тэмцээнд оролцох болсондоо баярлаж байсан ч гэр бүлээсээ хол байна гэдэгт санаа зовж байлаа. Надад амар байлгахын тулд ээж минь өдөр бүр судрын шүлэг, гүн утгатай захиас явуулж байхаар амлав.

Тэмцээн болохын өмнөх орой хэсэг хүүхдүүд үдэшлэг зохиосон юм. Би ч явах нь зүйтэй гэж бодоод, өрөөнийхөө хүүхэдтэй очиж үзэхээр шийдлээ. Гэвч миний дуртай үдэшлэг шиг биш байсныг би шууд л мэдсэн. Өсвөр насныхан согтууруулах ундаа ууж, тамхи татан, хараалын үгс хэлж, зохисгүй маягаар бүжиглэцгээж байв. Би тэнд байх ёсгүй гэдгээ мэдэж байсан ч өрөөний маань хүүхэд юу гэж хэлэх бол мөн өрсөлдөгчид маань юу гэж бодох бол гэж санаа зовж байлаа.

Гэнэт санаанд минь
“Ариун газруудад зогсогтун та нар”
гэсэн шүлэг орж ирэв.

Энэ нь Сургаал ба Гэрээ 87:8 дахь миний дуртай шүлэг буюу тэр өглөө ээжийн минь илгээсэн шүлгүүдийн нэг байлаа. “Иймийн тул, ариун газруудад зогсогтун та нар, мөн Их Эзэний өдөр ирэх хүртэл бүү шилжин нүүлгэгд; учрыг болгоогтун, энэ нь гэнэт ирэх болой хэмээн Их Эзэн айлдсан билээ. Амен.”

Ээж яагаад тэр шүлгийг яг тэр өдөр надад илгээснийг би мэдэхгүй ч энэ нь амьдралынхаа туршид дуртай байсан шүлгүүдийн минь нэг байв. Би тэр шүлгийг 8 настай байхдаа цээжилсэн ба энэ нь надад зоригтой, дуулгавартай, итгэдэг зүйлийнхээ төлөө зогсохыг ахин дахин сануулдаг байсан юм.

“Ариун газруудад зогсогтун та нар.”

Би өрөөнийхөө хүүхдэд “Би явлаа” гэлээ. Өглөө ээжийнхээ надад илгээсэн судрын шүлгийн талаар түүнд тайлбарлав. “Энэ бол миний зогсох ёстой газар биш” гэж би хэллээ.

Өрөөний минь охин ч гэсэн тэнд байхыг хүсэхгүй байгаагаа надад хэлэв. Түүнд ч гэсэн тавгүй байсан ба ганцаараа гарч яван, бүтэхгүй амьтан гэж харагдахыг хүсэхгүй байсан гэдгээ

хэлэв. Өөрт нь энэ талаар ярьсанд тэр надад баярлаад, бид гарч явсан.

Дараа өглөө нь биднийг гарсны дараахан үдэшлэгт үлдсэн хүүхдүүд баригдаж, согтууруулах ундаа, хар тамхи хэрэглэсэн тул тэмцээнд орох эрхээ хасуулсныг бид мэдлээ.

Ээжийн илгээсэн шүлэг санаанд орж ирээгүйсэн бол би ч гэсэн тэмцээнд орох эрхээ хасуулах байсан байв. Би нэгдүгээр байранд орсон бөгөөд тэмцээнд оролцох боломжтой байсандаа үнэхээр их баярласан. (Ээж минь надад мессеж илгээдэг байсанд би өдөр бүр талархдаг.)

Хүндийг өргөх тэмцээнд ялсан маань зарлиг, тушаалуудыг дагасны шууд адислал байсан нь ойлгомжтой. Гэхдээ Сургаал ба Гэрээ 87:8-д “Хүндийг өргөх тэмцээнд ялахын тулд ариун газруудад зогсогтун” мөн Иохан 14:15-д “Хэрэв та шууд адислагдахыг хүсвэл, Миний тушаалуудыг сахь” гээгүй. Их Эзэн бидэнд хайртай учраас биднийг адисалдаг. Мөн бид Их Эзэнд итгэж найдан, Түүнийг хайрладаг болохоор ариун байж, дуулгавартай байхыг хичээдэг билээ. ■

Зохиогч нь АНУ-ын Калифорнид амьдардаг.



“ХЭРЭВ ТА НАР НАМАЙГ ХАЙРЛАДАГ БОЛ, МИНИЙ ТУШААЛУУДЫГ САХЬ” иохан 14:15



Залуу эмэгтэйчүүдийн ерөнхий ерөнхийлөгч Бонни Х.Кордон эгч (голд), нэгдүгээр зөвлөх Мишэлл Д.Грэйг эгч (зүүн гар талд) болон хоёрдугаар зөвлөх Бэки Крэйвен эгч (баруун гар талд)



Залуу эрэгтэйчүүдийн ерөнхий ерөнхийлөгч Стэфэн В.Өүн (голд); нэгдүгээр зөвлөх Дуглас Д.Холмс ах (зүүн гар талд) болон хоёрдугаар зөвлөх М.Жозэф Брөү ах (баруун гар талд).

ХЭРЭВ ТА НАР НАМАЙГ ХАЙРЛАДАГ БОЛ

Залуу эмэгтэйчүүдийн ерөнхий ерөнхийлөгчийн зөвлөлөөс

Өсвөр үеийнхний 2019 оны уриа үйлдэл хийхэд дуудсан бөгөөд бидний Аврагчийн Өөрийн биеэр өгсөн урилга юм. Та нар бүгдээрээ үүнийг хүлээн авсан уу? Та нар Түүнд хайртай юу? Та нар Түүний гаргасан замаар явахыг хүсэж байна уу?

Аврагч Есүс Христ маань бидний өөрсдөө хийх боломжгүй байсан зүйлийг бидний өмнөөс хийсэн. Харин Тэр үүний хариуд биднээс юу хийхийг хүсдэг вэ? Тэрээр биднээс “түүний Сүнснийг өөрсөдтэйгөө үргэлж хамт байлгаж болохын тулд” (Моронай 4:3-ыг үзнэ үү) зарлигуудыг нь дагахыг хүсдэг.

Зарлигууд нь хайрын бэлэг юм. Аврагч “Хэрэв та нар Намайг хайрладаг бол, Миний тушаалуудыг сахь” хэмээн энгийнээр хэлсэн. Гэхдээ *яагаад?* Яагаад гэвэл, Тэр ТА НАРТ хайртай! Тэр *та нарыг* аз жаргалтай байгаасай гэж хүсдэг. Тэр *та нарын* амьдрал баяр баясгалан, эцэс төгсгөлгүй боломж бололцоогоор дүүрэн байгаасай гэж хүсдэг. Тэр *та нарыг* аюулгүй,

дэлхийн ёс бус зүйлээс хамгаалагдсан байгаасай гэж хүсдэг. Тэр *та нарыг* “хүлээн авах хангалттай зай байхгүй болтол” (3 Нифай 24:10) тийм агуу ихээр адислахыг хүсдэг. Тэр *та нарыг* Түүнд эргэн ирж, Тэнгэрлэг Эцэгийн *бүх* амласан адислалаас хүртээсэй гэж хүсдэг.

Тэнгэрлэг Эцэг Өөрийн хүүхдүүдийг хэчнээн их хайрладгийг үргэлж санаж яваарай. Тэрээр та нарыг төгс хайрладаг. Та нар Түүний зарлиг, тушаалуудыг сахиснаар хайраа харуулж чадна. Та нарын зөв шударга үйлдэл өөрсдөд тань болон эргэн тойрныхонд тань асар их адислалыг авчрах болно.

Бидний бошиглогч, ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсоний хэлснээр: “Та нар Их Эзэний өсвөр үеийнхний армид байх нь бидэнд хэрэгтэй байна. Энэ арми та нараар дутагдаж байна!” Тэр та нарыг *Залуучуудын бат бөх байдлын төлөө* гарын авлага дахь жишгийн дагуу амьдарч, “Есүс Христийн жинхэнэ шавийн адил харагдан, сонсогдож, үйлдэж, хувцаслах” замаар “босож зогсон [мөн] дэлхийнхнээс өөр байхад” урьсан (“Израйлийн найдвар” [өсвөр үеийнхний дэлхий даяарх шууд нэвтрүүлэг, 2018 оны 6-р сарын 3], 8, HopeOfIsrael.lds.org).



Та нар Их Эзэнийг болон Түүний бошиглогчдыг дагахыг эрэлхийлэх үед Ариун Сүнсний хүч та нарыг Бурханы хайраар дүүргэж, Бурханы охид, хөвгүүд хэмээх бурханлаг мөн чанарын тань талаар гэрчлэх болно. Зөв шударга амьдрахыг хичээх үед тэдгээр адислал өсөн нэмэгдэнэ. Их Эзэн болон бошиглогчид та нарт итгэж найддаг. Тэд та нарт хайртай. Та нарыг дуулгавартай байж, зарлиг, тушаалуудыг сахивал асар их итгэл үнэмшил, өөртөө итгэлтэй байдал, амар амгалан ирнэ гэдгийг бид амлаж байна.

МИНИЙ ТУШААЛУУДЫГ САХЬ

*Залуу эрэгтэйчүүдийн ерөнхий
ерөнхийлөгчийн зөвлөл*

Танд хэзээ нэгэн цагт “Би залбирлуудад маань хариулж, намайг адислаасай гэж хүсэж байгаагаа Тэнгэрлэг Эцэгт хэрхэн харуулж болох вэ?” гэсэн бодол төрж байсан уу? Аврагч Есүс Христ “Хэрэв та нар Намайг хайрладаг бол, Миний тушаалуудыг сахь” (Иохан 14:15) хэмээн хэлэхдээ үндсэн зарчмыг өгсөн.

Өөрөөр хэлбэл, бид Тэнгэрлэг Эцэгийн зарлиг, тушаалуудыг

сахиснаар Түүнийг хайрладаг гэдгээ харуулдаг.

Заримдаа хариулт нь бидний хүссэн цагт, хүссэн арга замаар ирдэггүй тул бид бууж өгөх эсвэл дуулгаваргүй байх уруу таталтад орж магадгүй. Гэхдээ биднийг тэвчээртэй байж, сонсох юм бол Их Эзэн Өөрийн цагт, Өөрийн арга замаар хариулах болно. Тэр зөв шударга залбиралд үргэлж хариулдаг. Тэр дуулгавартай байдлыг үргэлж адисалдаг (Мозая 2:21–24-ийг үзнэ үү).

Дэлхийнхэн хайранд үүрэг хариуцлага хамаарагддаггүй гэж заадаг. Гэвч үнэндээ үүний эсрэг байдаг нь үнэн юм. Бурханыг гэх бидний хайр Түүний зарлиг, тушаалуудыг дагах хүсэл, хичээл зүтгэлээс маань харагддаг.

Аврагч “Үнэн та нарыг чөлөөлнө” (Иохан 8:32) хэмээн заасан. Цаашилбал, бошиглогч Алма “ёс бус явдал хэзээ ч аз жаргал байгаагүй” (Алма 41:10) гэж тунхагласан. Мөн бошиглогч Иосеф Смитээр дамжуулан Их Эзэн “Энэ дэлхийн сууринаас өмнө дээр нь бүх адислал тулгуурлагдсан хууль тэнгэрт эргэлт буцалтгүйгээр тогтоогдсон болой—Мөн бид ямар ч адислалыг Бурханаас авлаа гэхэд, энэ нь

тулгуурлагдсан тэрхүү хуульд дуулгавартай байснаар буюу” (Сургаал ба Гэрээ 130:20–21) хэмээн заасан.

Дуулгавартай байснаар аз жаргал, адислал, удирдамжуудыг хүлээн авдаг. Тэнгэрлэг Эцэг таныг хайрладаг болохоор аз жаргалтай, эрх чөлөөтэй байгаасай гэж хүсдэг бөгөөд тийм ч учраас зарлиг тушаалуудыг өгдөг. Бид энэ дэлхийгээс олох боломжгүй тийм амар амгаланг олохын тулд Тэнгэрлэг Эцэгийн хүсэлд өөрсдийгөө нийцүүлэх нь аз жаргалд хүрэх цорын ганц арга зам юм гэдэгт суралцах хэрэгтэй.

Тэнгэрлэг Эцэг таныг мөнхийн аз жаргалыг олоосой хэмээн хүсдэг. Түүний бошиглогчид таныг хэмжээлшгүй их баяр баясгаланг олоосой хэмээн хүсдэг. Бид таныг Аврагчийг дагаснаар олж авсан тэрхүү амар амгаланг олоосой хэмээн хүсдэг. Түүний үзүүлсэн замаар явагтун (“Lord, I Would Follow Thee,” *Hymns*, no. 220-ийг үзнэ үү). Дуулгавартай байхыг сонго. Өөрийн хүслээр дуулгавартай байх нь жинхэнэ эрх чөлөө, аз жаргал руу таныг хөтөлнө. ■



ТҮҮНИЙГ ХАЙРЛАВААС

2019 оны Мючелийн уриа дуу

Үг, аяыг Ник Дэй

Эрч хүчтэй ♩ = 96-108

F Gm Dm B♭

5

1. Хайр бол хэ-лээд өнгө-рөх ү - гээс, Сэт-гэлд тө - рөх мэд - рэм - жээс и - лүү. —
2. Тэр би - дэнд за - мыг маань заас - наар Ач и - вээ-лийг бид хүр - тэх бол - сон. —

5 F Gm Dm

8

— Хайр бол ган-цаард-сан үед би - дэнд Найд-вар өгө-хөөр
— Түү - нийг хайр-лад-гаа ха - руулс - наар, Хэл-сэн ү-гийг нь

8 B♭ F Gm

11

ир - сэн шалт-гаан нь би - лээ. —
дагас - наар Бид үүрд өөрч-лөг - дөнө. — Е - сү-сийн — за-маар алх -

11 Dm B♭ F

© 2018 by Intellectual Reserve, Inc. Бүх эрх хамгаалагдсан.

Энэхүү дууг арилжааны бус зорилгоор сүмд болон гэр бүлийн хэрэгцээнд зориулан олшруулж болно.

Энэ мэдэгдлийг олшруулсан хуудас бүрд оруулна уу.

14

ваас — Түүн шиг хайр - лаж бид чад - на. — Түү-нийг хайр -

Gm Dm Bb

17

ла - даг боло - хоо — бид ха - руул - на. —

F Gm Dm

20

Хөрш-дөө — хо - ёр - гүй сэт - гэ - лээр бид үйл - чил - нэ. Зов -

Bb F Gm7

23

сон нэг-нийг олж о - чоод бид э - нэр - нэ. Зам - на - лаар нь амь-дарч заас-ныг

F Bb F

26

нь дага - на, Түү-нийг хайрла - ваас. — Түү-нийг хайрла - ваас. — Түү-нийг хайрла -

26 Gm⁷ F B^b

29 1. — ваас. — 2. 3. ваас. —

29 F Gm Dm B^b F

34 Coda руу буцна ☉

Түү-нийг хайрла-ваас. — Хайр-ла-ваас, —

34 Gm⁷ Dm⁷ B^b C

38 бүх зүйл өөрч - лөг - дөнө. — Хай - раар Тэр тэт - гэнэ. — Түү - ний өг -

38 Dm B^b F C

42

сөн бүх хай - рыг бид хүр - тэнэ. — Бид бүгд хүр - тэнэ. Хөрш-дөө —

Dm C7

45

— хо - ёр - гүй сэт - гэ - лээр бид үйл - чил - нэ. Зов - сон нэг-нийг олж о - чоод бид

F Gm Dm

48

э - нэр - нэ. Зам - на-лаар нь амь-дарч заас-ныг нь дага - на, Түү-нийг хайрла-ваас —

Bb F Gm Dm

52 D.S. al Coda

Хөрш-дөө

53 CODA rit.

Bb F Gm Dm Bb

rit.



Ариун ёслол ба Христтэй илүү адилхан болох нь

Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын
Ахлагч Д.Тодд Кристоффэрсон



**Ютагийн
Американ Форкт**
1945 оны 1-р сарын 21-нд
төрсөн.

Хуульчаар
ажиллаж байсан



2008 оны 4-р сард
**Арван хоёр
Төлөөлөгчийн
Чуулгын**
гишүүнээр гэмжин
батлагдсан

13 насандаа
ээжийгээ мээс
засал хийлгэсний
гараа
**талх
барьж**
тусалж байсан

1968 онд Кэйтрин
Жэйкобтой
**Солт
Лэйкийн
ариун сүмд**
гэрлэсэн



Тэр коллежид
явах хүртлээ
тусалсаар
байсан



Тэр
**5 хүүхэд
16 ач, зээтэй**



Их Эзэний зоог буюу ариун ёслолын бэлгэдлийн талаар тунгаан бодох сайхан. Талх, ус нь Амийн талх, Амьд ус болох Түүний мах хийгээд цусыг төлөөлдөг (Иохан 4:10-ыг үзнэ үү) бөгөөд биднийг гэтэлгэхийн тулд төлсөн төлөөсийг нь тод томруун сануулдаг. Талхыг хуваахад бид Аврагчийн шархалж бэртсэн бие махбодын өвчин зовиурыг санадаг. Усыг ууж байхдаа бид Гетсеманид болон загалмай дээр урсгасан цус мөн уг цусны ариусгагч хүчийн талаар боддог (Мосе 6:60-ыг үзнэ үү).

Түүний махыг идэж, цусыг уух гэдэг зүйрлэл нь илүү гүн утга учиртай бөгөөд энэ нь Христийн онцлог шинж, зан чанарыг өөрийн болгоно . . . гэсэн утгатай юм. Ариун ёслолын талх, уснаас долоо хоног бүр хүртэж байхдаа Түүний зан чанар, нүгэлгүй амьдралын загварыг өөрсдийн амьдрал, мөн чанарт бүрэн дүүрэн нэгтгэх талаар бодох нь бидэнд тустай. Есүс Өөрөө гэм нүгэлтэй байсан бол бусдын нүглийг цагаатгаж чадахгүй байх байсан. Шударга

ёс Түүнийг хамаарах эрхгүй байсан тул Тэрээр шударга ёсны төлөөсийг бидний өмнөөс Өөрийн биеэр төлж, нигүүлслийг авчирсан билээ. . . .

Аврагчийн махнаас идэж, цуснаас ууна гэдэг нь Христийн зан чанарыг өөрийн болгож, уг зан чанартай таарахгүй аливаа зүйлсийг өөрсдийн амьдралаас зайлуулахыг хэлнэ. Энэ нь наманчлалын илүү өргөн ойлголт бөгөөд өмнөх нүглээсээ татгалзаад зогсохгүй “сэтгэл зүрх, хүсэл эрмэлзлэлээ Бурханд хандуулан” урагш явахыг хэлдэг (Bible Dictionary, “Repentance”-ийг үзнэ үү). Бурхан бидэнд дутагдал, сул талуудыг маань харуулахын зэрэгцээ сул талаа хүчирхэгжүүлэхэд тусална (Ифер 12:27-г үзнэ үү). Хэрэв бид чин сэтгэлээсээ “Надад өөр юу дутагдаж байна вэ?” (Матай 19:20) гэж асуувал Тэр биднийг өөрсдөө олж мэд гээд орхидоггүй бөгөөд биднийг хайрлаж, бидний аз жаргалын төлөө хариултыг нь өгдөг. Тэр бас бидэнд итгэл найдвар өгдөг. ■

2017 оны 10-р сарын Ерөнхий чуулган дээр хэлсэн үгээс.



ХЭРЭВ ТА НАР НАМАЙГ
ХАЙРЛАДАГ БОЛ МИНИЙ
ТУШААЛУУДЫГ САХЬ.
ИОХАН 14:15

ЕСҮС ХРИСТИЙН
ХОЖМЫН ҮЕИЙН
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ

ЗАЛУУЧУУДАД ЗОРИУЛАВ

**АМЬДРАЛД БАЛМАГДАЖ
БАЙНА УУ?**

*Энэ сарын хэсэгт оюун санааны
болон сэтгэл зүйн эрүүл мэндээ
сайжруулах талаар өгүүлнэ.*

42

ИОСЕФ СМИТ
**ИОСЕФ СМИТИЙН
САЙХАН СЭТГЭЛ, ЗАН
ЧАНАРЫН ТУХАЙ
ДУРСАМЖУУД**

28

ӨСВӨР ҮЕИЙНХЭНД
ЗОРИУЛАВ

**ЕСҮС ХРИСТТЭЙ
4 ТАЛААРАА
АДИЛХАН БАЙХ
АРГА ЗАМУУД**

52

2019 ОНЫ
МЮЧЕЛИЙН СЭДЭВ
АВРАГЧИЙН УРИЛГА

58



ЕСҮС ХРИСТИЙН
ХОЖМЫН ҮЕИЙН
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СУМ



MONGOLIAN

Найз



**Хүүхдүүдэд
зориулсан
шинэ хэсгийг
ТА НАРТ!**



Ерөнхийлөгч
Рассэлл М.Нэлсон

Есүсийн талаар суралц

Бурхан бидэнд туслуулахаар Өөрийн Хүү, Есүс Христийг илгээсэн. Та
Бдараах зүйлсийг хийснээр Есүс Христийн хүчийг хүлээн авч чадна. Үүнд:



“Амьд Христ”-ийг судална уу.
Энэ нь бошиглогч,
төлөөлөгчдийн Есүс Христийн
тухай гэрчлэл юм.



Аврагчийн талаар суралц.
Хэдэн жилийн өмнө би судар
дээрх Есүс Христийн талаар
өгүүлсэн *шүлэг бүрийг* уншиж,
доогуур нь зурсан юм. Уншиж
дуусаад, би эхнэртээ “Би өөр
хүн болсон” гэж хэлж билээ.



Босож зогсоод,
бодлоо хэлэн, дэлхийн
хүмүүсээс өөр байхад
бэлэн бай.



Бодол санаа *бүрдээ*
Түүн рүү харагтун
(Сургаал ба Гэрээ 6:36). Ийнхүү
хийх үед эргэлзээ, айдас тань
арилах болно.



**Есүс бол Христ!
Түүний хүчээс
та нарын хүн нэг
бүр хүртэх
боломжтой.**



**Ариун нандин
гэрээнүүд байгуулж,
тэдгээрийг сахь.**

*“Есүс Христийн хүчийг амьдралдаа татан авах нь”
сэдэвт хэлсэн үгээс, 2017 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 25–28.*

МАНАЙ ЦЭЦЭРЛЭГИЙГ УРГУУЛАХАД ТУСЛААРАЙ!

Есүс Христ дэлхий дээр байхдаа бусдад эелдэг сайхан ханддаг байсан. Бид эелдэг байснаар Түүнийг дагадаг.

Цэцэрлэгт өөр өөр ургамал, цэцэгс, ногоо ургадгийн адилаар бид ч гэсэн өөр өөр арга замаар эелдэг байж болно.

Энэ жил бид эелдэг байдлын цэцэрлэгийг ургуулж байна! Хэн нэгэнд эелдэг хандахдаа та үүнийгээ цэцэг, кактус, навч, ногоо тэр ч бүү хэл цэцэрлэгт байдаг хорхой шавжны хэлбэрээр хайчилсан цаасан дээр бичнэ үү. Дараа нь үүнийгээ бидэнд илгээнэ үү. Арын хавтсан дээр хэрхэн илгээхийг тайлбарласан. Эсвэл та эелдэг байдлын өөрийн цэцэрлэгийг бий болгож, үүн дээрээ "ажиллаж байгаа" зургаа бидэнд илгээгээрэй!

Би та нарыг хайрласны адилаар та нар бие биеэ хайрлагтун. Энэ бол миний тушаал.*

*Иохан 15:12

Нигери улсын Осун мужийн Хүүхдийн хэсгийн хүүхдүүд эелдэг байдлын цэцэрлэгт зориулан цэцгүүд хийжээ!



Гэрчлэлийн ургамал

Гэрчлэлтэй байх гэдэг нь үнэндээ юу гэсэн үг вэ?

Сүмийн сэтгүүлүүд
Бодит түүхээс сэдэвлэв
Марисса Дэннис

Элиса Хүүхдийн хэсэг рүү очиж, найз Армандогийнхоо хажууд суулаа.

“Тавтай морилно уу!” гэж Руссо эгч хэлээд, “Дуугаар эхэлцгээе” гэлээ.

Элиса ангийнхантайгаа хамт “Итгэл бяцхан үр адил арчилбал ургана” хэмээн дуулав (*Хүүхдийн дууны ном*, 50).

Руссо эгч цаас, будгийн харандаа тараалаа. “Дуулсан дууныхаа талаар бод доо” гээд, “Итгэлийн үрээ таривал энэ нь гэрчлэл болон ургадаг. Гэрчлэл чинь ургамал байсан бол ямар төрлийн ургамал байх байсныг одоо зураарай” гэж хэлэв.

Элиса цэвэрхэн цаас руугаа ширтлээ. Бусад нь бүгд зурж эхлэв. Элиса Армандогийн зураг руу нүднийхээ булангаар харлаа. Түүний зурсан ургамал олон навчтай шулуун иштэй байв. Энэ нь байрных нь тагтан дээр ургаж байгаа базиликтэй адилхан харагдав. Түүний гэрчлэл яг үүнтэй адилхан харагддаг байх! Тэр будгийн харандаагаа аваад, түүнийхтэй адилхнаар зурлаа.

“Судрынхаа Алма 32-р бүлгийг нээнэ үү” гэж Руссо эгч хэлэв.

Тэд зүрх сэтгэлдээ үр тарин, ургахыг нь мэдрэх тухай уншлаа. Элиса гэрчлэлийнхээ ургамлыг харав. Түүнд гэрчлэл байсан уу? Энэ нь үнэндээ юу гэсэн утгатай үг вэ? Тэр үүний талаар асуухыг хүссэн ч ичиж байв.

Хичээл дуусахад Руссо эгч Элиса руу дөхөж ирлээ. “Анхаарал чинь төвлөрөхгүй байгаа харагдлаа. Бүх юм зүгээр үү?” гэж Руссо эгч асуув.

Элиса өөрийнхөө зураг руу доош харлаа. “Надад гэрчлэл байгаа эсэхийг би мэдэхгүй байна. Энэ нь юу гэсэн утгатайг ч би сайн мэдэхгүй байна” гэв.

Руссо эгч Элиса руу эелдэгхэн инээмсэглэлээ.



“Зүгээр дээ. Итгэл гэж юу болохыг санаж байна уу?” гэхэд нь Элиса толгой дохив. “Харагдахгүй байгаа зүйлдээ итгэхийг хэлдэг биз дээ?” гэхэд

“Яг зөв!” хэмээн Руссо эгч хэлээд, “Чи ямар ямар зүйлд итгэдэг вэ?” гэж асуулаа.

Энэ нь харин амархан асуулт байв. “Би Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христэд итгэдэг. Тэд намайг хайрладаг гэдгийг би мэднэ” гэлээ.

Руссо эгч инээмсэглээд, “Чи сая гэрчлэлээ хуваалцлаа шүү дээ! Гэрчлэл гэдэг нь сайн мэдээний талаар мэддэг зүйлийг чинь хэлдэг юм” гэв.

Элиса энэ тухай бодож үзлээ. “Тийм бол би аль хэдийн гэрчлэлтэй юм байна, тийм үү?” гэж хэлэхэд нь “Тийм!” гэв. Руссо эгч судраа дээш өргөн барив. “Өнөөдөр бидний уншсан зүйлийг санаж байна уу? Сүмд ирэх гэх мэт зүйлийг хийснээр чи үрээ торддог. Тэгвэл гэрчлэл чинь илүү хүчтэй болж өсөн нэмэгдэнэ” гэлээ.

Элисад ойлгосон мэт санагдлаа. “Тийм болохоор бид гэрчлэлээ ургамал болгон зурсан юм байна шүү дээ?”

“Яг тийм. Ургамал бага багаар ургадаг учраас” гэж Руссо эгч хэлээд, “Гэрчлэл ч гэсэн тэдгээртэй яг адилхан. Тэд ихэвчлэн шууд ургачихдаггүй. Харин бага багаар ургадаг” гэв.

Элисад өөрийнх нь зурсан ургамал сайхан санагдлаа. Тэр гэртээ очоод, “Миний гэрчлэлийн ургамал” гэж зургийнхаа хажууд бичив. Тэр зургаа орныхоо дэргэд өлгөлөө. Гэрчлэл нь аль хэдийн өсөж эхэлснийг тэр мэдэж байв. Мөн тэрээр бүр илүү өсгөхийн тулд Есүсийг үргэлжлүүлэн дуулгавартай дагахыг хүсэж байлаа! ●

A vibrant illustration of a young green plant with several large, healthy leaves growing out of a mound of brown soil. A blue watering can with a pink handle is positioned to the right, pouring water onto the plant. The background is a soft, light blue and green gradient. The text is overlaid on the leaves and soil.

ГЭРЧЛЭЛЭЭ ӨСГӨХ НЬ

Гэрчлэл

гэж “Бурхан намайг хайрладаг” эсвэл “Гэр бүлүүд мөнхөд гэдэгт би итгэдэг” гэх мэт үнэн гэдэгт итгэдэг зүйлийг хэлнэ.

Үндэс

нь ургамлыг бат бөх болгодог. Тэнгэрлэг Эцэг, Есүс хоёрыг өдөр бүр санснаар гэрчлэлээ хүчтэй хэвээр хадгалцгаая!

Ургамлыг

ургуулахад нарны гэрэл, ус хэрэгтэй. Судрууд, залбирал болон сүм нь гэрчлэлийн маань ус, гэрэл адил юм.

Хүн бүрийн гэрчлэл ургамлуудтай

адил өөр өөр хурдтай өсдөг. Таны мэдлэг өчүүхэн ч атугай өсөхөд Тэнгэрлэг Эцэг баярладаг.

Итгэлийн үр

Бошиглогч Алма гэрчлэлээ
Хөгжүүлэхийг үр суулгахтай
зүйрлүүлсэн байдаг (Алма 32-ыг
үзнэ үү). Залбирч, судруудаас
уншиж, бусдад туслах үед таны
итгэл өсөн нэмэгдэх болно! Үр
соёолохыг харахын тулд дараах
туршилтыг хийж үзнэ үү.

Танд хэрэгтэй зүйлс:



хуурай
шош
(ямар ч
төрлийнх
байж
болно)




цаасан
алчуур эсвэл
салфетка



ам нь хаагд-
даг, нэвт
гэрэлтдэг
гялгар уут

- 1 Нойтон цаасан алчуур юм уу салфеткийг гялгар уутан дотор хий. Шошгыг дээр нь байрлуулаад, уутын амыг хаа.
- 2 Уутаа нартай газар тавь. Долоо хоногийн дараа шош соёолж эхлэх болно!
- 3 Ургамлыг тэнд нь хэсэг зуур ургуул. Үндэслэсэн байвал ургамлыг хөрсөнд суулгаарай. Усалж, наранд тавин, хэр том ургахыг нь хар!



Ургамлыг тааруул

Хүн бүрийн гэрчлэл өөр өөрөөр өсөн нэмэгддэг. Та ургамал бүрийг сүүдэртэй нь тааруулж чадах уу?



ИТГЭЛ

Үг: Бэтрис Гоф Жаксон
Ая: Майкл Финлинсон Муди

Итгэлтэйгээр ♩ = 80-92

Chords: C G7 C F C

1. Ит - гэл бол ө - дөр бүр нар ман - даж, °гэ - рэлтэ - хийг хэл - нэ.
2. Ит - гэл бол өмнө нь Бур - хан - тай хамт амь - дарс - ныг хэл - нэ.

Chords: Dm G7 C D G7

Ит - гэл бол на - майг залби - рах үед Э - зэн °сонсо - хыг хэл - нэ.
Ит - гэл энэ °амьд - ра - лын да - раа бу - цаж °очи - хыг хэл - нэ.

Chords: Am C F C G7 C

Ит - гэл бяц - хан үр а - дил ар - чил - бал сайн урга - на.
Ит - гэл бол Бур - ханд Хрис - тэд ит - гэх зөв зам °юм аа.

Chords: Am C F C G7 C

Ит - гэл ми - ний зүрх сэт - гэлд бай - хад зө - вийг хий - хийг ури - на.
Ит - гэл минь °Бурха - ныг °сонсо - ход өсд - гийг би үр - гэлж мэ - дэр дэг.

© 2019 Intellectual Reserve, Inc. Энэ дууг хувиараа, арилжааны бус зорилгоор, сүм дээр болон гэр оронд ашиглахын тулд хуулбарлаж болно. Энэ тэмдэглэл хуулбар бүр дээр байх ёстой.

ФИЛИППИНЭЭС ИРСЭН МЭНДЧИЛГЭЭ



Намайг
Паоло гэдэг.


Харин
намайг Марго
гэдэг.



Энэ жил бид
Бурханы хүүхдүүдийн
талаар суралцахаар дэлхийгээр
аялж байна. Бидэнтэй хамт
Филиппинд айлчилна уу.



Филиппинд
ойролцоогоор 100
сая хүн мөн олон
сонирхолтой амьтан
амьдардаг.



Тэнд мөн найман
үндсэн хэлээр
ярьцгаадаг. Энэ
Мормоны Ном гэхэд
себуано хэл дээр
хэвлэгдсэн.



Та сүмд хэрхэн явж очдог вэ? Зарим филиппин гэр бүл
жипнигээр (Филиппинийн чиглэлийн такси) явдаг.



Энэ бол тагалог гэдэг филиппин хэлээр хийгдсэн ЗС бөгж. Бид “зөвийг сонго” гэдгийг *пилин анг тама* гэж хэлдэг.

Эдгээр нь Себу Сити болон Манила дахь ариун сүмүүд юм. Юу гээч? Манилад хоёр дахь ариун сүм баригдаж байгаа! Мөн ариун сүмүүд Урданета болон Кагаян дэ Оро гэсэн өөр хоёр хотод баригдах болно.



Филиппин хүүхдүүд *луксонг тиник* буюу “өргөсөн дээгүүр үсрэх” гэдэг тоглоом тоглодог. Нэг эсвэл хоёр хүүхэд газар суугаад, хөл, гараа дээр дээрээс нь давхарладаг. Дараа нь хүүхдүүд тэдэнд хүрэлгүйгээр дээгүүр нь үсрэхийг хичээдэг.

Бидэнтэй хамт Филиппинээр аялсанд баярлалаа! Дараа уулзацгаая.



Бидний зарим филиппин найзтай танилцана уу.



“Би орой гэр бүлээрээ судраас уншихыг дандаа тэсэн ядан хүлээдэг. Судраас унших болгонд надад сайхан мэдрэмж төрдөг.”
Ланна Д., 10 настай, Филиппинийн Төв Лузон




“Би анх уншиж сурч байхдаа хурдан уншиж чаддаггүй байсандаа сэтгэлээр унадаг байсан. Эцэг эх болон эгч маань надад тусалсан бөгөөд одоо би судраас уншиж байгаадаа баярладаг.”
Акумэн Д., 7 настай, Филиппинийн Төв Лузон

Та Филиппинд төрсөн үү? Бидэнд бичээрэй! Бид таныг сонсохыг хүсэж байна!

НОМЛОЛЫН МӨСӨН ЧИХРИЙН сан

Бодит түүхээс сэдэвлэв
Маккэнна Кларк



*“Есүс түүнд, Миний хоньдыг хариул гэлээ”
(Иохан 21:17).*

Жарэд ээж, аавтайгаа хамт халуун нарнаар сүмээс Жэр рүүгээ алхаж байв. Тэр Хүүхдийн хэсгийнхээ хичээлийн талаар бодлоо. Сонгол муутай тул Жарэд багшийнхаа үзүүлсэн зураг болон самбарт бичсэн үгсэд анхаарлаа онцгойлон хандуулсан байв.

Тэр өдөр Есүс шавь нараасаа номлогч болохыг хүссэн гэдгийг тэд сурсан юм. Жарэд Есүсийн хүссэнээр сайн мэдээг хуваалцахын тулд юу хийж болох талаар бодов. Тэр номлолд үйлчлэх хараахан болоогүй гэдгээ мэдэж байлаа. Гэнэт түүнд гайхалтай санаа

төрөв. Тэр номлолд зориулан мөнгөө цуглуулж эхэлж болно шүү дээ!

Жарэд гэртээ ирээд, Амбэр нэртэй ямааныхаа хажуугаар гүйж өнгөрөн, шууд байшин руугаа орлоо. Тэр том хуванцар сав аваад, дээр нь болгоомжтойгоор нүх гаргаж, гадна талд нь “Номлолын сан” гэж бичив. Дараа нь тэр өрөө рүүгээ ороод, орон доороосоо мөнгөө гаргаж ирлээ. Тэр зооснуудаа нэг нэгээр нь хийв. Гэтэл түүний бүх зоос ёроолыг нь арай хийж л дүүргэж байлаа. Тэр яаж мөнгө олж болох вэ?

Жарэд бодоод л байв. Тэр цонхны цаана хурц гэрэлтэх нарыг харлаа. Филиппинд маш халуун байв.



Жарэд найзуудтайгаа өдөр бүр хичээлийн дараа нар-гил жимсний мөсөн чихэр иддэг байлаа. “Энэ л байна шүү дээ!” гэсэн бодол түүнд төрөв. Тэр мөсөн чихэр хийгээд, сэрүүцэхийг хүссэн хүмүүст зарж болох юм.

Жарэд ээжийгээ олохоор гүйн гарав. “Та мөсөн чихэр яаж хийдгийг надад зааж өгч чадах уу?” гэж Жарэд хуруугаараа дохин үзүүлэв. Тэд гараараа харилцан ярьдаг дохионы хэлийг ашигладаг. Ээж нь ч инээмсэглээд, толгой дохилоо.

Маргааш нь Жарэд ээжтэйгээ зах орж, мөсөн чихрийн орцонд ордог бүх материалыг худалдан авав. Гэртээ ирэнгүүтээ Жарэд том аяга аваад, наргил жимсний сүү, өтгөрүүлсэн сүү, ванилин болон жижиглэсэн наргил жимсийг нийлүүлж холилоо. Жарэд ээжтэйгээ хамт хольцоо цорго ашиглан жижигхэн уутанд савлаад, бүх уугаа хөлдөөгчинд хийв. “Сайн байлаа!” гэж ээж нь дохиогоор хэлэв.

Мөсөн чихрийг хөлдөөхөд нэлээн удаан хугацаа шаардагдав. Харин маргааш нь хичээлийнхээ дараа ирэхэд, бэлэн болсон байлаа! Жарэд сандал дээр гарч зогсоод, хөргөгчний дээрээс цагаан хөргүүр авав. Тэр

ёроолд нь хэдэн алчуур тавьж, мөсөн чихрээ дээрээс нь давхарлан тавилаа. Тэр тэдгээрийг зарахыг тэсэн ядан хүлээж байв.

Жарэд гадагшаа тоостой гудамж руу гүйн гарав. Найзууд нь гараараа хийсэн нисгэдэг цаасан шувуугаар тоглож, төмөр лаазыг углаашаараа цохиж унагаахаар шидэж байх нь тэр.

Тэр замын хажууд ширээгээ байрлуулаад, “Мөсөн чихэр 5 песо” гэсэн тэмдэг тавилаа. Түүний найз Жонэл гүйж ирэн, хөргүүр рүү нь хуруугаараа заав. Тэр Жарэдэд 5 песогийн зоос өгч, тэр ч түүнд мөсөн чихрийг нь өгөөд, гараа харилцан алгадалцаж мэндчиллээ.

Удалгүй Жарэдийн өөр найзууд нь бас л мөсөн чихэр худалдан авахаар ирэв. Хэдэн цагийн дараа ээж нь Жарэдийг оройн хоолоо ид хэмээн дуудахад хэдхэн мөсөн чихэр үлдсэн байлаа.



Жарэд бараг хоосон шахам болсон хөргүүрээ зоостойгоо авав. Нэг халаасандаа тэр аравны нэгийн өргөлдөө өгөх хэдэн зоосоо хийлээ. Харин үлдсэн зоосоо нөгөө халаасандаа хийв. Тэр номлолын сангийн саваа дүүргэхийг тэсэн ядан хүлээж байв.

Гэртээ ирээд, тэр номлолын сангийн зоосоо савны ёроолд байх зооснууд дээрээ нэмж хийлээ. Зөндөө их зай үлдсэн хэвээрээ л байв! Гэсэн ч хэзээ нэгэн цагт номлолд үйлчилнэ гэж бодоход Жарэдийн дотор халуун дулаан мэдрэмж төрөв. Тэр саваа дүүрэх хүртэл өдөр бүр мөсөн чихэр хийж, зарахаар шийдлээ. Есүсийн хүссэнээр номлолд явахын тулд мөнгө хийх нь сайхан санагдав. ●



Зохиогч Филиппинд номлолд үйлчилсэн ба одоо АНУ-ын Виржиниад амьдардаг.



Шинэ Гэрээний уншлагын хүснэгт



Энэ жил та Шинэ Гэрээнээс уншсанаар Есүсийн талаар илүү ихийг сурч мэдэх болно. Долоо хоног бүр та Н14-р хуудсан дээрх шүлгүүдийг уншин, Хүүхдийн хэсгийн хичээлдээ бэлдэж болно. Уншсныхаа дараа зайг өнгийн харандаагаар буд.



ШИНЭ ГЭРЭЭНИЙ УНШЛАГЫН ХҮСНЭГТ

Эдгээр судрыг 2019 оны сургалтын хөтөлбөрт зориулсан долоо хоног бүр унших материалтай тааруулсан болно.

1. Матай 25:1-4, 8-13

2. Лук 1:30-38

3. Лук 2:40-49, 52

4. Иохан 1:1-5

5. Матай 3:11-17

6. Матай 4:1-10

7. Иохан 3:1-5, 14-17

8. Матай 5:14-16

9. Матай 6:5-8

10. Марк 4:35-41

11. Матай 12:6-13

12. Матай 13:1-9

13. Матай 14:22-31

14. Матай 16:13-19

15. Матай 17:14-20

16. Иохан 20:10-18

17. Лук 10:30-37

18. Иохан 10:9-18

19. Лук 17:11-19

20. Марк 10:13-22

21. Матай 21:12-17

22. Матай 25:31-40

23. Иохан 13:33-35

24. Марк 14:22-24

25. Лук 23:32-34, 39-43

26. Иохан 20:24-29

27. Үйлс 9:1-6, 18-20

28. Үйлс 3:1-10

29. Үйлс 12:5-11

30. Үйлс 17:22-31

31. Үйлс 26:12-20

32. Ром 6:3-11

33. Ром 10:13-17

34. 1 Коринт 2:11-14

35. 1 Коринт 13:1-8

36. 1 Коринт 15:13-22

37. 2 Коринт 1:3-7

38. 2 Коринт 9:6-9

39. Галат 6:1-10

40. Ефес 2:4-10

41. Ефес 6:10-18

42. Колоссай 2:2-7

43. 2 Тесалоник 3:7-13

44. 2 Тимот 3:14-17

45. Еврей 1:2-10

46. Еврей 7:1-6

47. Иаков 3:1-10

48. 1 Петр 3:12-18

49. 1 Иохан 5:2-5

50. Илчлэлт 5:1-10

51. Лук 2:4-12

52. Илчлэлт 12:7-11

Бид хэзээ ч, хаана ч, юуны ч төлөө
залбирч болно. Тэнгэрлэг Эцэг миний
залбирлыг сонсож, хариулдаг.



Ерөнхийлөгч Баллардын АНУ-ын Техаст хийсэн айлчлал

Төлөөлөгчид хүмүүст тохинуулж, тэдэнд Есүс Христийн тухай заахаар дэлхий даяар аялдаг.

“Харви” далайн хар шуурга АНУ-ын Техасын Хьюстонд ирэхэд Олон хүний гэр орон үерт автаж, сүйдсэн байлаа. Ерөнхийлөгч М.Рассэлл Баллард тэнд туслахаар нисэж очсон юм!



1

Онгоц газардангуут тэр хоол хүнс, эд зүйлс цуглуулж, Мормон тусламжийн гарын сайн дурынхныг ажилд явуулдаг Сүмийн удирдах төв рүү шууд очсон.



3

Тэр бас тусламж үзүүлж байсан номлогчид болон Сүмийн бусад гишүүнтэй уулзсан юм.



2

Дараа нь тэр олон гэр орон үерт автсан хорооллуудад айлчлан очив. Зарим гудамжийг хаасан байсан тул тэр нэг байшингаас нөгөө байшин руу алхаж очиж байсан юм. Тэр хүмүүсийн үгийг сонсож, Тэнгэрлэг Эцэгийн тэднийг гэх хайраас хуваалцсан.





4

Тэр онцгой цугларалт дээр болон гурван ариун ёслолын цуглаан дээр үг хэлж, Тэнгэрлэг Эцэгийн хайрыг олон хүнтэй хуваалцсан.

5

Ерөнхийлөгч Баллард гэр орон нь эвдэрч сүйдсэн нэгэн настантай уулзаад,

“Би Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн Төлөөлөгчдийн нэг байна... Бид танд хайртай гэдгийг мэдээсэй гэж хүсэж байна. Есүс Христ бас биднийг энд ирүүлэхийг хүссэн тул бид энд ирсэн” гэж хэлсэн юм.



ТОХИНУУЛАХ ГЭЖ ЮУ ГЭСЭН ҮГ ВЭ?

Есүс Христ бусдад тохинуулдаг байсан бөгөөд Түүний төлөөлөгчид ч тийн үйлддэг. Өнөөдөр хүмүүс хэрхэн тохинуулдгийг харуулсан зургуудтай үгсийг тааруул.



Туслах



Сонсох



Адислах



Хуваалцах



Эелдэг байх

Та өнөөдөр хэн нэгэнд хэрхэн тусалж болох вэ?

Хуваалцах ТӨГС ЭРДЭНЭС



Бодит түүхээс сэдэвлэв
Эрик Б.Мердок

Диегогийн багш “Маргааш онцгой
Дөдөр. Бид ‘Харуул, ярь’ үйл ажилла-
гааг хийнэ!” гэхэд

Диего инээмсэглэв. Тэр “Харуул, ярь”
үйл ажиллагаанд дуртай байв. Тэр бас
найзууддаа онцгой зүйл үзүүлэхийг тэсэн
ядан хүлээж байлаа.

Хичээлийнхээ дараа Диего ээждээ таа-
тай мэдээ дуулгав.

“Би юу авч очих вэ?” гэж тэр асуулаа.

“Өөрийн чинь хувьд онцгой ямар нэгэн
зүйл” гэж ээж нь хэлэв.

“Би Лобогоо авч очиж болно шүү дээ!”
гэхэд

“Бид сургууль руу нохой авч очиж
болохгүй гэж бодож байна. Гэхдээ чамд
хуваалцах өөр онцгой эрдэнэсүүд байгаа
шүү дээ” гэж ээж нь хэллээ.

Удалгүй Диего эрдэнэсийн эрэлд гарав.
Тэр чихмэл сармагчин олов. Үүнийг авч
очдог ч юм билүү? Гэсэн ч Диего хайсаар
л байв.





Тэр гал тогооны сандлын араар,
номын тавиурын дээгүүр бас хайлаа.
Тэр яг тохирсон зүйлээ олтол эрлээ
зогсоосонгүй.

Дараа нь тэр орныхоо доогуур харлаа.
Тэр яг тохирсон зүйлээ оллоо!

Диего ээж рүүгээ гүйсээр очив. Тэр
эрдэнэсээ чанга гэгч нь тэвэрлээ.

“Ээжээ, хар даа! Би хамгийн сайн
тохирох зүйлээ оллоо” гэж тэр
хэлэв.

Тэр ээждээ жижигхэн зургийг
дээш нь өргөж үзүүллээ. Энэ нь
бяцхан хүү Есүсийн зураг байв. Зураг

руу харахад Диегод сайхан мэдрэмж төрдөг
байлаа. Тэр бас сургуулийнхаа найзуудад
сайхан мэдрэмж төрөөсэй гэж хүсэж байлаа.

“Наадах чинь ‘Харуул, ярь’-д үзүүлэх үнэ-
хээр онцгой зүйл байна шүү” гэж ээж нь
хэлснээ, “Чи ангийнхандаа Есүсийн талаар
юу гэж хэлэх вэ?” гэж асуув.

“Бүгд аз жаргалтай
байж чадна. Яагаад
гэвэл, Есүс бүгдэд
хайртай” гэж тэр
хэллээ. ●



Есүс суралцаж мөн өссөн

Сүмийн сэтгүүлүүд
Марисса Виддисон

Есүс нялх хүүхэд
болон мэндэлсэн.
Би ч бас нялх
байлаа.



Мариа, Иосеф хоёр
Есүсийг асарч өсгөсөн.
Хэн надад тусалдаг вэ?

Есүс надтай адил өссөн.
Тэрээр *мэргэн ухаанаар*
өсөж байв. Энэ нь Тэр
шинэ зүйлс сурч мэдэж
байсан гэсэн үг юм.





Есүс бие бялдрын хувьд өсөж байв. Энэ нь Түүний бие өсөж том болсон гэсэн үг юм.

Тэр *Бурханы* таалалд өсөж хөгжсөн. Энэ нь Тэрээр Тэнгэрлэг Эцэгийн талаар суралцсан гэсэн үг юм. Тэр залбирч сурсан. Тэр судраас уншдаг байсан.



Есүс *хүмүүсийн* таалалд өсөж хөгжсөн. Энэ нь Тэр шинэ найз нөхөдтэй болсон гэсэн үг юм. Тэр бусдад найрсаг ханддаг байв. Тэр бас гэр бүлдээ тусалдаг байв.



Би өөрийн оюун санаа, бие бялдрыг өсгөн хөгжүүлж чадна.
Би Бурханыг дагахад суралцаж чадна. Би сайн найз байж чадна.
Би Есүстэй адил сайн хүн болж өсөж чадна! ●

Есүсийн бага насны талаар Лук 2:40–52-оос уншина уу.

Би өсөж байна



ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ АПРИЛ СТОТТ

Хүндэт эцэг эхчүүдэд

Бид шинэ *Найз* сэтгүүлийг танилцуулж байгаадаа баяртай байна! Энэ нь таны *Лиахона* сэтгүүлийг дагалдан ирэх болно. Хэрэв гэрт тань хүүхдүүд байхгүй бол та энэ сэтгүүлийг ач зээ, хөршийнхөө хүүхэд, Хүүхдийн хэсгийн ангийн хүүхэдтэй хуваалцаж болно.

Та шинэ *Найз* сэтгүүлээс дараах зүйлийг олж болно. Үүнд:

- 20 гаруй хуудас бүхий түүх, дуу, үйл ажиллагаа
- Будах, зурах, хайчлахад хялбар шинэ цаас
- Тэргүүн Зөвлөлийн захиас
- Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын дэлхий даяарх тохинууллын талаарх түүхүүд
- Дэлхийн өөр өөр улс орны хүүхдүүдийн тухай түүх
- Гэр бүлийн үдэш, гэр бүлээрээ судраас суралцахад зориулсан эх сурвалжууд

Бид дараах зүйлсийн талаарх таны бодол санааг сонсохыг хүсэж байна.

- Шинэ *Найз* сэтгүүлийг ашигласан гэр бүлийн тань туршлага
- Бусадтай үүнийг хуваалцсан тухай таны туршлага
- Сайжруулах санал зэргээ дараах хаягаар ирүүлнэ үү.

New Friend

50 E. North Temple Street, Room 2393

Salt Lake City, UT 84105-3220, USA.

liahona@ldschurch.org

Хүндэтгэсэн,
Найз сэтгүүл



Нуусан Лиахонаг олоорой!

ГАРЧИГ

- H2** Тэргүүн Зөвлөлөөс: Есүсийн талаар суралц
- H4** Гэрчлэлийн ургамал
- H6** Үйл ажиллагаа: Итгэлийн үр
- H7** Дуу хөгжим: Итгэл
- H8** Филиппинээс ирсэн мэндчилгээ!
- H10** Номлолын мөсөн чихрийн сан
- H12** Шинэ Гэрээний уншлагын хүснэгт
- H15** Ухаалаг санаа зурагт хуудас: Залбирал
- H16** Төлөөлөгчид дэлхий даяар: Ерөнхийлөгч Баллардын АНУ-ын Техаст хийсэн айлчлал
- H18** Хуваалцах төгс эрдэнэс
- H20** Есүсийг дагах нь: Есүс суралцаж, өссөн
- H23** Будах хуудас: Би өсөж байна